



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Empowered lives
Resilient nations



ОРХОНЫ ХӨНДИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ
ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР
БУЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭ ЦЭНЭ

2015



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



*Empowered lives
Resilient nations*

**ОРХОНЫ ХӨНДИЙН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ
НЭМЭР БУЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭ ЦЭНЭ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2015 ОН

Уг судалгааны ажлыг НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сангийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд гүйцэтгэв.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНААС

ТАЛАРХАЛ

Судалгааны баг тус судалгааг хийж, энэхүү тайланг боловсруулахад хамтран ажиллаж, туслалцаа үзүүлсэн төрийн болон хувийн байгууллагуудад, тэр дундаа Орхоны Хөндийн Байгалийн Цогцолборт Газрын хамгаалалтын захиргаа, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар, Үндэсний статистикийн хороо, болон Хүнс, хөдөө аж ахуйн яамны хамт олонд гүнээ талархаж байна.

Мөн, 2013 оны 10-р сараас 2014 оны 9-р сар хүртэлх хугацаанд Монгол улсад томилолтоор ажиллах, уулзалт, хурал, худалдан авах ажиллагаа, тоо мэдээ, материал цуглуулах зэрэг ажлыг зохион байгуулахад, мөн ажлын өрөө, тасалгаа, бусад техникийн туслалцаа үзүүлсэн Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт гүн талархал илэрхийлж байна.

ОРХОНЫ ХӨНДИЙН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР БУЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭ ЦЭНЭ

СУДАЛГААНЫ БАГ:

Гончигсумлаагийн Ганзориг

Байгаль орчны эдийн засагч - Үндэсний зөвлөх
Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн
Эдийн Засаг Бизнесийн Сургуулийн багш
ganjaa123@yahoo.com

Марлон Флорес

Эдийн засагч - Олон улсын зөвлөх
Байгаль орчны эдийн засаг, санхүү хариуцсан ахлах зөвлөх
Эколожик Институт, Вашингтон ДиСи хот, АНУ
marlon.flores@eius.org

Эх бэлтгэлийг:

Б.Сарнай

Хэвлэлийн хуудас: 16.5
“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

ISBN: 978-99962-3-945-8



АГУУЛГА

ХУРААНГУЙ	5
1. ОРШИЛ	9
2. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ЭКОСИСТЕМ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ.....	11
3. ОХБЦГ-ЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР БУЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭ ЦЭНЭ	13
3.1 Судалгааны арга зүй	13
3.2 Байгалийн аялал жуулчлал	13
3.3 Усалгаатай газар тариалан.....	19
3.4 Мал аж ахуйн салбар.....	28
3.5 Ундны ус.....	35
3.6 Ойн аж ахуй болон ойн нүүрстөрөгч шингээлт	40
4. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	46
4.1 Дүгнэлт	46
4.2 Зөвлөмж	47
ХАВСРАЛТ 1. Ашигласан материал.....	48
ХАВСРАЛТ 2. Зорилтот салбарын шинжилгээ - ЗСШ (Судалгааны арга зүй).....	49
ХАВСРАЛТ 3. Салбарын тоо мэдээ	51

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БББ	Бизнес Байгаагаараа Байх хувилбар
ЭСҮ	Экосистемийн үйлчилгээ
ЗГ	Монгол Улсын засгийн газар
БКХО	Байгалийн Капиталд Хөрөнгө Оруулах хувилбар
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ТХГНС	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ
БАЖ	Байгалийн аялал жуулчлал
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ОХБЦГ	Орхоны хөндийн байгалийн цогцолборт газар
ТХНУГ	Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар
ЗСШ	Зорилтот салбарын шинжилгээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТХГНСБ төсөл	“Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь” төсөл
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан

ХУРААНГУЙ

Даян дэлхийн байгаль орчны сан болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж буй “Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь (ТХГНСБ)” төсөл (2010-2015) нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд техникийн туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж байна. Энэхүү төслийн зорилго нь Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний санхүүгийн тогтвортой байдал болон түүний удирдлага, зохион байгуулалтын үр дүнг дээшлүүлэх явдал юм. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхээр гурван үндсэн зорилтыг дэвшүүлсэн билээ. Үүнд: (1) Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний тогтвортой санхүүжилт, удирдлага, зохион байгуулалтын бодлого, эрх зүй, институцийн тогтолцоог бэхжүүлэх, (2) Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний удирдлага зохион байгуулалтыг үр дүнтэй болгох зорилгоор институцийн болон албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх, (3) Сонгосон тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн стратегийг үр дүнтэй болгох, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, мөн тогтвортой санхүүжилтийн механизм, шинэлэг хамтын ажиллагааны арга замыг нэвтрүүлэх явдал юм.

Тавьсан зорилгодоо хүрэх, мөн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ (ТХГНС)-ний санхүүжилтийн хэмжээг өсгөх улс төрийн сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд тусгай хамгаалалттай газар нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнийг тооцох нь маш чухал асуудал болоод байна. Энэ ажлын хүрээнд Орхоны Хөндийн Байгалийн Цогцолборт Газар (ОХБЦГ)-ын эдийн засгийн үнэ цэнийг тооцох судалгааг НҮБХХ-ээс хэрэгжүүлж буй ТХГНСБ төслийн захиалгаар хийгдэв.

Энэхүү тайлан нь дөрвөн бүлгээс бүрдэх бөгөөд нэг ба хоёрдугаар бүлэг нь танилцуулга, зорилго, экосистемийн үйлчилгээний үндсэн зарчмын асуудлыг багтаасан болно.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь ТХГН-нийн экосистемийн үйлчилгээний “муу” болон “сайн”

менежментийг хэрэгжүүлснээр зарим эдийн засгийн салбарт гарах “алдагдал” болон “хожоо”-г тооцох, тодорхойлох явдал юм. Тухайн салбарын төрийн болон хувийн байгууллагууд эдийн засаг, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхдээ ойр орчмын ТХГН-нийн экосистемийн менежментэд оруулах хөрөнгө оруулалтыг асуудлыг хамтатган тусгахад тус тайлан дэмжлэг үзүүлэх болно. Мөн, энэхүү тайлангийн нэг дараагийн зорилго бол БОНХАЖЯ-наас ТХГН-нийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, санхүүжилтийн стратегийг дэмжих улс төрийн хүсэл сонирхлыг дээшлүүлэх нийгэм, эдийн засгийн үндэслэлийг бий болгоход оршино.

Энэхүү судалгааг Зорилтот Салбарын Шинжилгээ (ЗСШ)-ний арга зүйгээр хийж гүйцэтгэв. Эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглан ЗСШ-ний арга зүйгээр “Бизнес Байгаагаараа Байх (БББ) хувилбар” хэрэгжиж буй өнөөгийн экосистемийн менежмент буюу түүний үнэ цэнийг “Байгалийн Капиталд Хөрөнгө Оруулах (БКХО) хувилбар”-ын үед хэрэгжих тогтвортой экосистемийн менежмент буюу түүний үнэ цэнэтэй харьцуулан судалдаг. ЗСШ-ний арга зүйгээр БББ хувилбараас БКХО хувилбарт шилжих үеийн эдийн засгийн хожоог (эсвэл алдагдыг) тооцон үнэлдэг. БББ хувилбараар богино хугацааны (Ж.нь: 10-аас доош жилийн) хожоо, хомсдол, доройтолд орж буй экосистемийн үйлчилгээнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, зардал, болон эдийн засгийн үнэ цэнийг үл ойшоосноос үүдэх сөрөг үр дагаврыг авч үздэг. Харин БКХО хувилбарын хувьд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаснаас хүртэх урт хугацааны (10-аас дээш жил) хожоо, түүний үнэ цэнийг авч үздэг. Мөн, БКХО хувилбараар, шийдвэр гаргах үйл явцад экосистемийн үйлчилгээг нөхөн сэргээх замаар экосистемийн бүтээгдэхүүн, үйлчилгээг урт хугацаанд тогтвортой ашиглах асуудлыг авч үздэг. Энэ хувилбар хэрэгжсэнээр экосистемийн тогтвортой байдал хангагдан, улмаар эдийн засгийн салбаруудын үр ашиг урт хугацаанд тогтвортой бий болно.

Гуравдугаар бүлэгт тус тайлангийн хамгийн гол агуулга оршино. ОХБЦГ-ын эдийн засагт оруулж буй хувь нэмэр буюу экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг энэ бүлэгт тодруулан авч үзнэ. БББ ба БКХО хувилбарыг харьцуулан үнэлэхдээ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ, ажил эрхлэлт зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглан тус судалгааг гүйцэтгэв. ЗСШ-ний арга зүйг ашиглан дараах салбаруудыг сонгон судалгаанд авч үзэв. Үүнд: Байгалийн аялал жуулчлал (БАЖ), усалгаатай газар тариалан, мал аж ахуй, ундны ус, ойн аж ахуй.

ОХБЦГ нь жуулчдын хамгийн их очдог газруудын нэг юм. Монгол оронд ирсэн нийт гадаадын жуулчдын 20% нь ОХБЦГ-т байгалийн үзэсгэлэн, түүхийн дурсгалт газруудыг үзэхээр ирдэг. ОХБЦГ нь 2004 онд ЮНЕСКО-гийн дэлхийн өвд бүртгэгдсэн газар билээ.

Энд ирэх жуулчдын тоо цаашид нэмэгдэх хандлагатай байна. 2013 онд ОХБЦГ-т нийтдээ 43,591 жуулчин очсоноос, 17,625 нь гадаадын, 25,966 нь дотоодын жуулчид байв. Сүүлийн жилүүдэд дотоодын жуулчдын тоо гадаадын жуулчдаас өсөх хандлагатай байна, тухайлбал 2006 онд дотоодын жуулчид нийт жуулчдын 46%-нийг эзэлж байсан бол 2013 онд 60%-нийг эзлэх болжээ. ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа (2012)-ны мэдээлснээр 2006 онд нийт 8,560 жуулчин ОХБЦГ-т ирсэн бөгөөд энэ нь 2013 онтой харьцуулахад бараг гурав дахин бага байжээ. БББ хувилбарын хувьд 2013 оны байдлаар ОХБЦГ-ын байгалийн аялал жуулчлалын салбарт оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ 14.9 тэрбум (9.8 сая доллар) төгрөг гэж тооцов. Харин БКХО хувилбараар авч үзвэл жуулчдын үзэх үзвэрийн удирдлага, зохион байгуулалт сайжирч, жуулчдын амралт, зугаалга төлөвлөгөөний дагуу үр дүнтэй хэрэгжсэнээр жуулчдын тоо, тэдний ОХБЦГ-т хоноглох хоногийн тоо өснө гэж үзсэн. БКХО хувилбар хэрэгжвэл, өнөөгийн БАЖ-ын салбарын экосистемийн үйлчилгээний эдийн засгийн 2033 он гэхэд 35.1 тэрбум төгрөг (23 сая доллар) болж өсөх хандлагатай байна.

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээ болон ойр орчмын газар тариалангийн салбар хооронд шууд холбоотой гэж үзэж болно. ТХГН-ийн тухай хуулиар ТХГН-т газар тариалан эрхлэхийг хориглодог ч ОХБЦГ-аас эх (цутгалаа) авдаг, тэндээ хамгаалагддаг ус, мөн тоос хүртээлт зэрэг экосистемийн үйлчилгээг ойр орчмын газар тариалан эрхлэгчид хүртдэг.

Газар тариалангийн салбар нь газар тариалан эрхлэгч өрх болон аж ахуй нэгжүүдэд ажлын байр бий болгодог. 2012 оны байдлаар, ОХБЦГ-тай давхцан оршдог 6 сумын газар тариалангийн салбарт ойролцоогоор 2,000 хүн ажиллаж байв. ОХБЦГ-ын усан хангамж болон тоос хүртээлтийн экосистемийн үйлчилгээгүйгээр эдгээр хүмүүс ажлын байраар хангагдах боломжгүй юм.

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээнээс газар тариалангийн салбарын хүртэж буй үр өгөөж буюу эдийн засгийн үнэ цэнийг бүтээгдэхүүн (хадлан, тэжээл, үр тариа, хүнсний ногоо, жимс) үйлдвэрлэл, ажлын байр бий болгосны үр өгөөжөөр тооцож үзэхэд, 2002 онд 1.4 тэрбум төгрөг (1.25 сая доллар), харин 2012 онд 6.0 тэрбум төгрөг (4.42 сая доллар) - тэй тэнцүү байна.

БББ хувилбар энэ хэвээр үргэлжилбэл экосистемийн салбарын хөгжилд оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнэ нь урт хугацаанд тогтвортой байж чадахгүй. Хэрэв БББ хувилбар үргэлжилбэл 2023-2033 онд БКХО хувилбартай харьцуулснаар 35.9 тэрбум төгрөг (26.4 сая доллар)-ийн цэвэр алдагдал гарна.

ОХБЦГ нь бэлчээрийн экосистемийн үйлчилгээг ТХГН-тай давхцан орших сумдын мал аж ахуйн салбарт үзүүлж, улмаар олон мянган малчид түүний үр өгөөжийг хүртэж байна. 2012 оны байдлаар, ОХБЦГ-тай давхцан орших 6 суманд ойролцоогоор 1 сая гаруй мал бэлчээрлэж байна. Малын тоо 2002 онд 581,300 байсан бөгөөд 2012 он гэхэд 1,073,800 болж нэмэгджээ.

ОХБЦГ-ын 6 сумын мал аж ахуйн салбарын экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг таван хошуу малын мах, арьс, шир, ноос (хонь, тэмээний), ноолуур, сүү (үнээ, ямааны) үйлдвэрлэлээс олсон цэвэр орлогоор тооцов. 2012 оны байдлаар тус салбарын нийт үйлдвэрлэл 57.8 тэрбум төгрөг (42.6 сая доллар) байсан. Үүнээс зардлыг хасаж, үлдсэн цэвэр орлогыг тооцоход 34.1 тэрбум төгрөг (25.1 сая доллар) болж байна. Гэхдээ, бэлчээрийн экосистемийн ядмаг удирдлага, зохион байгуулалт энэ хэвээр байвал мал аж ахуйн салбарын экосистемийн үнэ цэнэ урт хугацаанд тогтвортой байж чадахгүй. Тиймээс, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон эдийн засгийн үнэ цэнийг тогтвортой байлгахын тулд ТХГН-ийн экосистемийн үйлчилгээг дэмжихэд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Хар Хорин сумын мал аж ахуйн салбар бэлчээрийн экосистемийн



үйлчилгээг хамгийн ихээр хүртдэг бөгөөд бусад таван сумтай харьцуулахад нийт МАА-н үйлдвэрлэлийн 23.5%-нийг эзэлж байна.

Мал аж ахуйн салбарын нэг онцлог нь маш олон хүнийг ажлын байраар хангадаг. Үндэсний Статистикийн Хороо (2014b)-ноос гаргасан тоо баримтаас үзэхэд 2012 онд ОХБЦГ-ын 6 сумын мал аж ахуйн салбарт нийт 10,900 хүн ажлын байраар хангагдсан байна.

Ундны усны хувьд, Орхон гол нь Монгол орны усны сав газруудаас газар зүйн байршил, цэнгэг усны нөөцийн эх ундаргын хувьд экологи-эдийн засгийн чухал ач холбогдолтой. Орхон гол нь ОХБЦГ-аар урсан өнгөрөх бөгөөд Туул болон Тамир голуудад цутгадаг. ОХБЦГ-аар урсан өнгөрдөг болон эндээс эх авдаг нийт 219 гол, 36 булаг, 7 рашаан, 15 нуур байдаг. 2012 оны байдлаар, ОХБЦГ-ын 6 сумын нутаг дэвсгэр дээр оршин суудаг 43 орчим мянган хүн амын ундны усны экосистемийн үйлчилгээг хүртсэн бөгөөд тэдний ихэнх нь Өвөрхангай аймгийн Хархорин болон Уянга суманд амьдардаг байна.

ОХБЦГ-аар дайран өнгөрдөг болон эх авдаг ундны усны эдийн засгийн үнэ цэнэ нь 2002 онд 189.1 сая төгрөг (170,300 доллар) байсан бол 2013 онд 421.5 сая төгрөг (276,600 доллар) болж өссөн байна. 2002-2008 оны эдийн засгийн үнийн нийлбэрийг тооцоход 2.8 тэрбум төгрөг (2.03 сая доллар) болж байна. Хужирт ЖЕМ ХХК Өвөрхангай аймгийн Хужирт суманд 2009 оноос хойш үйл ажиллагаа явуулж Улаанбаатарын зах зээлд цэвэр ус нийлүүлэх болсонтой холбоотойгоор тус оноос хойш ОХБЦГ-ын ундны усны эдийн засгийн үнэ цэнэ хурдацтай өссөн. 2013 онд үйлдвэрлэсэн нийт цэвэр усны эдийн засгийн үнэ цэнэ 235.2 сая төгрөг (211.8 мянган доллар) байгаа нь тус оны ОХБЦГ-ын ундны усны нийт үнийн 55.8%-тай тэнцэж байна. Хэрэв энэ газар нутгийг тусгай хамгаалалтанд аваагүй байсан бол ундны усны хүн амд өгч буй экосистемийн үйлчилгээний үр өгөөж ийм өндөр байхгүй байсан.

БББ хувилбар хэрэгжвэл 2013-2025 он хүртэл хугацаанд ундны усны үнэ цэнэ нь БКХО хувилбарын үнэ цэнээс өндөр буюу нийт 1.62 тэрбум төгрөг (1.19 сая доллар)-нийн хожоотой байна. Харин 2026 оноос хойш БББ хувилбар нь БКХО хувилбарын үнэ цэнээс бага болж цаашлаад улам буурах хандлагатай байна. 2026-2033 оны хооронд БББ хувилбарын БКХО хувилбартай харьцуулсан эдийн засгийн алдагдал 1.65 тэрбум төгрөг (1.22 сая доллар) байх төлөвтэй байна.

Харин БКХО хувилбар хэрэгжсэнээр 2033 онд ундны усны эдийн засгийн үнэ цэнэ 560.8 сая төгрөг (412.6 мянган доллар) болохоор байгаа нь 2013 онтой харьцуулахад 1.3 дахин их байна.

ОХБЦГ-ын ойн экосистемийн үйлчилгээ нь мод бэлтгэлийн салбарт үр өгөөжөө өгч байдаг. ОХБЦГ-тай давхцан оршдог Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум нь бусад таван сумтай харьцуулахад ой модны нөөцөөр арвин нутаг юм. Бат-Өлзий сумын газар нутгийн 75% нь ОХБЦГ-ын газар нутагт багтдаг. Тус сум 12.9 сая га ойтой бөгөөд энэ нь Монгол улсын нийт ойн талбайн 0.63% (81,511 га) болж байна. Бат-Өлзий сумын нийт газар нутгийн 31.4% нь ойгоор хүрээлэгдсэн бөгөөд ОХБЦГ-ын 22.3%-нийг ойн сан бүхий газар эзэлдэг.

2010-2013 оны ОХБЦГ-аас бэлтгэсэн ойн модны эдийн засгийн цэвэр үнэ цэнэ нь нийт 219.2 сая төгрөг (161.3 мянган доллар) байна. Ойн модыг түлээ, түлш, барилгын материал хийх, мөн гэрийн мод үйлдвэрлэлд ашиглах замаар орон нутгийн хүмүүс үр өгөөжийг нь хүртдэг. БББ хувилбар энэ хэвээр үргэлжилбэл ойн модны аж ахуйн эдийн засгийн үнэ цэнэ 2013 онд 99.5 сая төгрөг (65.3 мянган доллар) байсан бол 2033 онд 73.5 сая төгрөг (48.2 мянган доллар) болж буурахаар байна.

ОХБЦГ нь шинэсэн ой ихтэй бөгөөд шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлтийн эдийн засгийн үнэ цэнийг тооцож үзлээ. ОХБЦГ-ын нийт ойн сан бүхий талбай нь 151,900 га бөгөөд үүний 135,900 га нь шинэсэн ойн талбай юм. ОХБЦГ-ын шинэсэн ой нь дэлхийн шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлтийн экосистемийн үйлчилгээнд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж буйг нотлох зорилгоор нүүрстөрөгч шингээлтийн үнэ цэнийг тооцсон болно. Учир нь одоохондоо Монголд нүүрстөрөгч шингээсний төлөө өгч буй татаас буюу нүүрстөрөгч шингээлтийн зах зээл хөгжөөгүй байна. Хэдий тийм ч, 2013 онд ОХБЦГ-ын шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлтийн эдийн засгийн үнэ цэнэ нь 2013 онд 1.93 тэрбум төгрөг (1.34 сая доллар) болж байна. БББ хувилбар цаашид үргэлжилбэл шинэсэн ойн нөөц багасаж энэ үнэ цэнэ цаашид буурах төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, ирэх 20 жилийн хугацаанд БББ хувилбар энэ хэвээрээ үргэлжилснээр 11.5 тэрбум төгрөг (7.6 сая доллар)-нийн нүүрстөрөгч шингээх боломжоо алдахаар байна.

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ нь орон нутгийн эдийн засагт томоохон хувь

нэмэр оруулж байна гэж дүгнэж болно. Гэвч, БББ хувилбар цаашид энэ хэвээр хадгалагдвал мал аж ахуй гэх мэт салбар богино хугацаанд өсөх боловч, экосистемийн үйлчилгээ доройтох үед эдийн засгийн үйл ажиллагаа доголдож, эдийн засгийн салбарууд уналтанд орно. БКХО хувилбарыг хэрэгжүүлэх замаар ОХБЦГ-ын тогтвортой менежментийг хэрэгжүүлэх санхүүгийн нөөц дутмаг байдлаас үүдсэн эдийн засгийн алдагдлыг бууруулах боломжтой.

4-р бүлэгт судалгааны үр дүнд гарсан саналыг багтаасан болно. Үүнд:

- ОХБЦГ-ын экосистемийн менежментийг сайжруулахад учирч буй бодлогын алдаа, дутагдал, саад бэрхшээлийг үнэлсний үндсэн дээр ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа, сумын ЗДТГ болон орон нутгийн малчидтай хамтран бэлчээр, усны байгалийн нөөцийн тогтвортой менежментийг төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх, тухайлбал, ОХБЦГ-ын ховор амьтан, ургамлын нөхцөл байдал болон бэлчээрийн даацын үнэлгээнд тулгуурлан бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Сумын засаг даргын тамгын газрууд тогтвортой аялал жуулчлалын стратегийг хувийн хэвшил болон Монгол улсын ТХГН-нийн төрийн байгууллагуудтай хамтран боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Тус стратегид ТХГН-т нэвтрэх хураамжийн бодлогыг сайжруулах,

жуулчдын статистик тоо баримт дээр үндэслэн байгалийн үзмэр, дурсгалт газруудад очих явган хүний зам, хоноглох газрын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг асуудлыг тусгах;

- ОХБЦГ болон суурин газруудад жуулчны мэдээллийн төвүүдийг бий болгох, түүнийг санхүүжүүлэх;
- ОХБЦГ-ын цахим хуудсанд эдийн засгийн нөлөө, санхүүгийн тоо мэдээ зэрэг мэдээллийг Англи болон Монгол хэл дээр оруулах;
- Орон нутгийн санхүүжилтийн механизмуудыг бий болгох замаар аялал жуулчлалын салбарын хөгжлийг дэмжих, нөгөөтэйгүүр аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн татвар төлөлтийг нэмэгдүүлэх;
- Хүн амын ундны усны хэрэгцээнд ашиглаж буй гол, мөрөн, булаг шандны усны чанарыг үнэлэн, усны эх үүсвэрийг хамгаалах бодлогыг тодорхойлох;
- ОХБЦГ-ын ойн нөөцийн хэмжээ болон чанарт хяналт тавих зорилгоор ойн мэдээллийн системийг бусад бүс нутаг болон ТХГН-нийн удирдлагуудтай хамтран бий болгох;
- Дээрх санал, зөвлөмжүүд нь тус тайланд авч үзсэн салбаруудад БББ хувилбарыг БКХО хувилбар болгон өөрчлөхөд шаардагдах жишиг арга хэмжээнүүдийн санал юм.



1. ОРШИЛ

Даян дэлхийн байгаль орчны сан болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж буй “Монгол орны ТХГН-нийн сүлжээг бэхжүүлэх нь (ТХГНСБ)” төсөл (2010-2015) нь Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж байна. Энэхүү төслийн зорилго нь Монгол орны ТХГНС-ний санхүүгийн тогтвортой байдал болон түүний удирдлага, зохион байгуулалтын үр дүнг дээшлүүлэх явдал юм. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхээр гурван үндсэн зорилгыг дэвшүүлсэн. Үүнд:

(1) Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний тогтвортой санхүүжилт, удирдлага, зохион байгуулалтын бодлого, эрх зүй, институцийн тогтолцоог бэхжүүлэх,

(2) Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний удирдлага зохион байгуулалтыг үр дүнтэй болгох зорилгоор институцийн болон албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх,

(3) Сонгосон тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн стратегийг үр дүнтэй болгох, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, мөн тогтвортой санхүүжилтийн механизм, шинэлэг хамтын ажиллагааны арга замыг нэвтрүүлэх явдал юм.

Тавьсан зорилгодоо хүрэх, мөн ТХГНС-ний санхүүжилтийн хэмжээг өсгөх улс төрийн сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд ТХГН-нийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнийг тооцох нь маш чухал асуудал болоод байна. Энэ ажлын хүрээнд Орхоны Хөндийн Байгалийн Цогцолборт Газар (ОХБЦГ)-ын эдийн засгийн үнэ цэнийг тооцох судалгаа хийгдлээ. Энэхүү тайлан нь дөрвөн бүлгээс бүрдэх бөгөөд нэг ба хоёрдугаар бүлэг нь танилцуулга, зорилго, экосистемийн үйлчилгээний үндсэн зарчмын асуудлыг багтаасан болно.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь ТХГН-нийн экосистемийн үйлчилгээний “муу” болон “сайн” менежментийг хэрэгжүүлснээр зарим эдийн засгийн салбарт гарах “алдагдал” болон “хожоо”-г

тооцох, тодорхойлох явдал юм. Тухайн салбарын төрийн болон хувийн байгууллагууд эдийн засаг, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхдээ ойр орчмын ТХГН-нийн экосистемийн менежментэд оруулах хөрөнгө оруулалтыг асуудлыг хамтатган тусгахад тус тайлан дэмжлэг үзүүлэх болно. Мөн, энэхүү тайлангийн нэг дараагийн зорилго бол БОНХАЖЯ-наас ТХГН-нийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, санхүүжилтийн стратегийг дэмжих улс төрийн хүсэл сонирхлыг дээшлүүлэх нийгэм, эдийн засгийн үндэслэлийг бий болгоход оршино.

ОХБЦГ нь унаган байгаль, ургамал, амьтан, экосистем, түүх соёлын дурсгалт газраар баялаг нутаг бөгөөд Их богд, Хангайн уулсын ан амьтны нүүдэллэх замд оршдог. Мөн тус нутагт олон гол мөрөн, булаг шандны усны эх үүсвэр бий. Энд жуулчдын үзэхийг хүсдэг байгалийн үзэмжит газрууд олон байдаг. Тухайлбал, Хүйсийн Найман Нуур, Улаан Цутгалан, Төвхөн хийд, Эрдэнэ зуу хийд гэх мэт. ОХБЦГ-ын хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөө (2010)-нд тусгасан нэг зорилт бол байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал юм.

ОХБЦГ-т VI-VII зууны Түрэгийн үеийн чулуун дурсгалууд, VIII-IX зууны Уйгарын нийслэл Хар балгасын туурь, XVI зуунд бүтээгдсэн Эрдэнэ зуу хийд, Өндөр гэгээн Занабазарын бүтээсэн Төвхөн хийд байдаг. ОХБЦГ нь 2004 онд ЮНЕСКО-гийн дэлхийн өвд бүртгэгдсэн. ОХБЦГ нь дараах бүсүүдэд хуваагддаг.

Үүнд:

Онцгой бүс. Энэ бүсэд ховор буюу биологийн устах аюулд орсон төрөл зүйлийг хамгаалах, байгальд сөрөг нөлөөгүйгээр судалгаа шинжилгээ явуулах, байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаа явагддаг. ОХБЦГ-ын онцгой бүсэд Баян нуур, мөн Тооройт, Шар дов, Хүрэн булуу, Хар хул, Шар булуу гэх мэт уулс, Могойтын рашаан, Хангайн цагаан чулуут, Хангайн овоо, Хамарын даваа, Өвөр гэгээн, Ар цагаан, Улаан даваа, Хятрууны даваа, Баян нуур, 2,3,4-р постууд багтана.

Аялал жуулчлалын бүс. Онцгой болон хязгаарлалтын бүсэд явагддаг үйл ажиллагаа нь аялал жуулчлалын бүсэд явагдах боломжтой. ОХБЦГ-ын аялал жуулчлалын бүсэд Төвхөн уул, Булш толгой, Хүүшийн гозгор уул, Шанага толгой, Хужиртын худаг, Шагшаа худаг, Хадатын худаг, Жаргалантын худаг, Голинханан уул, Голын толгой, Арцат толгой, Өндөр Арцат, Сэнжит уул, Толгойн барилга, Уулын хөтөл, Орхон гол, Хэцүү

толгой, Бэрх багийн төв, Сүүжийн булаг, Бондгор толгод, Мухдагийн худаг, Үүртийн тохой, Цагаан гол, Орхоны хүрхрээ, Шахлага толгой, Яргайт толгой, Улаанхад уул, Худаг уул, Төвхөн уулын орчмын газрууд орно.

Хязгаарлалтын бүс. Онцгой болон хязгаарлалтын бүсэд явагддаг үйл ажиллагаанаас гадна мал бэлчээх, жуулчдын амралтын байр, зам барих зэргийг хязгаарлалтын бүсэд явуулж болно.



2.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, ЭКОСИСТЕМ, ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Биологийн төрөл зүйл хэмээх нэр томъёо нь генээс эхлэн экосистем хүртэлх дэлхий дээр бүх түвшинд оршин буй төрөл бүрийн амьд биет, түүнийг тэтгэх экологийн болон эволюцын үйл явцыг хэлнэ. Биологийн төрөл зүйлд бидний онцгойлон анхаардаг ховор, устах аюулд орсон мөн устаж буй зүйлүүд төдийгүй, бидний тэр бүр сайн мэддэггүй микроб, мөөгөнцөр, сээр нуруугүй амьтад зэрэг бүхий л амьд организм багтдаг. Дэлхийн аль ч хэсэгт биологийн төрөл зүйл маш чухал юм. Таны эргэн тойрон болоод алс газарт амьдарч буй бусад амьтад, тэдний амьдралын орчин нөхцөл нь экосистемийн зохистой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Биологийн төрөл зүйлийг зохистой харьцаанд байлгахад хоол хүнс, ундны ус, түлш, амьдрах газар, эм тариа г.м үндсэн хэрэгцээгээр хангах шаардлагатай. Дэлхийн хүн амын дийлэнх нь өнөөг хүртэл ургамал, амьтдыг эм тарианы голчлох түүхий эд болгон ашиглаж байгаа, тухайлбал, АНУ-д хамгийн түгээмэл хэрэглэгддэг 150 төрлийн эмийн 57 хувь нь биологийн гаралтай.

Экосистем гэдэг нь физикийн амьгүй хүчин зүйлсийг хамруулсан тодорхой газар нутаг дахь бүх ургамал, амьтан, микро организмуудаас бүрдсэн байгалийн нэгж бөгөөд амьдрах орчин нөхцөлтэй адил бүхэлдээ бие даасан нэгж, бие даасан организм юм.

Экосистемээс хүмүүсийн сайн сайхан амьдралд шууд болон шууд бусаар оруулж буй хувь нэмрийг экосистемийн үйлчилгээ гэж хэлнэ (UNEP, 2014). “Экосистемийн бараа, үйлчилгээ” хэмээх ойлголт нь экосистемийн үйлчилгээтэй ойролцоо утгатай¹. Экосистемийн үйлчилгээний талаар олон тодорхойлолт байдаг. Скротер нар (2005)-ын үзэж буйгаар экосистемийн үйлчилгээ гэдэг нь мод, цасан бүрхүүл, хөрсний үржил шимтэй байдал зэрэг байгалийн капиталыг модон эдлэл, өвлийн аялал жуулчлал, тариалангийн талбай гэх мэт хүнд үр өгөөжтэй зүйлс болгон хувиргасныг хэлнэ. Экосистемийн үйлчилгээг байгалиас бүтээгдсэн хүмүүст хэрэгцээтэй үйлчилгээ хэмээн тодорхойлж болно (DEFRA, 2007: 10).

Экосистем нь усан хангамж, тоос хүртээлт, ургамлын үр тархаах, цаг уурын орчлыг зохицуулах,

ус цэвэршүүлэлт, шим тэжээлийн бодисын эргэлт, газар тариалангийн хортон шавжтай тэмцэх зэрэг үйлчилгээг үзүүлдэг².

Экосистемийн үйлчилгээ нь хангамжийн, зохицуулах, дэмжих, соёлын үйлчилгээ хэмээн 4 ангилагддаг (TEEB in Local and Regional Policy and Management, 2012).

Хангамжийн үйлчилгээ гэдэг нь экосистемээс бий болсон материаллаг болон эрчим хүч агуулсан зүйлс юм. Жишээ нь: хоол хүнс, ус, барилгын материал, бусад нөөцүүд г.м,

Зохицуулах үйлчилгээ гэдэг нь экосистемээс зохицуулж буй үйлчилгээг хэлнэ. Жишээлбэл: агаар, хөрсний чанарыг зохицуулах, үерлэх, өвчний тархалтыг зогсоох г.м,

Дэмжих үйлчилгээ нь хүмүүсийн сайн сайхан байдал болон бусад төрлийн экосистемийн үйлчилгээний үндэс суурь болох ба биологийн төрөл зүйлсийн оршин тогтнох буюу амьдрах орчин, орон зайг бүрдүүлдэг;

Соёлын үйлчилгээнд амралт зугаалга, аялал жуулчлал тэр дундаа эко-аялал жуулчлал гэх мэт материаллаг бус үйлчилгээ багтана.

Эдгээр экосистемийн үйлчилгээ нь бүтээмжит салбаруудад зайлшгүй шаардлагатай орц нөөц болох бөгөөд улмаар эдийн засгийн хөгжилд хүргэдэг. Хүснэгт 1-т ОХБЦГ-ын голлох экосистемийн үйлчилгээнүүдийг харуулав.

Хүснэгт 1: ОХБЦГ-ын экосистемийн голлох үйлчилгээнүүд

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээ	Судалгаанд хамрагдсан
Цэвэр ус	•
Тоос хүртээлт	•
Ой мод	•
Бэлчээр(хадлан)	•
Цэвэр усны хангамж (ундны ус)	•
Соёлын	•
Байгалийн спорт: Загасчлах, ан хийх, цанын спорт, явган аялал, байгалийн үзэсгэлэн болон зэрлэг амьтад ажиглах	•


¹ www.teebweb.org

² <http://www.amnh.org/our-research/center-for-biodiversity-conservation/about/what-is-biodiversity>

ОХБЦГ нь амьтан, ургамлын төрөл зүйлээр баялаг бөгөөд тэнд орших Орхон голд олон гол, горхи цутгадаг. Цаг уурын өөрчлөлт, экосистемийн ядмаг менежментийн улмаас Орхоны Хүрхрээний ус татарч байна. Өөрөөр хэлбэл, 1982-2007 оны хооронд Өвөрхангай аймгийн сумдын ойролцоох ихэнх гол мөрний ус (тооцоогоор 71.2% хүртэл) ихээр татарчээ (ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа 2014а).

Байгаль орчинд халтай уул уурхайн үйл ажиллагаа нь Орхон гол зэрэг усны эх үүсвэрүүдийг бохирдуулсаар байгаа юм. Дотоодын аялал жуулчлал нэмэгдэх, хууль бусаар мод бэлтгэх, бэлчээр болон газар тариалангийн даац хэтрүүлэх зэрэг нь ОХБЦГ-ын экосистемийг доройтуулж байна. Газрын зураг 1-т ОХБЦГ-ын байршлыг харуулав.

Газрын зураг 1. ОХБЦГ-ын байршил





3.

ОХБЦГ-ЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР БУЮУ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭ ЦЭНЭ

ОХБЦГ-ын цэвэр ус, бэлчээр, ой модны экосистем нь аялал жуулчлал, усалгаатай газар тариалан, мал аж ахуй, ундны ус, ой мод зэрэг салбаруудад эдийн засгийн хувьд онцгой хувь нэмэр оруулдаг. Өвөрхангай аймгийн Уянга сумын 12,010 га нь ТХГН-т хамаарагдах бөгөөд үүнээс гадна 11,500 га газар Хүйсийн Найман Нуур дурсгалт газарт, харин үлдсэн 510 га нь ОХБЦГ-т ордог. Тиймээс энэхүү судалгаанд ОХБЦГ болон Хүйсийн Найман Нуур дурсгалт газар гэсэн хоёр ТХГН-нийг хамтатган авч үзэв.

3.1 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааг Зорилтот Салбарын Шинжилгээ (ЗСШ)-ний арга зүйгээр хийж гүйцэтгэв. Эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглан ЗСШ-ний арга зүйгээр “Бизнес Байгаагаараа Байх (БББ) хувилбар” хэрэгжиж буй өнөөгийн экосистемийн менежмент буюу түүний үнэ цэнийг “Байгалийн Капиталд Хөрөнгө Оруулах (БКХО) хувилбар”-ын үед хэрэгжих тогтвортой экосистемийн менежмент буюу түүний үнэ цэнэтэй харьцуулан судалдаг. ЗСШ-ний арга зүйгээр БББ хувилбараас БКХО хувилбарт шилжих үеийн эдийн засгийн хожоог (эсвэл алдагдыг) тооцон үнэлдэг. БББ хувилбараар богино хугацааны (Ж.нь: 10-аас доош жилийн) хожоо, хомсдол, доройтолд орж буй экосистемийн үйлчилгээнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, зардал, болон эдийн засгийн үнэ цэнийг үл ойшоосноос үүдэх сөрөг үр дагаврыг авч үздэг. Харин БКХО хувилбарын хувьд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаснаас хүртэх урт хугацааны (10-аас дээш жил) хожоо, түүний үнэ цэнийг авч үздэг. Мөн, БКХО хувилбараар, шийдвэр гаргах үйл явцад экосистемийн үйлчилгээг нөхөн сэргээх замаар экосистемийн бүтээгдэхүүн, үйлчилгээг урт хугацаанд тогтвортой ашиглах асуудлыг авч үздэг. Энэ хувилбар хэрэгжсэнээр экосистемийн тогтвортой байдал хангагдан, улмаар эдийн засгийн салбаруудын үр ашиг урт хугацаанд тогтвортой бий болно.

Зорилтот Салбарын Шинжилгээний арга зүйг олон зорилгоор ашиглаж болно. Тухайлбал, үүнд:

Байгаль орчны “муу” болон “сайн” менежментийг хэрэгжүүлснээр сонгосон эдийн засгийн

салбаруудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд гарах алдагдал болон хожоог судлах,

Экосистемийн үйлчилгээнд нөлөө үзүүлж буй тухайн салбарын үйл ажиллагаа нь ямар эрсдэл дагуулж, боломж олгож байгаа талаар шийдвэр гаргагчид болон бизнес эрхлэгчдэд мэдээлэх,

Төрийн болон хувийн байгууллагад тухайн салбарын стратеги төлөвлөлт, бизнес төлөвлөгөө, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын бодлогод ойр орчмын экосистемийн менежментийн асуудлыг тусгахад дэмжлэг үзүүлэх,


Экосистемийн менежментийг сайжруулах, санхүүжилтийн хэмжээг өсгөх улс төрийн хүсэл зоригийг нэмэгдүүлэхэд шаардлагатай нийгэм, эдийн засгийн үндэслэлээр хангах г.м.

БББ, БКХО хандлагын үнэлэхэд эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашигласан. Тухайлбал, бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ, ажил эрхлэлт болон орлого, төсөвт оруулсан орлого (татвар), гадаад валютын орлого г.м. Судалгааны арга зүйн талаар Хавсралт 2-т дэлгэрэнгүй тайлбарласан болно. ЗСШ-ний арга зүйг дараах салбаруудад ашигласан. Үүнд: Байгалийн аялал жуулчлал, усалгаатай газар тариалан, мал аж ахуй, ундны ус, ойн аж ахуй.

3.2 БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол улсад ирсэн жуулчдын анхаарлыг хамгийн ихээр татдаг газруудын нэг бол ОХБЦГ юм. Гадаадын жуулчдын 20 орчим хувь нь байгалийн үзэсгэлэн, түүхийн дурсгалыг үзэж сонирхохоор ОХБЦГ-т ирдэг ажээ. Үүнд: Орхон голын зүүн хэсгээр Төвхөн уул, Хүүш Гозгор уул, Шанага толгой, Хадатын худаг, Жаргалант худаг, Хана мэт хэлбэртэй голын ханан уул, Голын толгой, Арцат толгой, Сэнжит уул, Толгойн барилга, Өлийн хөтөл, Орхон голын эрэг дагуу Хэцүү толгой, Сүүжийн горхи, Бондгор толгой, Мухдагийн худаг, Үүртийн тохой, Орхоны цутгалан, Онгоцын гүүр, Шахлага толгой, Яргайтын толгой, Улаанхад уул, Худаг уул оршино. 2004 онд Орхоны хөндийг ЮНЕСКО-гийн Дэлхийн Соёлын дурсгалт газарт хэмээн соёлын өвд бүртгэн авчээ.

Фото Зураг: Хүйсийн найман нуур. <http://www.sunpath-mongolia.com/pages/eighth-lakes>



Зурагчин: Д.Должинням <http://whc.unesco.org/en/list/1081/gallery/>



Орхоны Хөндийн Соёлын дурсгалт газар-ЮНЕСКО Дэлхийн соёлын өв

121,967 га талбай бүхий Орхоны хөндий нь Орхон голын эрэг хавийн өргөн уудам тал газрыг хамрах бөгөөд 6-р зууны үеийн археологийн олон дурсгалыг хадгалан үлджээ. 13-14-р зууны үед Монголын эзэнт гүрний нийслэл байсан Хархорум хот Орхоны хөндийд байрлаж байв. Тус хөндийд үлдсэн дурсгал, олдворууд нь нүүдэлчин, мал аж ахуй зонхилсон нийгэм, захиргааны хийгээд шашны төв болон Төв Азийн түүхэн дэх Орхоны хөндийн ач холбогдлыг илтгэн харуулдаг.

ОХБЦГ-т Жуулчны 20 компани үйл ажиллагаа явуулж байгаагаас 12 нь Хархорин, 6 нь Бат-Өлзий, 1 нь Хужирт, 1 нь Хашаат суманд тус тус байрлаж байна. Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд байгалийн аялал жуулчлал ихээхэн ач холбогдолтой. Тухайлбал, гэр жуулчны бааз, гэр буудал, мухлаг, дэлгүүр, цайны газар, ресторан, сувинерийн жижиглэн худалдаа, морь унуулах үйлчилгээний газрууд ажиллуулах замаар орон нутгийн иргэд амьжиргаагаа дээшлүүлдэг. Жишээлбэл: 2012 онд байгуулагдсан 14 өрхөөс бүрдсэн “Тулгын чулуу” нөхөрлөл нь 28 хүний орон тоотой. Өрх бүр жилд 4-6 сая төгрөг(2,600-3,900 доллар)-ийн орлого олж байна³. ОХБЦГ-т зочлох жуулчдын тоо өссөөр байна. График 1-д 2005-2013 оны хооронд ОХБЦГ-т ирсэн жуулчдын тооны өсөлтийг харуулав. ОХБЦГ нь олонд танигдсан аялал жуулчлалын газар болж байна. 2013 онд 43,591 жуулчин ОХБЦГ-т зочилсноос 17,625 нь гадаадын, 25,966 нь дотоодын жуулчид байжээ.

Сүүлийн жилүүдэд дотоодын жуулчдын тоо гадаадын жуулчдаас илүү өсөж байна, тухайлбал, 2006 оны байдлаар дотоодын жуулчид нийт жуулчдын 46%-нийг эзэлж байсан бол 2013 онд 60% болж өссөн байна. ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа(2012)-ны тайланд 2006 онд ОХБЦГ-т 8,560 дотоодын жуулчид зочилж байсан бол энэ тоо 2013 онд 3 дахин өссөн болохыг дурджээ.

Хэдийгээр ОХБЦГ-т зочилж буй жуулчдын тоо өсөж буй нь эдийн засгийн хувьд үр ашигтай боловч байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө мөн нэмэгдсээр байна. ОХБЦГ-т зочилж буй дотоодын жуулчид хогоо ил задгай хаяж байгаа нь хамгаалалтын захиргааны хог хаягдлын менежмент тааруу байгааг харуулж байна. Энэ нь цаашдаа гадаадын жуулчдын тоо буурах шалтгаан болж байна. Иймэрхүү хандлагыг энгийн БББ хувилбарын жишээ гэж хэлж болно. Хүснэгт 2-т байгалийн аялал жуулчлалын БББ болон БКХО хандлагын хэв шинжийг харуулав.

³ “Тулгын Чулуу” нөхөрлөлийн ахлагч Хэнмэдэхийн Чулуунбаттай хийсэн ярилцлага, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, 2014 оны 2-р сарын 9.



ОХБЦГ-ын өвлийн аялал жуулчлал, Хамгаалалтын захиргаа Монголын уулчдын үндэсний холбоотой хамтран “2015 оны ханан мөсний авиралтын улсын аварга шалгаруулах тэмцээн”-ийг Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Орхоны хөндийн БЦГ-ын Хүрхрээ бүсэд амжилттай зохион байгууллаа.


Тэмцээний үеэр Хүрхрээ бүсийн хамгаалалтын горимыг олон нийтэд таниулан сурталчилах, мөрдүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, бүс нутгийн аялал жуулчлалыг өргөжүүлэх зорилгоор хамгаалалтын захиргаанаас ажлын хэсэг гарч 3 хоног ажиллаа.



“RESPECT THE MOUNTAINS” уриатайгаар зохион байгуулагдсан энэ удаагийн арга хэмжээнд 100 гаруй хүн хамрагдаж байгальд ээлтэй,

хариуцлагатай байж бүсийн дэглэмийг мөрдөж оролцлоо.

График 1. ОХБЦГ-т ирсэн жуулчдын тоо



Эх сурвалж: ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2012, 2014b)

Хүснэгт 2. Монгол улсын ОХБЦГ дахь БББ болон БКХО хандлагын хэв шинж (БББ/БКХО)

БББ

- Аялал жуулчлалын ядмаг менежмент нь экосистемийн доройтлын шалтгаан болдог;
- Газрын гадаргуугийн бохирдол: зам, гол, нуурын эрэг, голлох байгалийн үзэсгэлэнт газруудын дагуух хог хаягдал;
- Жуулчдын аюулгүй байдлын хөтөлбөр байдаггүйн улмаас зочлох нь багасдаг;
- Тээврийн хүрэлцээ муу: Галт тэрэг, автобусны маршрут болон явалтын тоо цөөн, замын дэд бүтэц дутмаг, хүн тээврийн үйлчилгээ ба аюулгүй байдал хангалтгүй;
- Зочид буудлын хүрэлцээ, ариун цэврийн байдал муу;
- Мэргэжлийн бус буюу сургалтанд хамрагдаагүй үйлчилгээний ажилчид, хувиараа гэр орноо түрээслэгчид;
- Мэдээллийн төв, тараах материал хомс, онлайн мэдээлэл бага;
- Ус, цахилгааны хүрэлцээгүй;
- ОХБЦГ-ын аялал жуулчлалын дэд бүтэцэд оруулах хөрөнгө оруулалт бага;
- Маркетингийн стратеги, төлөвлөгөө, менежмент, мөн харилцаа холбоо муутай;
- Эрүүл мэндийн үйлчилгээний хангамж дутмаг (эмнэлгийн тоо цөөн, эсвэл хол зайтай);
- Жуулчдын зочлох боломжтой газарт нэгдсэн төлөвлөлтгүйгээр дэд бүтцийг барьж байгуулдаг;
- Тогтвортой аялал жуулчлал (АЖ)-ын бодлого, стратеги дутмаг, АЖ-ын бүтээгдэхүүнүүдийн цогц бус салангид байдал (байгалийн АЖ, адал явалт АЖ, өвлийн АЖ, эрүүл мэндийн АЖ);
- Газар ашиглалт, бүсчлэл нь зохион байгуулалт муутай, заримдаа дүрэм журамгүй;
- ОХБЦГ-т нэвтрэх хураамжийн төлбөр хэт бага;
- Байгалийн үзэсгэлэнт газарт орчин нөхцөл муутай(жим, гарц, гүүр, мэдээлэх тэмдэг байхгүй);
- Аялал жуулчлалын яам, ОХБЦГ-ын захиргаа, орон нутгийн удирдлага, орон нутгийн бусад байгууллагуудын хооронд хамтын ажиллагаа муу;
- Үйлчилгээ үзүүлэх байгууллагууд хязгаарлагдмал (жуулчны компаниуд, баазууд цөөн);
- Үйлчилгээний чанар муу (орон нутгийн зочид буудал, ресторан, айл өрхийн түрээслэдэг байр сууц, тур-операторууд);

БКХО

- Экосистемийн менежмент, газар ашиглалтын асуудлыг шийдсэн тогтвортой аялал жуулчлалын бодлого;
- ОХБЦГ дахь хог хаягдлын хатуу менежмент;
- Жуулчдын аюулгүй байдлыг хангах хөтөлбөр, төлөвлөгөөтэй;
- Жуулчлалын гол газруудад хүрэх боломж сайтай, тухтай, аюулгүй дэд бүтэцтэй;
- Аяллын гол маршрутуудад гадаадын жуулчдад тохиромжтой дэд бүтцийг байгуулах;
- Мэргэжлийн буюу сургалтанд хамрагдсан ажилчид, зохион байгуулалттай гэр орноо түрээслэгчид;
- Тохиромжтой байршилд мэдээллийн төвүүдийг байгуулж, тараах материалаар хангах;
- Онлайн мэдээллийг чанаржуулж, дэлгэрэнгүй болгох (Англи болон бусад хэлээр);
- Жуулчны улиралд тог, ус тасрах явдлыг зохицуулсан бодлого, стратеги, зохион байгуулалт, төлөвлөгөөтэй;
- Улсаас ОХБЦГ-т шаардлагатай наад захын зардлыг санхүүжүүлдэг (дэд бүтэц г.м);
- Аялал жуулчлалын яамтай хамтран маркетинг, харилцаа холбооны стратегийг тодорхойлох;
- Голлох байршлуудад эрүүл мэндийн үйлчилгээний нөхцөл, хүртээмжийг сайжруулах (эмнэлгүүд);
- ОХБЦГ доторхи газар ашиглалтын бодлого нь дэд бүтцийн төлөвлөлт, стратегитай уялдаатай хэрэгждэг(орон сууц барих г.м);
- Тогтвортой АЖ-ын стратеги нь хувийн ААН-үүдтэй нягт уялдаатай, хамтран боловсруулагдан хэрэгждэг;
- ТХГН-т нэвтрэх хураамжын систем сайн хөгжсөн, захиалгын системд шилжсэн;
- Байгалийн үзэсгэлэнт газар луу нэвтрэхэд хялбар (Жим, гарц, гүүр, мэдээллийн самбар хүрэлцээтэй байх);



ОХБЦГ-ын экосистемийн аялал жуулчлалын салбарт үзүүлэх эдийн засгийн үр ашгийг ОХБЦГ-т зочилсон жуулчдын тоог тэдний дундаж зардлаар үржүүлэх замаар тооцсон болно. Гадаадын болон

дотоодын жуулчдын дундаж зардлыг ОХБЦГ-ын захиргаанаас тооцон гаргасан байдаг (2014b). Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. ОХБЦГ-т зочилсон жуулчдын зардал


	Мөр дугаар	Жуулчны төрөл	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Нэг хүний нэг шөнө хоноглох буудал/ гэрийн дундаж зардал (мян.Төг)	А	Гадаад	20.0	20.0	25.0	25.0	30.0	30.0	35.0	35.0
		Дотоод	20.0	20.0	20.0	20.0	25.0	25.0	30.0	35.0
Нэг хүний нэг өдрийн хоол хүнсний дундаж зардал (мян.Төг)	В	Гадаад	15.0	15.0	15.0	15.0	21.0	21.0	25.0	25.0
		Дотоод	15.0	15.0	15.0	15.0	18.0	18.0	25.0	25.0
Нэг хүний нэг өдөрт аялал жуулчлалын үзвэр, үйлчилгээнд зарцуулсан дундаж зардал (мян.Төг)	С	Гадаад	12.0	12.0	12.0	12.0	20.0	20.0	20.0	20.0
		Дотоод	10.0	10.0	1.0	10.0	12.0	12.0	15.0	15.0
Нэг хүний нэг өдөрт зарцуулсан нийт дундаж зардал (мян.Төг)	D=A+B+C	Гадаад	47.0	47.0	52.0	52.0	71.0	71.0	80.0	80.0
		Дотоод	45.0	45.0	36.0	45.0	55.0	55.0	70.0	75.0
Нэг хүний ОХБЦГ-т өнгөрүүлэх дундаж өдрийн тоо	Е	Гадаад	2	2	3	3	3	3	3	3
		Дотоод	3	3	3	4	4	5	5	5
Нэвтрэх хураамж, тээврийн зардлаас бусад нийт зардал (мян.Төг)	F=D x E	Гадаад	94.0	94.0	156.0	156.0	213.0	213.0	240.0	240.0
		Дотоод	135.0	135.0	108.0	180.0	220.0	275.0	350.0	375.0
Нэг хүний ОХБЦГ-т ирж, буцах тээврийн дундаж зардал (мян.Төг)	G	Гадаад	215.0	215.0	215.0	260.0	320.0	375.0	470.0	470.0
		Дотоод	35.0	40.0	40.0	50.0	70.0	80.0	100.0	100.0
Нэг хүний ОХБЦГ-т нэвтрэх хураамжийн дундаж зардал (мян.Төг)	H	Гадаад	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0	3.0
		Дотоод	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3
Нэг хүний ОХБЦГ-т зочлох дундаж зардал (мян.Төг)	I=F+G+H	Гадаад	312.0	312.0	374.0	419.0	536.0	591.0	713.0	713.0
		Дотоод	170.3	175.3	148.3	230.3	290.3	355.3	450.3	475.3

Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргааны мэдээлэл (2014b)

ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014b)-наас ирүүлсэн мэдээллийн дагуу 2013 онд гадаадын нэг жуулчин ОХБЦГ-т дунджаар 3 хонож, 713 мянган төгрөг (467.9 доллар) зарцуулдаг байна. Үүнд зочид буудал, хоол хүнс, нэвтрэх хураамж, үйлчилгээний хөлс, тээврийн зардал багтаж байна. Дотоодын жуулчдын хувьд тус оны байдлаар ОХБЦГ-т дунджаар 5 хонож, 475,3 мянган төгрөг

(311.9 доллар)-ийн зардал гаргажээ. Дотоодын жуулчид гадаадын жуулчдаас бага зардал гаргаж байгаа ч тэдний аяллын хугацаа урт байна. Нийт орлогын 60 хувь цэвэр ашиг болж, 40 хувь нь үйл ажиллагааны зардалтай тэнцүү гэж хийсвэрлэв. 2006-2013 оны хооронд ОХБЦГ-ын аялал жуулчлалын салбарт оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнийг График 2-т харуулав.

График 2. ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний байгалийн аялал жуулчлалын салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнэ (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо

Аялал жуулчлалын салбарын нийт орлогыг тооцохдоо ОХБЦГ-т зочилсон дотоодын болон гадаадын жуулчдын тоог тэдний дундаж зардлаар үржүүлсэн. ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний аялал жуулчлалын салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнийг тооцохдоо нийт орлогыг ашгийн хувь буюу 60%-иар үржүүлсэн болно. Ингэснээр, ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний аялал жуулчлалын салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнэ нь 2013 онд 14.9 тэрбум төгрөг байгаа нь 2006 оныхоос 3.7 дахин өссөн үзүүлэлт юм.

ОХБЦГ өнөөгийн нөхцөл байдал БББ хувилбараар явж байгаа гэж үзэн дээрх үнэ цэнийг БББ хувилбараар тооцсон үнэ цэнэ гэж хэлж болох бөгөөд үүнийг БКХО хувилбартай харьцуулан авч үзэв.


БББ хувилбараар ОХБЦГ-ын аялал жуулчлалын өнөөгийн менежмент үргэлжилнэ гэвэл жуулчдын тоо, ялангуяа дотоодын жуулчдын тоо өсөж, бохирдол болон экосистемийн доройтол ихсэн аялал жуулчлалын салбарын өсөлт удааширч, цаашлаад уналтанд орж эхэлнэ.

2006-2013 оны хооронд аялал жуулчлалын салбарын үнэ цэнийн өсөлт дунджаар 21.1% байсан боловч дэд бүтэц, экосистемийн үйлчилгээг дэмжих, хамгаалахад шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалт хангалтгүй хэвээр байвал энэ өсөлт цаашид тогтвортой хадгалагдахгүй. Гэхдээ энэхүүж дундаж өсөлтийн хурд (жилд 2.2%-иар буурна гэж үзвэл) удааширсаар БББ хувилбарын үеийн үнэ цэнэ 2024 он хүртэл хамгийн өндөр түвшинд хүрээд эргээд буурна, учир нь өсөлтийн хурд энэ үеэс эхлэн сөрөг утгатай болж ирэх ба дараа дараачийн жилүүдэд улам хурдан доошлохоор байна.

БББ хувилбар хэрэгжсэнээр, 2014-2024 оны хооронд аялал жуулчлалын салбар 48.8 тэрбум төгрөг (32 сая доллар)-ийн хожоотой байх боломжтой. Гэвч 2025 оноос эхлэн алдагдал үүсч байна. 2025-2033 оны хооронд БББ хувилбарын нийт алдагдал 134.2 тэрбум төгрөг (доллар 88 сая) байна. 2014-2033 оны хоорондох цэвэр алдагдал График 3-т үзүүлснээр 85.4 тэрбум төгрөг (56 сая доллар) байх төлөвтэй байна.



График 3. ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний байгалийн аялал жуулчлалын салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнийн хандлага



Монгол улсын Засгийн газар болон ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа экосистемийн менежмент, тогтвортой аялал жуулчлалд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлбэл салбарын экосистемээс хүртэх үр өгөөж илүү тогтвортой байх юм. БКХО хувилбараар сайтар зохион байгуулагдсан байгалийн үзмэр, төлөвлөгөөт аялал жуулчлал хөгжин улмаар ОХБЦГ-т зочлох жуулчдын тоо болон тэдний энд өнгөрүүлэх хоногийн тоог нэмэгдэнэ. БКХО хувилбараар, ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний байгалийн аялал жуулчлалын салбарт оруулах хувь нэмэр буюу үнэ цэнэ 2033 онд 35.1 тэрбум төгрөгт (23 сая доллар) хүрэхээр байна. 2025 он хүртэл үнэ цэнэ нь өссөөр байх бөгөөд үүнээс хойш энэ үнэ цэнэ тогтворжин тогвортой аялал жуулчлалд хүрнэ. БКХО хувилбараар хийсэн тооцооны дагуу ОХБЦГ-ын үнэ цэнэ 2022 онд 35.1 тэрбум төгрөг болж хамгийн өндөр түвшиндээ хүрнэ. Энэ нь аялал жуулчлалын салбар ОХБЦГ-аас авах үр өгөөжийн хамгийн дээд хэмжээ (даац) бөгөөд энэ хэмжээ цаашид хадгалагдана.

3.3 УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАН

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээ болон усалгаатай газар тариалан хоорондоо шууд хамааралтай юм. Хэдийгээр БЦГ-д газар тариалан эрхлэх эрх зүйн боломжгүй ч ойр орчмын газар тариалангийн салбар ОХБЦГ-т бүрэлдэн хадгалагдаж байдаг экосистемийн үйлчилгээний

ачаар ашиг орлого олж байна (Монгол Улсын Их Хурал, 1994). Түүхэн үүднээс авч үзвэл, ОХБЦГ нь социализмын үед газар тариалангийн онцгой ач холбогдол бүхий бүс нутаг байжээ. Түүнчлэн тус газар нь үржил шим сайтай Хангайн бүсэд багтах бөгөөд газар тариалан эрхлэхэд маш тохиромжтой газар юм. Гэвч сүүлийн 30 жилд газар байгаль орчинд халтай тариалангийн үйл ажиллагаа явагдсаны улмаас ОХБЦГ-ын хөрсний үржил шим муудаж, салхины эвдрэлд орж байна. ОХБЦГ-давхцан орших бусад 5 сумтай харьцуулахад, Өвөрхангай аймгийн Хархорин сум нь жил бүр дунджаар 18.9 мянган га талбайд тариалалт хийдгээрээ хамгийн ихэд тооцогдож байна. (Өвөрхангай аймгийн ЗДТГ, 2013). Сумын захиргаанаас мэдэгдсэнээр тус суманд 12 компани орон нутгийн 500 хүнийг, 332 айл өрх 700 хүнийг байнгын ажлын байраар хангаж, усалгаатай газар тариалан эрхэлж байна⁴. Жишээ нь: Монголын чацарганы томоохон үйлдвэрүүдийн нэг болох “Хархорин ХХК” 2005 оноос хойш 500 га газар чацаргана тарьж байна (Өвөрхангай аймгийн Аж үйлдвэр, ХАА-н хэлтэс, 2014). Тус компани ОХБЦГ-аас эх авдаг Орхон голын усыг газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байна.

ОХБЦГ-ын 6 сумаас үр тариа тариалдаг нь зөвхөн Хархорин сум юм. Тус суманд Өвөрхангай аймгийн хүнсний ногооны гуравны нэгийг тариалдаг.

⁴ Өвөрхангай аймгийн Хархорин сумын засаг дарга Ламзавын Энхбаттай хийсэн ярилцлага, сумын ЗДТГ, 2014.02.10

Мөн Өвөрхангай аймгийн трактор, анжис, хөрс бутлагч машин зэрэг газар тариалангийн тоног төхөөрөмжүүдийн 90 орчим хувь нь Хархорин суманд байна(Өвөрхангай аймгийн Аж үйлдвэр, ХАА-н хэлтэс, 2014). Усалгаатай газар тариаланд экосистемийн үндсэн гурван үйлчилгээг үзүүлж байна.

Усны хангамж. Орхон гол нь Орхон-Сэлэнгийн ай савд багтах томоохон голуудын нэг юм. Орхон голын арвин усны нөөц нь Орхоны хөндий орчмын газрын хөрсийг илүү үржил шимтэй болгож усалгаатай газар тариалан эрхлэх нөхцлийг бүрдүүлдэг. ОХБЦГ-ын усны хангамжийн экосистемийн үйлчилгээ нь Өвөрхангай аймгийн Хархорин, Бат-Өлзийт, Уянга, Хужирт болон Архангай аймгийн Хашаат, Хотонт сумдын усалгаатай газар тариаланд амин чухал үүрэгтэй.

Тоос хүртээлт. Тоос хүртээгчид нь жимс, жимсгэнэ, цэцэг, тэжээлийн ургамлын аж ахуйд ихээхэн чухал үүрэгтэй. Мөн үндэслэг болон ширхэглэг ур тарианы үрийг боловсруулах, тархаахад оролцдог

(FAO, 2014). Үр тогтоолт, үр боловсруулалтыг бий болгодог тоос хүртээгч амьтдад зөгий, эрвээхий, ялаа, шувуу, сарьсан багваахай зэрэг багтана. Цаашилбал тоос хүртээлт салхиар ч явагдаж болно. ОХБЦГ нь цэцэгс, төрөл бүрийн ургамлын гэр болсон 95.5 мянган га ой модтой. Энэ газарт ургамлын төрөл зүйл элбэг байх бөгөөд энэ нь зөгий, эрвээхий зэрэг тоос хүртээгчдэд таатай орчинг бүрдүүлдэг учир тоос хүртээх үйлчилгээг илүү амар болгодог.

Байгалийн хадлан. Байгалийн өвс ургамлыг хадаж мал малын тэжээлд ашигладаг. Энэ нь мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тогтвортой байдалд чухал нөлөөтэй.

Энэхүү судалгааны хүрээнд цэвэр усны экосистемийн менежментийн өнөөгийн байдал,үүнд оруулж буй хөрөнгө оруулалтын дутмаг байдал зэрэгт үндэслэн, өнөөгийн явуулж байгаа газар тариалангийн үйлдвэрлэлийг БББ хувилбар гэж үзэж болно. БББ болон БКХО хувилбарын хэв шинжийг Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4. Газар тариалангийн салбарын БББ болон БКХО хувилбарын хэв шинж

БББ	БКХО
<ul style="list-style-type: none"> ▪ Экосистемийн менежментийн бодлого дутмаг, зөвлөгөө өгөх үйлчилгээ муу (мэргэжлийн бус экстейншний үйлчилгээ үзүүлэгч/тариаланч, мэдээллийн төв, тараах материал дутмаг, агро-бизнесийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үүнийг хөгжүүлэх орон нутгийн бодлого, төлөвлөгөө, дүрэм журам хангалтгүй; ▪ Газар тариалангийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилт дутмаг; ▪ Усалгааны систем сайн хөгжөөгүй, ус татах дэд бүтэц нэгдсэн төлөвлөгөөгүй, бас хүрэлцээгүй; ▪ Пестицид болон химийн бордооны хэрэглээ өндөр; ▪ Голын эрэг, бэлчээр ургамалгүй болж, ойн зурвасаар хамгаалсан бэлчээрийн систем байхгүй; ▪ Усны бохирдол их; ▪ Газар зохион байгуулалт, ашиглалт, бүсчлэл төлөвлөлт, хэрэгжилт сул хөгжсөн, ялангуяа бэлчээрийн газарт; ▪ Байгалийн хадлангийн хэмжээ багасаж зуднаас үүдэх хохирол ихсэх; 	<ul style="list-style-type: none"> ▪ Тогтвортой газар тариалан, экосистемийн менежментийн бодлого, үр дүн сайтайн зөвлөгөө өгөх үйлчилгээ (мэргэжлийн экстейншний үйлчилгээ үзүүлэгч, мэдээллийн төв, тараах материал элбэг, агро-бизнесийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үүнийг хөгжүүлэх орон нутгийн бодлого, төлөвлөгөө, дүрэм журам сайтай; ▪ Тогтвортой ХАА-н бодлогыг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц хөрөнгө оруулалттай, үүнд зудын хэрэглэх хангалттай хадлан хураах г.м; ▪ Төлөвлөгдсөн, хүртээмжтэй усалгааны дэд бүтэц; ▪ Пестицид болон химийн бордооны хэрэглээг хязгаарлах, хяналт тавих; ▪ Мод тарих, усны эх ундрагыг хамгаалах бодлого; ▪ Усны бохирдлыг бууруулах, түүнд хяналт тавих санхүүгийн арга хэмжээ (торгууль г.м) авах; ▪ Тариалангийн талбай болон бэлчээрийн газар ашиглалт, бүсчлэлийн төлөвлөлт, хэрэгжилт сайн зохион байгуулагдсан, ▪ Бэлчээр ашиглалтыг төлөвлөх зэрэг газар, бүс нутгийн зохицуулалттай, сайтар зохион байгуулагдсан ашиглалт;

Усалгаатай газар тариаланд БББ болон БКХО хувилбар хэрэгжсэнээр гарах алдагдал болон хожоог үнэлэхийн тулд дараах үзүүлэлтүүдийг сонгон авсан. Үүнд: үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ, нэгжийн үнэ, ажиллах хүч, улсад төлсөн татварын орлого. Газар тариалангийн салбарт хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж байна. Тус судалгаагаар газар тариалангийн

бүтээгдэхүүний таван төрлийн бүтээгдэхүүнийг сонгон авсан: хадлан, тэжээл, улаан буудай, хүнсний ногоо, чацаргана. Доорхи хэсгүүдэд эдгээр бүтээгдэхүүнүүдэд хийсэн судалгааны үр дүнг харуулав. Үндэсний Статистикийн Хороо (2014) гаргасан тоо мэдээнд үндэслэн ОХБЦГ-тай давхцан оршдог сумдын түвшинд тус тооцооллыг хийлээ.



ХАДЛАН


Өвөл, хаврын хатуу цагт малаа онд мэнд оруулахад намар бэлтгэсэн хадлан их чухал үүрэгтэй. 2013 онд ОХБЦГ-тай давхцан орших 6 сум жилд дунджаар 25,900 тонн хадлан бэлтгэдэг бөгөөд 2002-2012 оны хооронд нийт 238,700 тонн өвс хадсан байна. Сүүлийн 10-аад жилд малын тоо өсөхийн хэрээр хадлангийн хэмжээ нэмэгдсэн хэдий ч хур тунадас багасах, хуурайшил явагдаж байгаатай уялдан өвсний гарц мөн буурч байна.

Хадлангийн өвсний эрэлт нь нийлүүлэлтээсээ давснаар зах зээлийн үнэ хурдацтай өсөж байна. Энэ нь ОХБЦГ-ын байгалийн бэлчээрийн экосистемийн нөхөн сэргэх чадварт сөргөөр нөлөөлж, өвсний хомсдолд оруулж байгаа юм.

Жишээлбэл, 2012 онд ОХБЦГ-аас 4,560 тонн өвс хураан авсан ажээ. 2012 онд нэг тонн өвсний дундаж үнэ ОХБЦГ-ын 6 суманд 195.5 мянган төгрөг байв⁵. 2007 оноос хойш хадлангийн өвсний үнэ 100%-иар өсөөд байна.

График 4-т харуулснаар ОХБЦГ-ын 6 сумаас хураасан хадлангийн өвсний зах зээлийн нийт үнэ цэнэ 2012 оны байдлаар 5.1 тэрбум төгрөг (3.72 сая доллар) байна. 2002-2012 оны хооронд хадлангийн өвсний нийт зах зээлийн үнэ 31.5 тэрбум төгрөг (23.2 сая доллар) болж байна. Байгалийн хадлангийн ургац арвин байх тусмаа ОХБЦГ дотор болон гадна орших малчин өрхүүдэд маш чухал ач холбогдолтой.

График 4. ОХБЦГ-ын 6 сумын хадлангийн нийт үнэ цэнэ (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний Статистикийн Хороо (2014)


ТЭЖЭЭЛ

Малын тэжээлийн ургамал нь өвөл, хаврын улиралд мал тэжээхэд хэрэглэдэг газар тариалангийн нэг төрлийн бүтээгдэхүүн юм. ОХБЦГ-ын 6 сумд ойролцоогоор 543.2 тонн малын тэжээл хураасан бөгөөд 2002-2012 оны хооронд малын тэжээлийн нийт үйлдвэрлэл 9,300 тонн байжээ. 2008 оныг эс тооцвол, сүүлийн 10 жилд малын тэжээлийн үйлдвэрлэл тогтвортой байсан байна. Өвөрхангай аймгийн Уянга суманд үйлдвэрлэсэн малын тэжээлийн хэмжээ 2007 онд 80 тонн байснаа 2008 онд 959.6 тонн болж маш ихээр өссөн байна. Хадлангийн өвсний адил малын тэжээлийн зах

зээлийн үнэ ч өссөөр байна. 2012 онд ОХБЦГ-ын 6 суманд нэг тонн малын тэжээлийн дундаж үнэ 134.5 мянган төгрөг байв. График 5-аас харвал ОХБЦГ-ын 6 сумаас 2012 онд хураасан малын тэжээлийн зах зээлийн нийт үнэ цэнэ 105.4 сая төгрөг (77.6 мянган доллар) байжээ. 2002-2012 оны хооронд малын тэжээлийн зах зээлийн нийт үнэ цэнэ 1.16 тэрбум төгрөг (850.5 мянган доллар)-тэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, ийм хэмжээний экосистемийн үйлчилгээний үр өгөөжийг орон нутгийн иргэд болон аж ахуй нэгжүүд тэжээлийн ургамал тариалан хүртэж байна.

⁵ 2012 оны долларын ханшыг 1 доллар=1359.24 Төг гэж тооцов. Энэ нь www.mongolbank.mn цахим хуудсанд тайлагнасан долларын ханшны 2012 оны 12 сарын дундаж үзүүлэлт юм.

График 5. ОХБЦГ-ын 6 сумын малын тэжээлийн үйлдвэрлэлийн нийт үнэ цэнэ (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний Статистикийн Хороо (2014);

УЛААН БУУДАЙ


ОХБЦГ-аас эх авдаг, түүгээр дайран өнгөрдөг цэвэр усны экосистемийн үйлчилгээ нь ойр орчмын улаан буудайн үйлдвэрлэлд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг. ОХБЦГ-ын 2 суманд улаан буудай тариалж байна. Үүнд: Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Хотонт сум. Гэвч 2012 онд Хархорин сум дангаараа нийт 5.3 мянган тонн улаан буудай үйлдвэрлэсэн байхад бусад таван сум огт улаан буудай тариалаагүй байна. Тус хоёр сумын 2002-2012 оны нийт улаан буудай үйлдвэрлэл 24,000 тонн гэж тооцоологдов.

2008 онд хойш Хархорин сумын улаан буудай үйлдвэрлэл 857 тонн байсан бол 2012 онд 5,329 тонн болж хурдацтай өсжээ. Улаан буудайн үйлдвэрлэл ингэж хурдацтай өсөхөд Орхон голын

ус маш чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэвч Орхон голын усны нөөц багасаж байгаа нь ирээдүйд бүтээгдэхүүний гарцад бууруулах эрсдэлтэй.

Сүүлийн арван жилд улаан буудайн зах зээлийн үнэ мөн өсөлттэй байна. Нэг тонн улаан буудайн зах зээлийн дундаж үнэ 2012 онд 311.1 мянган төгрөг байв. Үнэ өссөнтэй холбоотойгоор төрөөс улаан буудайг тариаланчдаас худалдан авч, гурил үйлдвэрлэдэг компаниудад хямд үнээр нийлүүлэх зохицуулалт хийхэд хүрсэн. Улаан буудайнд хэрэгжүүлж буй төрийн урамшууллын бодлого нь Атрын 3-р аяны хүрээнд хэрэгжсэн ажил юм. 2002-2012 оны хоорондох улаан буудайны зах зээлийн үнэ цэнийг График 6-д харуулав.

График 6. ОХБЦГ-тай давхцан орших сумдад тариалсан улаан буудайн нийт үнэ цэнэ (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)



2012 онд ОХБЦГ-ын 6 сумын улаан буудай үйлдвэрлэлийн зах зээлийн үнэ цэнэ 1.7 тэрбум төгрөг (1.2 сая доллар) байсан бөгөөд 2002-2012 оны хооронд нийт 5.7 тэрбум төгрөг (4.2 сая доллар)-ийн улаан буудай үйлдвэрлэжээ. Ийм хэмжээний улаан буудай үйлдвэрлэхэд Орхон голын ус асар чухал ач холбогдолтой хэдий ч усны нөөцийн оновчтой менежментийг

хэрэгжүүлэх, цэвэр усны экосистемийн үйлчилгээг дэмжих, усны эх ундрагыг хамгаалах, бохирдлоос хамгаалах үйл ажиллагаанд ямар ч хөрөнгө оруулалт хийхгүй байна. Өөрөөр хэлбэл, энэ нь экосистемийн менежментийн БББ хувилбар өдий хүртэл хэрэгжиж байгааг харуулж байгаа хэрэг юм.

ХҮНСНИЙ НОГОО


ОХБЦГ-ын 6 суманд хураан авсан хүнсний ногооны хэмжээ 2006 онд 460 тонн байсан бол 2012 онд 1,980 тонн болтлоо өсжээ. Нийт хүнсний ногооны 67.5 хувь нь төмс байна. 2012 онд хураан авсан нийт хүнсний ногооны 72.3 хувийг Өвөрхангай аймгийн Хархорин сум үйлдвэрлэсэн байна (Хүнсний ногооны тариалалтын бүтцийн талаар илүү дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос харна уу?).

Социалист нийгмээс ардчилсан нийгэмэд шилжсэн 1990-ээд онд хоршоолол, нэгдлүүд хувьчлагдан, үйл ажиллагаагаа зогсоосон тэр үед хүнсний ногооны үйлдвэрлэл уналтанд орсон. Харин сүүлийн жилүүдэд ОХБЦГ-тай дахвцан орших 6 суманд усжуулалтын схем засгийн газрын дэмжлэгтэйгээр сайжирч байгаа ба үүний үр дүнд хүнсний ногооны үйлдвэрлэл нэмэгдсэн байна. Түүнчлэн хүнсний ногооны зах зээлийн үнийн өсөлт нь бага хэмжээний ногоочдод дэмжлэг болсон.

2012 онд өргөст хэмхийг эс тооцвол хүнсний ногооны килограмм тутмын зах зээлийн дундаж үнэ 1,253 төгрөг байсан ба өргөст хэмхний үнэ 2,786 төгрөгт байв. График 7-д 2002-2012 оны хоорондын хүнсний ногооны зах зээлийн үнэ цэнийг харуулав.

2012 онд ОХБЦГ-ын 6 суманд тариалсан хүнсний ногооны зах зээлийн нийт үнэ цэнэ 1.8 тэрбум төгрөг (1.34 сая доллар) байв. 2002-2012 оны хооронд хураан авсан хүнсний ногооны зах зээлийн нийт үнэ цэнэ 8.3 тэрбум төгрөг (6.1 сая доллар) болжээ. Бусад таван сумтай харьцуулахад Хархорин сум нийт эдийн засгийн үнэ цэнийн 73.8%-ийг дангаараа бүрдүүлж байна. Цэвэр усыг ашиглаж энэ хэмжээний үнэ цэнэ бүхий хүнсний ногооны үйлдвэрлэл явуулж байгаа ч экосистемийн менежментийг сайжруулаагүйгээс (БББ хувилбар) энэ үйлдвэрлэл цаашид буурах хандлагатай.

График 7. ОХБЦГ-ын 6 сумын хүнсний ногоо тариалалтын нийт үнэ цэнэ (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)

ЖИМС, ЖИМСГЭНЭ


ОХБЦГ-т ургадаг голлох жимсээр улаан лооль, чацарганыг нэрлэж болох бөгөөд энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр мөн л Хархорин сум тэргүүлж байна.

Хархорин сумын чацаргана үйлдвэрлэгч хамгийн том компани болох “Хархорин ХХК” 2007 оны байдлаар 500 га талбайд чацаргана тариалж эхэлсэн бөгөөд 2010 онд 8.5 тонн бүхий анхны ургацаа хураасан билээ. Тус компани нь дуслын услалтын системээр Орхон голын усыг ашиглан үйлдвэрлэлээ явуулдаг. Энэ компани нь засгийн газраас хэрэгжүүлсэн “Ногоон Хэрэм”, “Чацаргана” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Улмаар улсын төсвөөс 800 сая төгрөгийг чацаргана үйлдвэрлэхэд тус компанид олгожээ⁶. Өнөөгийн байдлаар “Хархорин ХХК”-ний төсөл “Аж үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд хүрээнд Чингис бондын

хөнгөлөлттэй зээлээр санхүүжигдэх 1,151 төсөлд шалгараад байна. Гэтэл БББ хувилбар ёсоор Орхон голын цэнгэг усны нөөцийн менежментэд ямар ч хөрөнгө оруулалт хийгдээгүй байна⁷. “Хархорин ХХК” нь засгийн газраас олгох хямд зээлийн санхүүжилтийг ашиглан үйлдвэрлэлээ өргөжүүлэхээр төлөвлөж байгаа нь ойлгомжтой. Гэхдээ БББ хувилбар цаашид энэ хэвээр үргэлжилбэл тус компаний үйлдвэрлэл цаашид төлөвлөсөн хэмжээндээ хүрэхгүй уналтанд орох эрсдэлтэй.

ОХБЦГ-ын 6 сумын чацарганы үнэ улаан лоолины үнэтэй харьцуулахад хурдан өсөж байна. Нэг килограмм чацарганы зах зээлийн дундаж үнэ 2012 оны байдлаар 4,881 төгрөг, улаан лоолины үнэ 2,920 төгрөг байна. График 8-д 2002-2012 оны хоорондох БББ хувилбарын жимс үйлдвэрлэлийн зах зээлийн үнэ цэнийг харуулав.

График 8. 2002-2012 оны хооронд ОХБЦГ-ын 6 сумын үйлдвэрлэсэн жимсний нийт үнэ цэнийн хандлага (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)

2012 онд жимс (чацаргана, улаан лооль)-ний зах зээлийн үнэ цэнэ 158.3 сая төгрөг (116.5 мянган доллар) байв. 2002-2012 оны хооронд жимсний зах зээлийн нийт үнэ цэнэ 359.55 сая төгрөг (264.5 мянган доллар) байжээ. Хадлангийн өвс, малын тэжээл, улаан буудай, хүнсний ногоо, жимсний


зах зээлийн нийт үнэ цэнийн нийлбэрээр газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэлийн зах зээлийн үнэ цэнийг тооцов. Газар тариалангийн үйлдвэрлэлийн зах зээлийн үнэ цэнэ 2012 оны байдлаар 8.8 тэрбум төгрөг (6.5 сая доллар) болж байна.

⁶ Эх сурвалж: Монгол улсын баг, сумдын үндэсний холбоо (2012): <http://bagsum.mn/index.php/news?start=2>

⁷ Эх сурвалж: Монгол улсын Шинэчлэлийн Засгийн Газар (22.01.2014) <http://zasag.mn/news/view/4293>



График 9. ОХБЦГ-ын 6 сумын усалгаатай газар тариаланд үзүүлж буй ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний нийт үнэ цэнэ (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)

2002-2012 оны хооронд хураан авсан газар тариалангийн үйлдвэрлэлийн зах зээлийн нийт үнэ 47 тэрбум төгрөг (34.6 сая доллар) байна (График 9). Газар тариалангийн салбарт ОХБЦГ-

тай давхцан орших сумдаас Хархорин сум голлох үйлдвэрлэгч бөгөөд 2012 онд энэ сумын үйлдвэрлэл нийт газар тариалангийн үйлдвэрлэлийн 45.1%-ийг эзэлж байна.

Бүтээгдэхүүний нийт зардлыг хасах, ашгийн хувиар үржүүлэх замаар цэвэр ашгийг олсон.

Хүснэгт 5. Газар тариалангийн салбарын ашгийн хувь хэмжээ

Он	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Ашгийн хувь (%)	61.5	61.5	61.5	61.5	61.5	53.3*	45.1*	36.9*	28.8	28.8	28.8


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2012); *Таамаглалд үндэслэн тооцов⁸.

Хүснэгт 5-д нийт ашгийн хувийг үзүүлэв. Тухайлбал, 2010 онд газар тариалангийн нийт орлогын 28.8 хувь нь ашиг гэж үзэж болно. График 10-т 2002-2012 оны хоорондох зах зээлийн үнийн хандлагыг харуулав. Усалгаатай газар тариаланд үзүүлж буй экосистемийн үйлчилгээний цэвэр үнэ цэнэ сүүлийн жилүүдэд өсөж байна.

Тухайлбал, 2002 онд 1.2 тэрбум төгрөг байсан бол 2012 онд 2.5 тэрбум төгрөг болж өсжээ. ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний усалгаатай газар тариалангийн салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнийн ихэнх хувь нь Өвөрхангай аймгийн Хархорин суманд ногдож байна.

⁸ Үндэсний статистикийн хороо (2012) 2006, 2010 оны ашгийн хувийг 61.5, 28.8 хувь гэж мэдээллэсэн бөгөөд 2002-2005 оны үзүүлэлтийг 2006 оныхоор, 2011-2012 оны үзүүлэлтийг 2010 оны ашгийн хувьтай тэнцүү гэж, харин 2007-2009 оны үзүүлэлтийг тус хоёр үзүүлэлтийн дундаж өсөлтөөр тооцов.

График 10. 6 ОХБЦГ-ын 6 сумын усалгаатай газар тариаланд ОХБЦГ-ын экосистемийн үзүүлж буй үйлчилгээний үнэ цэнэ (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)


ОХБЦГ-ын 6 сумын усалгаатай газар тариалангийн салбар нь тодорхой хэмжээний орон нутгийн иргэдийн ажлын байраар хангадаг. Тухайлбал: Үндэсний статистикийн хороо(2014)-ноос мэдээлснээр 2012 онд 1,178 өрх, 55 компани ОХБЦГ-ын 6 суманд газар тариалан эрхэлжээ. 2011 онд явуулсан Монгол улсын хөдөө аж ахуйн анхдугаар тооллогоор газар тариалангийн 1 компани 4.4 хүнийг, 1 өрх 1.5 хүнийг ажлын байраар хангасан гэж тайлагнасан байна. Энэ үзүүлэлтийг ашиглан газар тариалангийн салбарт ажиллаж буй хүмүүсийн тоог тооцож гаргав (График 11).

2012 онд ОХБЦГ-ын 6 суманд ойролцоогоор 2 мянган хүн усалгаатай газар тариалангийн салбарт ажиллаж байсан байна. ОХБЦГ-ын

цэвэр усны экосистемийн үйлчилгээгүйгээр Ийм хэмжээний ажил эрхлэлт бий болох боломжгүй юм. Усалгаатай газар тариаланд нэг хүн жилд 7 сар ажилладаг гэж үзэн энэ салбарын ажлын байрны бий болгосны үр өгөөжийг тооцов.

Нийт ажлын байраар хангагдсан хүний тоог ҮСХ (2012)-ноос гаргасан сар цалингаар үржүүлэн газар тариалангийн салбарын ажлын байр бий болгосны үр өгөөжийг тооцов. Нэг хүний сарын дундаж цалинд татвар, нийгмийн хамгааллын зардлуудыг хассан. 2012 онд ОХБЦГ-тай давхцан оршдог 6 сумын газар тариалангийн салбарын ажлын байр бий болгосны орлого 3.5 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2002-2012 оны хоорондох нийт үнэ цэнийн нийлбэр нь 14.5 тэрбум төгрөг болж байна.

График 11. ОХБЦГ-ын 6 суманд усалгаатай газар тариалангийн салбарт ажиллаж буй хүмүүсийн тоо



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)




НИЙТ ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТ ҮНЭ ЦЭНЭ

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний усалгаатай газар тариалангийн салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнийг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн

цэвэр үнэ цэнэ, ажлын байр бий болгосны үр өгөөж, татварын орлогын нийлбэрээр тооцсон болно. Үүнийг График 12-т харуулав.

График 12. ОХБЦГ-ын 6 сумын усалгаатай газар тариалангийн эдийн засгийн нийт үнэ цэнэ




Эх сурвалж: Судлаачдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)

Усалгаатай газар тариалангийн салбарт ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнэ нь 2012 оны байдлаар 6 тэрбум төгрөг бөгөөд энэ нь 2002 оны үнэ цэнээс даруй 4.3 дахин өссөн үзүүлэлт юм. 2002-2012 оны

хооронд усалгаатай газар тариалангийн ОХБЦГ-аас хүртсэн экосистемийн үнэ цэнийн нийлбэр нь 33.9 тэрбум төгрөгтэй тэнцүү (24.9 сая доллар) байна.

График 13. ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний газар тариалангийн салбарт оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнийн хэтийн төлөв (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо

Газар тариалангийн салбар өнөөг хүртэл БББ хувилбараар явж ирсэн гэж үзвэл, өөрөөр хэлбэл ОХБЦГ-ын усны менежмент бүрэн хангагдаагүй байсан энэ байдал цаашид үргэлжилбэл газар тариалангийн үйлдвэрлэлд үзүүлж буй хувь нэмэр буурна. График 13-т БББ болон БКХО хувилбаруудаар тооцсон үнэ цэнийг харуулав.

БББ хувилбараар явж ирсэн газар тариалангийн салбарын 2002-2012 оны үнэ цэнэ жилд дунджаар 20.7%-иар өссөн байна. БББ хувилбар цаашид үргэлжилбэл, энэхүү дундаж өсөлт нь 2013 оноос жил бүр 2.5%-иар буурна гэж таамаглав. Учир нь БББ хувилбар үргэлжилснээр байгаль орчинд халтай газар тариалангийн менежмент, экосистемийн менежментийн санхүүжилтийн дутмаг байдал, төлөвлөлт муутай услалтын систем, пестицид болон химийн бордооны хэрэглээний өсөлт, усны бохирдол, усны үрэлгэн хэрэглээ зэрэг асуудлууд шийдвэрлэгдэлгүй улам газар авсаар байх болно. Энэ хандлага хэвээр хадгалагдвал ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний газар тариалангийн салбарт оруулах хувь нэмэр буюу үнэ цэнэ 2033 онд 1.0 тэрбум төгрөгт (757.4 сая долларт) хүрч буурна⁹. Өөрөөр хэлбэл БББ хувилбар цаашид үргэлжилснээр 2033 оны үнэ цэнэ 2012 оны үнэ цэнээс 6 дахин багасна.

БББ хувилбараар явбал 2023 он хүртэл богино хугацаанд 32.1 тэрбум төгрөгийн богино хугацааны хожоо олох боломжтой. Гэвч үүнээс хойш жилийн дундаж өсөлт сөрөг утгатай


болсноор үнэ цэнэ буурч эхэлнэ. БББ хувилбараар явбал 2024-2033 оны хооронд нийт 68 тэрбум төгрөгийн алдагдалд хүрч болзошгүй. Богино хугацааны хожоо, урт хугацааны алдагдал хоёрын зөрүү буюу БББ хандлагын 2013-2033 оны хоорондох цэвэр алдагдал нь 35.9 тэрбум төгрөгтэй тэнцүү болохоор байна.

Харин БКХО хувилбар хэрэгжвэл үнэ цэнэ нь тодорхой түвшин хүртлээ өсөж, цаашид тогтворжино. Энэ нь газар тариалангийн оновчтой бодлого, практикийг хэрэгжүүлж, экосистемийн менежментийг санхүүжүүлэн дэмжсэнээр хүрэх үр дүн юм. БКХО хувилбараар хэрэгжсэнээр 2019 онд 12.2 тэрбум төгрөгт хүрнэ, энэ нь газар тариалангийн салбарын ОХБЦГ-ын экосистемээс хүртэх үр өгөөжийн дээд хэмжээ гэж үзэж болно (БББ хувилбарын хамгийн өндөр үзүүлэлт). БКХО хувилбараар энэ үнэ цэнэ 2029 оноос хойш тогтвортой хадгалагдана.

3.4 МАЛ АЖ АХУЙН САЛБАР

ОХБЦГ нь зэргэлдээ сумдын мал аж ахуйн салбарт байгалийн бэлчээр, ус зэрэг экосистемийн үйлчилгээг үзүүлэн мянга мянган малчдын амьжиргааг залгуулж байна. Үндэсний статистикийн хороо (2014)-ны тоо баримтаас харахад 2012 онд ОХБЦГ-ын 6 сум нь 1 сая малтай. 2002 онд 581,300 байсан малын тоо 2012 онд 1,073,800 болж өсөөд байгаа юм. Малын тоог График 14-т үзүүлэв.

График 14. ОХБЦГ-тай давхцан орших 6 сумдын малын тоо (Мянган толгой)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)

⁹ 2012 оны долларын төгрөгтэй харьцах ханшаар тооцов.



ОХБЦГ-тай дахвцан орших сумдын мал аж ахуйн салбарын гол асуудал нь бэлчээрийн доройтол бөгөөд энэ нь малын тоо бэлчээрийн даацаас хэтэрсэнтэй холбоотой. 2010-2014 оны ОХБЦГ-ын хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөөнд 2011 онд тус бүс нутгийн бэлчээрийн талбайн 33% нь маш их, 55% нь дунд зэргийн доройтолд орсон, харин 12% нь бэлчээрийн доройтолд ороогүй гэж тэмдэглэжээ. Тус баримт бичигт Бат-Өлзий сумын Зөрүүлэг, Хужирт сумын Уужим, Хотонт сумын Хөөвөр, Бургалтай,

Хархорин сумын Жалбаа, Нарийнхур, Онгоцон Ухаа, Хашаат сумын Цайдам, Баян, Номгон багийн бэлчээрийн даац 0.75-1.0 дахин хэтэрсэн байна (ОХБЦГ-ын удирдлагын төлөвлөгөө, 2013). Тиймээс ОХБЦГ-тай дахвцан орших сумдын мал аж ахуйн салбарын бэлчээрийн менежмент нь БББ хувилбар өнөөг хүртэл хэрэгжиж байгааг харуулж байна. Доорх хүснэгтэд мал аж ахуйн салбарын БББ болон БКХО хувилбарын хэв шинжийг харуулав.

Хүснэгт 6. ОХБЦГ-ын 6 сумын мал аж ахуйн салбарын БББ ба БКХО хувилбарын хэв шинж

БББ	БКХО
<ul style="list-style-type: none"> ▪ Бэлчээрийн тогтвортой менежментийн бодлого ядмаг; ▪ ОХБЦГ-ын бэлчээрийг сүйтгэгч мэрэгч амьтдын тоо өсөж байгаа; ▪ Өнөөгийн мал аж ахуйн менежмент нь уст цэг орчмын бэлчээрийг доройтуулах шалтгаан болдог; ▪ Бэлчээрийн үнэлгээ хийж, бэлчээрийн нөхцөл байдлын талаар олон нийтэд мэдээлэл тараах тогтолцоо байхгүй; ▪ Бэлчээрийн оновчтой менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, тоо мэдээ цуглуулах санхүүжилт дутмаг ▪ Өнөөгийн бэлчээрийн менежментийн бодлого нь бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулахад ямар ч нөлөөгүй; ▪ Одоогийн мал аж ахуй нь бэлчээрийн даацыг хэтрүүлэх ба бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх хүсэл сонирхол бага. 	<ul style="list-style-type: none"> ▪ Бэлчээрийн тогтвортой менежментийн бодлого хэрэгжсэн; ▪ Байгальд ээлтэй хортон шавжид хяналт тавьдаг байгальд ээлтэй менежмент; ▪ Уст цэг орчмын бэлчээрийг доройтуулахгүй мал аж ахуй эрхлэх; ▪ Бэлчээр хариуцсан алба мөн ТХГН-ийн захиргаадад бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, тоо мэдээ цуглуулах санхүүжилт хангалттай; ▪ Бэлчээрийн менежментийн бодлого нь хэрэгжилтэд тавих хяналт сайтай; ▪ Бэлчээрийн бодлого үр дүн нь үр өгөөжтэй; ▪ Бэлчээрийн даацыг хэтрүүлэлгүй мал аж ахуйг хөгжүүлэх бодлого хэрэгжиж, энэ бодлогыг хэрэгжүүлэх хүсэл сонирхлыг санхүүгийн дэмжлэгээр нэмэгдүүлнэ.

Мал аж ахуйн салбар ТХГН-ийн хэд хэдэн экосистемийн үйлчилгээний үр өгөөжийг хүртэн байж үйл ажиллагаагаа явуулдаг, тухайлбал бэлчээр, ус. Хуулийн дагуу “Дархан Цаазат Газар” болон “Байгалийн Дурсгалт Газар”-аас бусад ТХГН-т мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрдөг. Тэдгээр ТХГН нь малын улирлын бэлчээр болон ус зэрэг экосистемийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг, ингэснээр мал аж ахуйн салбар хөгжиж орон нутгийн малчдын аж амьдрал дээшилдэг.


ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний мал аж ахуйн салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнийг таван хошуу малын мах, ямаа, үнээний сүү, арьс, шир, ноос, ноолуур зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр тооцов.

МАХ ҮЙЛДВЭРЛЭЛ

Мах бол Монголчуудын хүнсний хэрэглээний хамгийн чухал бүтээгдэхүүн бөгөөд шаардлагатай уургийн ихэнх хувийг махнаас авдаг. 2013 онд 249.7 мянган тонн мах үйлдвэрлэсэн бөгөөд нэг хүнд 89.4 кг мах ногдож байна (ҮСХ, 2014а). 2012 онд ОХБЦГ-тай дахвцан орших сумдад нийт 7.0 мянган тонн махан үйлдвэрлэгдсэн байна. Гэвч 2009-2010 зудны үед малын хорогдол нэмэгдэж улмаар махны нийлүүлэлт буурсан байна.

Эдгээр сумдад 2012 онд үхрийн мах кг нь дунджаар 6,040 төгрөг, хонины мах 5,450 төгрөг байжээ. 2009 оны зуднаас өмнө махны үнэ хямд байсан. Жишээ нь 2009 онд 1кг үхрийн мах 2,460 төгрөг байсан нь 2012 оны үнээс 2.5 дахин хямд байжээ.

График 15. ОХБЦГ-тай давхцан орших сумдад үйлдвэрлэсэн махны үнэ цэнэ (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014d)


ОХБЦГ-ын 6 сумын мах үйлдвэрлэлийг үнийн дүнгээр тооцохдоо зах зээлийн үнийг нийт үйлдвэрлэсэн махны хэмжээ (малчин өрх дотроо хэрэглэсэн махыг оруулсан)-гээр үржүүлж тооцов. График 15-д ОХБЦГ-ын 6 сумын эрэлтийн өсөлт, нийлүүлэлтийн хомсдолоос үүдэн махны үнэ өссөнтэй уялдан 2002-2012 онд нийт үйлдвэрлэл мөнгөн дүнгээрээ өссөнийг харуулж байна, гэвч үйлдвэрлэсэн махны бодит хэмжээ энэ хугацаанд тийм ч их өсөөгүй. 2012 он мах үйлдвэрлэлийн нийт үнэ цэнэ нь 36.5 тэрбум төгрөг (26.9 сая доллар) байв.

СҮҮ ҮЙЛДВЭРЛЭЛ

Сүү үйлдвэрлэлийн үнэ цэнийг ОХБЦГ-тай давхцан орших сумдын ямаа, үнээний сүү үйлдвэрлэлээр тооцов. Нийт сүү үйлдвэрлэлийг тооцохдоо Өвөрхангай аймгийн 4 суман дахь үхрийн тоог дундаж сүүний гарцаар үржүүлж тооцов.

2012 онд 6 сумдын нийт үйлдвэрлэсэн сүү 11.4 мянган тонн байв. Нэг литр сүүний үнэ маш хурдан өсөж байгаа бөгөөд 2012 онд нэг литр сүү 1,300 төгрөг байжээ. ОХБЦГ-ын 6 сумын нийт сүү үйлдвэрлэлийн хэмжээг үнийн дүнгээр тооцохдоо үйлдвэрлэсэн сүүг жилийн дундаж үнээр үржүүлж тооцов.

График 16. ОХБЦГ-ын сумуудын сүүн бүтээгдэхүүний эдийн засгийн өртөг (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо(2014d)




График 16-аас харахад 2012 онд сүүний нийт үнэ цэнэ 14.9 тэрбум төгрөг (11 сая доллар) байна. ОХБЦГ-ын бэлчээр, ус зэрэг экосистемийн үйлчилгээгүйгээр ийм үнэ цэнэ бүхий сүү үйлдвэрлэл явуулах боломжгүй. Уянга болон Бат-Өлзий сумд нь малын тоогоороо хамгийн өндөр учир эдгээр сумд сүү үйлдвэрлэлээр бусад 4-өөс тэргүүлж байна. 2002-2012 оны сүү үйлдвэрлэлийн үнэ цэнийн нийлбэр 103.5 тэрбум төгрөг (76.5 сая доллар) болж байна.

НООЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Малын гаралтай бүтээгдэхүүнээс хамгийн өндөр өртөгтэй нь ямааны ноолуур юм. 2012 онд ОХБЦГ-ын 6 суманд нийт 92.6 тонн ноолуур үйлдвэрлэгджээ. Үндэсний статистикийн хороо (2014d)—ны тайланд 2012 онд ноолуурын дундаж үнэ нэг кг нь 42.6 мянган төгрөг байжээ (График17).

График 17. ОХБЦГ-ын 6 сумын ноолуур үйлдвэрлэлийн үнэ цэнэ (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014d)

Тус сумдын 2012 онд үйлдвэрлэсэн ноолуурын нийт үнэ цэнэ 4.09 тэрбум төгрөг (3 сая доллар), 2002-2012 оны нийлбэр дүнгээр 27 тэрбум төгрөг буюу 19.9 сая доллар байв. Өөрөөр хэлбэл, энэ эдийн засгийн үнэ цэнэ нь бэлчээрийн болон усны экосистемийн үйлчилгээний үр дүн юм.


НООС ҮЙЛДВЭРЛЭЛ

Нүүдлийн соёл, уламжлалаа дагаад Монголчууд ноосыг амьдрал ахуйдаа өргөнөөр хэрэглэдэг, жишээ нь хонь, тэмээний ноосоор эсгий хийж гэрээ бүрдэг, тэр нь өвлийн хүйтэн, зуны халуунаас гэрийг тусгаарлах материал болдог, мөн гэрийн

дээвэр, туурга, гудас, гутал зэргийг эсгийгээр хийдэг.

2012 онд ОХБЦГ-ын 6 сумдад 568.9 тонн хонь (99.4%), тэмээний ноос (0.6%) үйлдвэрлэгджээ. 2012 онд нэг кг хонины ноос дунджаар 614 төгрөг тэмээний ноос 5,300 төгрөг байсан. Ноосны дундаж үнийн Монгол улсын бүх ТХГН-тай давхцан орших 189 сум, 4 дүүргийн дундаж үнээр тооцов. 2012 онд ноос үйлдвэрлэлийн үнэ цэнэ 345.3 сая төгрөг байсан бөгөөд 2002-2012 оны нийлбэр дүнгээр ТХГН-ийн 6 суманд 2.05 тэрбум төгрөг(1.5 сая доллар-ийн ноос үйлдвэрлэжээ (График 18)

График 18. ОХБЦГ-ын 6 сумын ноос үйлдвэрлэлийн үнэ цэнэ (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014d)


АРЬС, ШИР ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол улс арьс, шир боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадал сул, үүнтэй холбоотойгоор үйлдвэрлэсэн арьс, ширээ түүхийгээр нь БНХАУ руу экспортлодог. Нийт үйлдвэрлэсэн арьс, ширийг нядалсан малын тоотой тэнцүү гэж үзэн тооцов.

2012 онд ОХБЦГ-ын 6 сумдад нийт 114,600 ширхэг арьс, шир үйлдвэрлэгдсэн байна. Тус сумдын 2012 оны арьс, ширний үнийг дор жагсаав:

- Ямааны арьс: 14,000 төгрөг
- Хонины арьс: 9,300 төгрөг
- Үхрийн шир: 24,600 төгрөг
- Адууны шир: 30,600 төгрөг
- Тэмээний шир: 10,900 төгрөг

График 19. ОХБЦГ-ын 6 сумын арьс, шир үйлдвэрлэлийн үнэ цэнэ (Сая.төг)




Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014d)

2012 онд ОХБЦГ-ын сумдад үйлдвэрлэсэн нийт арьс, ширний үнэ цэнэ 2 тэрбум төгрөг байв. 2002-2012 оны арьс, ширний үнэ цэнийн нийлбэр нь 13.7 тэрбум төгрөг буюу 10.1 сая доллар байжээ.

ОХБЦГ-тай дахвцан орших сумдын МАА-н салбарт үйлдвэрлэгдсэн мах, сүү, ноос, ноолуур, арьс, ширний үйлдвэрлэл нь ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээтэй салшгүй холбоотой.



График 20. ОХБЦГ-ын 6 сумын мал аж ахуйн нийт үйлдвэрлэлийн үнэ цэнэ (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014)

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээг ашигладаг мал аж ахуйн үйлдвэрлэлийн нийт үнэ цэнэ 2012 онд 57.8 тэрбум төгрөг (42.6 сая доллар) байсан ба өсөх хандлагатай байна.

Нийт үнэ цэнээс үйлдвэрлэлийн зардлыг хасаж цэвэр үнэ цэнийг тооцоход 2012 оны экосистемийн үйлчилгээний МАА-н салбарт үзүүлж буй экосистемийн үнэ цэнэ 34.1 тэрбум төгрөг (25.1 сая доллар) байв¹⁰. Гэвч бэлчээрийн экосистемийн сул менежментээс шалтгаалан өнөөгийн өсөлтийн түвшин тогтмол хадгалагдахгүй байна. Тиймээс нэг малаас авах бүтээгдэхүүний ашиг шим, МАА-н үйлдвэрлэлийн үнэ цэнийг цаашид тогтвортой байлгах арга зам нь ТХГН-нийн экосистемийн үйлчилгээний менежментэд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал юм. Үүнийг ОХБЦГ-ийн экосистемийн үйлчилгээний үр өгөөжийг МАА-н салбарт хамгийн их хүртэж буй Хархорин сумын жишээгээр харж болно. Бусад 5 сумтай харьцуулахад энэ суманд экосистемийн үйлчилгээний МАА-н салбарын үнэ цэнийн 23.5% нь ногдож байна. Мал аж ахуйн салбарын бас нэг


чухал үзүүлэлт бол бий болгосон ажлын байрны тоо юм. ҮСХ (2014b)-ны судалгаагаар авч үзвэл нэг малчин өрх дунджаар 2 байнгын ажлын байр бий болгодог. 2012 оны байдлаар ОХБЦГ-ын 6 суманд МАА-н салбарт 10,900 хүн ажиллаж байна. Энэ хэмжээний ажлын байр бий болгосны үнэ цэнийг мөнгөн дүнгээр тооцвол 29.8 тэрбум төгрөг (21.9 сая доллар) байна¹¹.

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний МАА-н салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнийг ажлын байр бий болгосны үнэ цэнэ болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн цэвэр орлогын нийлбэрээр тооцов. Ингэж тооцоход 2012 оны байдлаар МАА-н салбар 63.9 тэрбум төгрөг (47.0 сая доллар)-ийн үр өгөөжийг ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээнээс хүртэж байна. 2002-2012 оны МАА-н салбар дахь ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний нийлбэр нь 368.1 тэрбум төгрөг буюу 270.8 сая доллар байна. Энэ хэмжээний үр өгөөжийг МАА-н салбар ОХБЦГ-ын бэлчээрийн экосистемийн үйлчилгээгүйгээр хүртэх боломжгүй (График 21).

¹⁰ Үндэсний статистикийн хороо (2012)-ны тайланд МАА-н бүтээгдэхүүний үнийн хүснэгтийг хавсралтаас үзнэ үү?

¹¹ ҮСХ-ноос гаргасан нийт ажиллагсдын тоог тэдний авч буй дундаж цалин (бүх төрлийн татвар, даатгалыг хасч тооцсон)-гийн дүнгээр тооцов. Гэвч маш цөөн малчид орлогоосоо татвар, нийгмийн даатгал төлж байна.

График 21. ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний МАА-н салбарт оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ (Тэрбум.төг)




Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014d)

Дээрх тооцооллод үндэслэн МАА-н салбарын үнэ цэнийн цаашдын хандлагыг БББ болон БКХО хувилбараар тооцов. 2002-2012 оны хооронд ОХБЦГ-ын 6 сумын МАА-н салбарын үнэ цэнийн жилийн дундаж өсөлт 16.9% хувьтай байна. БББ хувилбар цаашид хэвээр үлдвэл энэ өсөлт жил бүр 1.7%-иар буурна гэж үзэв. Дундаж өсөлт ингэж буурснаар 2022 он хүртэл үнэ цэнэ өсөж хамгийн өндөр түвшиндээ хүрээд 2023 оноос буурч эхлэх юм, учир нь энэ оноос эхлээд жилийн дундаж өсөлт сөрөг утгатай болно. 2013-2024 онд БКХО хувилбартай харьцуулахад БББ

хувилбарын хувьд МАА-н салбар 264.4 тэрбум төгрөг (194.5 сая доллар)-ний хожоотой байх болно. Гэвч 2025-2033 онд БКХО хувилбарын үнэ цэнэ БББ хувилбарын үеийн үнэ цэнээс их болж, БББ хувилбар хэрэгсэний алдагдал 459.5 тэрбум төгрөг (338.0 сая доллар)-т хүрэх юм. 2013-2033 онд хэрэв БББ хувилбар хэрэглэсэн хэвээр байвал ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний МАА-н салбарт оруулах хувь нэмэр буюу үнэ цэнийн цэвэр алдагдал 195.1 тэрбум төгрөг (143.5 сая доллар) болно (График 22).

График 22. ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний МАА-н салбарт оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнийн хэтийн төлөв (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо




БКХО хувилбар хэрэгжсэнээр ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний МАА-н салбарт оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнэ 2027 онд боломжит дээд хэмжээндээ хүрч цаашид энэ хэмжээндээ тогтвортой байна, хэрэв БББ хувилбар хэрэгжсэн бол хамгийн дээд хэмжээнд 2021 онд хүрэх байсан.

БКХО хувилбараар бэлчээрийн нөөцийн менежментийн бодлого нь бэлчээрийг сайжруулах, малчдад зориулсан экстейншний үйлчилгээ буюу

мэргэжлийн зөвлөх үйлчилгээг түлхүү явуулах, бэлчээрийн доройтлоос сэргийлэх үр дүнтэй, системтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх, энэ бүгдийг урт хугацаанд санхүүжүүлэх шаардлагатай гэж үздэг. 2033 онд БКХО хувилбарын дагуу ОХБЦГ-ын МАА-н салбарт үзүүлэх экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ 2012 оны үнэ цэнээс хоёр дахин их буюу 131.2 тэрбум төгрөг (96.5 сая доллар)-т хүрсэн байх болно.

Газрын Зураг 2: ОХБЦГ-ын орчмын гадаргын усны сүлжээ



Эх сурвалж: ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014)

3.5 УНДНЫ УС

Экосистемийн олон талт ач холбогдол бүхий гол мөрнүүдийн нэг бол ОХБЦГ-аар дамжин урсах Орхон гол юм. Орхон гол нь Суврага Хайрхан уулын бэлд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт Хангайн нуруунаас эх авдаг. Хангайн нуруунаас Өвөрхангай аймгаар дайран өнгөрдөг ба Хархорин хүртэл Орхоны хөндийн дээд хэсгийг даган урсдаг. Цаашид урссаар 10 метр өргөн 20 метр өндөр Орхоны хүрхрээ буюу Улаанцутгалад хүрдэг.

Хархориноос Булган аймаг хүрээд зүйн хойд зүг рүү ОХУ-ын хилийн ойролцоо Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын дэргэд Сэлэнгэ голтой нэгддэг. 1,124 км үргэлжлэх Орхон гол нь Сэлэнгэ голоос ч хол урсах бөгөөд Монголын хамгийн хол урсдаг гол юм. Орхон голыг тэтгэдэг гол эх үүсвэр нь Туул, Тамир гол юм. ОХБЦГ-т 219 гол, горхи, 36 булаг шанд, 7 рашаан, 15 нуур байдаг. Газрын Зураг 2-т ОХБЦГ-ын ойр орчмын болон гадаргын усны сүлжээ, Газрын Зураг 3-т Орхон голын байрлалыг харуулав.

Газрын Зураг 3: Орхон голын байрлал



Эх сурвалж: ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014)

Мөн их устай бороо, хаврын шар усны үерийн үеэр гол ус үерлэх, хөрсөнд ус шингэлгүй урсан, хөрсний элэгдэлд оруулах эрсдэл нэмэгддэг. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалт дутмаг байгаа явдал нь хүн амын ундны усны экосистемийн үйлчилгээ багасах буюу БББ хувилбар хэрэгжих нөхцөл бүрддэг. Хүснэгт 7-д ундны усны БББ болон БКХО хувилбарын хэв шинж харуулав.

Ойр орчмын бүс нутагтаа Орхон гол нь өндөр ач холбогдолтой гадаргын усны эх үүсвэр бөгөөд усны түвшин нь тухайн жилийн хур тунадасны хэмжээнээс үлэмж хамаардаг. Сүүлийн жилүүдэд ОХБЦГ дахь Орхон голыг тэжээдэг жижиг гол, горхи, булаг шанд ширгэж байна. Өвөрхангай аймагт орших ихэнх (71.2%) гол мөрний усны түвшин багассан байна (ОХБЦГ-ын Хамгаалалтын Захиргаа, 2014а). Сүүлийн 4-5 жилд хур тунадас нэмэгдэн, байдал сайжирч байгаа ч цаашдаа гол мөрөн ширгэх эрсдэл байсаар байна.

Хууль бус мод бэлтгэл, ойн нөөцийн хомсдол зэрэг нь ОХБЦГ орчмын гол мөрний усны түвшин буурахад нөлөөлж байна, учир нь хөрсний усыг шингээх, тогтоон барих чадвар сулардагтай холбоотой.

Фото Зураг: Орхоны хүрхрээ 2011 он



Эх сурвалж: <http://visitamongolia.blogspot.com>

Хүснэгт 7. Ундны усны салбарын БББ болон БКХО хувилбарын шинж чанар

БББ	БКХО
<ul style="list-style-type: none"> ▪ Ундны усны зохисгүй хэрэглээ; ▪ Жуулчид, жуулчдын баазууд, нутгийн иргэд усны бохирдуулах, ба ус цэвэршүүлэх байгууламж хөгжөөгүй; ▪ Эрүүл ахуйн шаардлага хангаагүйн улмаас бохир уснаас гаралтай өвчин нэмэгдэх; ▪ Усны хэмжээ, чанар, урсгал, худаг, бохирдол, рашааны үнэлгээ г.м мэдээллийг агуулсан усны нөөцийн мэдээллийн сан буюу систем байхгүй; ▪ Голын сав газар, усны эх ундрагын хамгаалалт муу; ▪ Усны тоолуурын систем дутмаг буюу хөгжөөгүй; усны үнэ хямд буюу улс төрийн нөлөөгөөр усыг хямд борлуулдаг; ▪ Хаягдал буюу саарал ус их; 	<ul style="list-style-type: none"> ▪ Усны тогтвортой менежмент, бохир усны хариуцлагатай менежмент; ▪ Байнгын ажиллагаатай, хүчин чадал хангалттай ус цэвэршүүлэх байгууламж; ▪ Эрүүл ахуйн шаардлага хангасан, хаягдал усны менежмент сайжирч, бохир уснаас гаралтай өвчин буурсан; ▪ Усны тоо, бүртгэл мэдээллийн системтэй; ▪ Голын сав газар, усны эх ундрагын хамгаалалт хамгаалалт сайтай; ▪ Усны тоолуурын систем хөгжсөн, хэрэглэгчдийн онцлогоос хамааран усны өндөр зохих хэмжээнд хүрсэн: ахуйн хэрэглээний, ашиг орлогын, аж үйлдвэрийн, газар тариалангийн г.м; ▪ Хаягдал буюу саарал усыг бага;




Монгол улсад усны литр тутмын үнэ нь ЗГ-аас тогтоосон экологи, эдийн засгийн үнэ цэнээс бага байна. Өөрөөр хэлбэл, ундны усны салбар ЗГ-ын татаасаар өдийг хүртэл хөл дээрээ зогсдог. Ингэснээр хэрэглэгчид усыг хэт “хямд” үнээр ашиглах боломжтой болдог. Жишээ нь: 2012 онд Ус сувгийн удирдах газар (УСУГ)-ын тооцооноор гэр хороололд амьдардаг хүмүүсийн нийт усны хэрэглээ жилд 681,8 мянган шоо метр байжээ, нэг шоо метр усны үнэ 5,294.8 төгрөг (3.9 доллар) байхад үйл ажиллагаагаа хэвийн явуулах

боломжтой гэж тооцжээ. Хэрэглэгчдэд худалдсан нэг шоо метр усны үнэ 911.6 төгрөг (0.671 доллар) байсан. Энд БББ хувилбар хэрэгжиж байна гэж үзэж болно.

Хөдөө орон нутагт хүн амын нягтшил бага бөгөөд ялангуяа ТХГН-т амьдрах малчин өрхүүд хоорондоо маш хол зайтай амьдардаг. Тэд 4 улирлын турш, бэлчээрийн соргогийг хайн нүүдэллэн амьдардаг. 2012 оны байдлаар ОХБЦГ-т ойролцоогоор 12 орчим мянган хүн амьдарч байна (График 23-т).

График 23. ОХБЦГ-т амьдардаг хүн амын тоо (Мянган хүн)




Эх сурвалж: ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014)

ОХБЦГ-аас гаралтай ундны усны экосистемийн үйлчилгээг зөвхөн ТХГН дотор амьдардаг иргэд биш түүнээс гадна ойр орчмын хүн ам хүртэн, ундны усны хэрэгцээгээ хангадаг. Тиймээс ОХБЦГ дотор амьдардаг хүмүүсээс гадна, тус газартай давхцан орших 3 аймгийн 6 сумын ард иргэд тус газрын усны эх үүсвэр, ялангуяа Орхон голын усыг хэрэглэдэг. Мөн ОХБЦГ-аас ундны ус савлан зах зээлд борлуулдаг 3 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийн хамгийн том нь Өвөрхангай аймгийн Хужирт суманд байрлах

“Хужирт ЖЕМ” ХХК юм. 2013 оны байдлаар тус компани 1.6 мянган тонн ус буюу 2.1 сая ширхэг савласан ус үйлдвэрлэсэн байна¹². Тус компаний савласан усны гол хэрэглэгчид нь Улаанбаатар хотын иргэд юм. Ундны усны экосистемийн үнэ цэнийг тооцохдоо, нэгдүгээрт, ОХБЦГ-тай давхцан орших 6 сумын хүн амын усны хэрэглээгээр (График 24), хоёрдугаарт “Хужирт ЖЕМ” компаний савласан ус үйлдвэрлэлийн хэмжээгээр тус тус тооцов.

График 24. ОХБЦГ-ын 6 сумын нийт хүн ам



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, Үндэсний статистикийн хороо (2014d)

¹² “Хужирт ЖЕМ” ХХК-ний ерөнхий менежер Галсаньямын Ганболдтой хийсэн ярилцлага, Өвөрхангай аймгийн Хужирт сум, 2014 оны 2-р сарын 10.


2012 онд ОХБЦГ-ын ундны усны экосистемийн үйлчилгээг хүртдэг 43 мянган хүн байсан бөгөөд бусад 4 сумтай харьцуулахад Өвөрхангай аймгийн Хархорин, Уянга сумдын иргэд хамгийн их хувийг эзэлж байна. Хүн амын тоо харьцангуй тогтвортой байсан боловч хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор 2006 оноос хойш хүн амын тоо бага зэрэг буурч байна.

ОХБЦГ-ын ундны усны экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг тооцохдоо зарим эх сурвалжаас гаргасан нэг хүний өдөрт хэрэглэх усны дундаж хэмжээг ашигласан болно. Төвийн ус түгээх шугам сүлжээнд холбогдоогүй гэр хороололд амьдардаг нэг хүн өдөрт дунджаар 6.6 литр ус бол, Төвийн ус түгээх шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдардаг нэг хүн өдөрт дунджаар 239.05 литр ус хэрэглэж байна.

ОХБЦГ-ын 6 сум нь төвийн ус түгээх шугам сүлжээнд холбогдоогүй тул нэг хүний хоногт хэрэглэх усны хэмжээ 6.63 литр буюу нэг жилд 2.42 шоо метр байхаар тооцов. Гэвч Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)-наас гаргасан мэдээллээ 2016 он гэхэд Хархорин, Уянга, Хужирт гэсэн 3 сумыг төвийн ус түгээх шугам сүлжээнд холбоно гэсэн төлөвлөгөөтэй байгаа, хэрэв энэ ажил хэрэгжвэл тэдгээр сумдын усны хэрэглээ огцом өснө. Гэхдээ энэ ажил хэрэгжээгүй байгаа тул усны хэрэглээний цаашдын хандлагыг одоогийн байдлаар (төвийн ус түгээх шугам сүлжээнд холбогдоогүй үед) авч үзсэн.

Ундны усны нийт хэрэглээг ОХБЦГ-т оршин суудаг иргэдийн усны хэрэглээ хийгээд “Хужирт ЖЕМ” ХХК-ний савласан усны хэмжээгээр тооцов.

График 25. ОХБЦГ-ын 6 сумын хүн ам болон “Хужирт ЖЕМ” компанийн нийт усны хэрэглээ (мянган шоо метр)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо

2012 онд ОХБЦГ-ын 6 сумын иргэд болон Хужирт компанийн савласан усыг хэрэглэгчид нийтдээ 105.8 мянган шоо метр ус хэрэглэжээ. Өвөрхангай аймгийн Хархорин сумын иргэд нийт ундны усны гуравны нэг орчмыг хэрэглэсэн байна (График25). Ундны усны дундаж үнийг судлаачид хэд хэдэн аргачлалаар тодорхойлсон байна. Тухайлбал, Л.Эмертон нар (2009) Туул голын экосистемийн үнэ цэнийг тооцох судалгаандаа Улаанбаатар хотын иргэдийн ундны усанд төлөхөд бэлэн

байгаа үнийг ашиглан нэг литр усны үнийг 1.36 төгрөг (0.001 доллар) гэж тооцоолжээ.

Одонцэцэг нар (2010) ус ашиглалтын төрөл бүрээр гадаргын болон гүний усны экологи-эдийн засгийн үнэ цэнийг тооцсон. Тэдний судалгаагаар Монгол улсын 29 усны ай сав газрын гадаргын ус нэг литр нь 0.35-аас 1.62 төгрөг (0.00026-0.0012 доллар); гүний ус нэг литр нь 0.6-аас 13.06 төгрөгийн (0.00044-0.0096 доллар) байна гэж тооцоолжээ¹³.

¹³ 2012 оны төгрөгийн доллартай харьцах ханшаар тооцов.



Албан ёсны эрх зүйн үндэслэлээр авч үзвэл Монгол улсын ЗГ нь байгалийн нөөцийн экологи-эдийн засгийн үнэ цэнийг тодорхойлон баталдаг. Засгийн газар Монгол орны усны экологи-эдийн засгийн үнэлгээг 2011 онд баталсан (Монгол Улсын ЗГ, 2011). Тус тогтоолын эхний хавсралтад Туул голын сав газрын газрын гүний ус нэг литр нь 0.944 төгрөг (0.0007 доллар), гадаргын ус нэг литр нь 1.06 төгрөг (0.0008 доллар) -ийг экологи-эдийн засгийн үнэ цэнэтэй байна гэж заажээ¹⁴.


Ундны усны эдийн засгийн нийт үнэ цэнийг тооцоолохдоо дараах зүйлсийг авч үзсэн болно. Үүнд:

- Нэг шоо метр усны дундаж үнийг Засгийн газраас тогтоосон усны үнэ цэнээр тооцсон.

Ж.нь: нэг шоо метр усны үнэ 1,789 төгрөг буюу 1.32 доллар (Дэлгэрэнгүйг Монгол орны ТХГНС-ний үнэ цэнийн тайлангаас үзнэ үү?).

- “Хужирт ЖЕМ” ХХК-ний савласан усны 2009-2013 оны хоорондох үнэ. Нэг савласан усны үнийн 20% нь Хужирт ЖЕМ компаний цэвэр өгөөж буюу Өвөрхангай аймгийн Хужирт сумын ус ашигласны үр өгөөж буюу үнэ цэнэ гэж үзэв¹⁵. Эндээс үндэслэн тооцоход тус компаний хэрэглэсэн нэг шоо метр усны үнэ цэнэ 146.3 мянган төгрөг (131.8 доллар) байна.
- ОХБЦГ-ын 6 сумын ундны усны хэрэглээний нийт хэмжээ
- Улаанбаатар хотод нийлүүлсэн Хужирт ЖЕМ компаний савласан нийт усны хэмжээ

График 26. ОХБЦГ-ын ундны усны нийт үнэ цэнэ (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо

Дээрх үзүүлэлтүүдийг ашиглан тооцоход ОХБЦГ-аас эх авдаг эсвэл энэ газраар дайран өнгөрдөг ундны усны эдийн засгийн үнэ цэнэ 2002 онд 189.1 сая төгрөг (170.3 мянган доллар) байсан бол 2013 онд 421.5 сая төгрөг (276.6 мянган доллар) болтлоо өсжээ. 2002-2013 оны усны үнэ цэнийн нийлбэр нь 2.8 тэрбум төгрөгтэй (2.03 сая доллар) тэнцэж байна. “Хужирт ЖЕМ” ХХК Улаанбаатар хотын зах зээлд савлагаат ус бэлтгэн нийлүүлж эхэлсэн 2009 оноос ОХБЦГ-ын ундны усны үнэ цэнэ огцом өсжээ. 2013 онд тус компанийн үйл ажиллагаа гурав дахин өргөжиж, тэдний олж буй цэвэр орлого буюу савласан ундны усны


үнэ цэнэ нь ОХБЦГ-ын ундны усны нийт цэнийн 55.8% буюу 235.2 сая төгрөгтэй тэнцэж байна. Хэрэв энэ газар нутгийг тусгай хамгаалалтанд аваагүй байсан бол ундны усны хүн амд өгч буй экосистемийн үйлчилгээний үр өгөөж ийм өндөр байхгүй байсан.

Ундны усны эдийн засгийн үнэ цэнэ өсөж байна. Гэтэл цэвэр усны экосистемийн менежментийг сайжруулах санхүүжилт болон үйл ажиллагаа байхгүй байгаагаас тус үйлчилгээний цаашдын үнэ цэнэ тогтвортой байх боломжгүй юм. Ундны усны экосистемийн үйлчилгээний менежментийн өнөөгийн байдлыг БББ хувилбараар хэрэгжиж

¹⁴ Хавсралт 1-т хавсаргасан Монгол улсын засгийн газар (2011)-ын тогтоолд гадаргын усны нэг шоо метрийн үнэ 2,651 төгрөг (1.95 доллар)-ийг Хавсралт 2-т хавсаргасан Засгийн газрын 2013 оны шинэчлэгдсэн тогтоолын дагуу хүн амын ундны усны ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр болох 0.4-өөр үржүүлэв. Үүний дараа шоо метр усны үнийг литрт шилжүүлэв. Газрын гүний усны үнийг тогтооход мөн адил аргачлалыг ашигласан бөгөөд нэг шоо метрийн итгэлцүүрийг 0.1-ээр тооцоход нэг шоо метр усны үнэ 9,440 төгрөг буюу 6.95 доллар (Монгол Улсын Засгийн Газар 2011) байна.

¹⁵ Үлдсэн 80% нь тус компанийн үйл ажиллагааны зардалтай тэнцүү гэж үзэв.

График 27. БББ болон БКХО хувилбараар тооцсон ОХБЦГ-ын ундны усны экосистемийн үйлчилгээний үнэ цэнийн хэтийн төлөв (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо

байна гэж үзэж болно.

БББ хувилбараар авч үзэхэд 2002-2013 оны хооронд ундны усны нийт үнэ цэнийн жилийн дундаж өсөлт 9% байна. БББ хувилбар энэ хэвээр үргэлжилбэл тус жилийн дундаж өсөлтийн хувь 2033 он хүртэл жил бүр 1.2%-иар буурна гэж үзлээ.

БББ хувилбараар 2025 он хүртэл богино хугацаанд ойролцоогоор 1,628 сая төгрөгийн хожоотой байх боловч 2026 оноос эхлэн 2033 он хүртэл алдагдалтай байна (БКХО хувилбартай харьцуулахад). Энэ хугацааны нийт алдагдал нь 1,653 сая төгрөгт хүрнэ. Богино хугацааны хожоо болон урт хугацааны алдагдал хоёрын зөрүү нь цэвэр алдагдал болох ба энэ нь 25.1 сая төгрөгтэй тэнцүү байна.


БКХО хувилбар ОХБЦГ-ын ундны усны удирдлага зохион байгуулалтад хэрэгжин, биелэлээ олбол ундны усны эдийн засгийн үнэ цэнэ 2033 онд 560.8 сая төгрөг (412.6 мянган доллар) болох бөгөөд энэ нь 2013 оны үнэ цэнээс 1.3 дахин их байна (График 27-д үзүүлэв).

3.6 ОЙН АЖ АХУЙ БОЛОН ОЙН НҮҮРСТӨРӨГЧ ШИНГЭЭЛТ

ОХБЦГ нь ой мод элбэгтэй ТХГН юм. ОХБЦГ-ын 6 сумаас ойн нөөцөөр хамгийн арвин сум бол Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум билээ. Тус сумын газар нутгийн бараг 75% нь ТХГН-т багтдаг.

Бат-Өлзий суманд Монгол улсын нийт ойн 0.63% (81,511 га) буюу 12.9 сая га бүхий ой мод бий. Бат-Өлзий сумын нийт газар нутгийн 31.4% нь ой модтой бөгөөд энэ нь ОХБЦГ-ын 22.3%-тай тэнцүү юм.

Газрын зураг 4: Өвөрхангай аймгийн ой модны тархац



Эх сурвалж: ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014а). ОХБЦГ-ын менежментийн төлөвлөгөө: 2014-2018.



Энэ хэсэгт экосистемийн хоёр төрлийн үйлчилгээг авч үзэж, тэдгээрийн эдийн засгийн үнэ цэнийг тооцов. Үүнд: 1) ОХБЦГ-аас бэлтгэсэн мод (экосистемийн хангамжийн үйлчилгээ), 2) ОХБЦГ-ын шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлт (экосистемийн зохицуулах үйлчилгээ).

Ой мод нь байгаль орчин-эдийн засгийн өндөр ач холбогдолтой. Байгаль орчны хувьд ой мод нь усны ай савын хагалбарын зангилаа болж усны нөөцийг хадгалах, уур амьсгалыг зохицуулах, амьтан, ургамлын амьдрах орчныг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой. Эдийн засгийн хувьд ойгоос бэлтгэсэн модыг хүмүүс өдөр тутмын амьдралдаа ашигладаг. ОХБЦГ-аас бэлтгэсэн модыг дөрвөн төрөлд ангилан үзэж болно. Үүнд: түлээ, банз, зах банз, палк (ОХБЦГ-ын Хамгаалалтын Захиргаа, 2014b).

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас 2012 онд баталсан менежментийн төлөвлөгөөнд Өвөрхангай аймгийн нутгаас 25,000-33,300 шоо метр мод бэлтгэхийг зөвшөөрчээ. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 6-р тогтоолоор 2013 онд Өвөрхангай аймгийн газар нутгаас бэлтгэх модны дээд хэмжээг 33,200 шоо метр хэмээн тогтоожээ. 2013 онд Бат-Өлзий сумаас 23,000 шоо метр мод бэлтгэснээс 20,000 шоо метрийг түлээнд, 3,000 шоо метрийг бусад зорилгоор бэлтгэжээ.

Тус суманд 2013 оны байдлаар 18-36 гишүүн бүхий 24 ойн нөхөрлөл байна. Тэд ойролцоогоор 1,500 га ой модыг хамгаалдаг. Мөн хэд хэдэн байгууллагууд тус бүсэд ой модны менежментийг сайжруулах үйл ажиллагаа явуулж байна. Гэвч, хууль бус мод огтлолт явагдсаар, ой модны хэмжээ багассаар байна. Хүснэгт 8-д ой модны БББ болон БКХО хувилбарын төлөвийг харуулав.

Хүснэгт 8. Бат-Өлзий сумын мод бэлтгэл: БББ болон БКХО хувилбар

БББ	БКХО
<ul style="list-style-type: none"> ▪ Ой модыг хамгаалах санхүүжилт, хөрөнгө оруулалт дутмаг (ой модны менежментийн бодлого тогтвортой бус); ▪ Ойн түймэр, хууль бус мод бэлтгэл, түүнтэй холбоотой бусад зардал өссөн; ▪ Газар ашиглалтын бодлого сул, хэрэгжилт тааруу тул мод бэлтгэл эрчимжиж ойн нөөц улам буурсан; ▪ Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлын сөрөг нөлөө улам нэмэгдсэн; ▪ Ойн талбай хумигдсанаар ойн нүүрстөрөгч шингээх чадвар багассан; 	<ul style="list-style-type: none"> ▪ Ой модны тогтвортой менежментийн бодлого, хэрэгжилтэд хийх хөрөнгө оруулалт хангалттай; ▪ Ой модны тогтвортой менежментийн бодлого хэрэгжин ойн түймэр, хууль бус мод бэлтгэл буурсан; ▪ Газар ашиглалтын тогтвортой бодлого хэрэгжиж, газрын төлөөх зөрчилдөөн багасаж, ойн нөөцийн хомсдол буурсан; ▪ Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүд хэрэгжсэн; ▪ Ойн талбайг ихэсгэх бодлогыг хэрэгжүүлснээр ойн нүүрстөрөгч шингээх чадвар нэмэгдсэн;

ОХБЦГ-ын ой мод нь орон нутгийн болоод улсын хөгжилд олон төрлийн экосистемийн үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- Хөрсний элэгдэл, усны хагалбарын хамгаалалт. Ой мод нь хөрсний элэгдлээс сэргийлдэг, учир нь модны үндэс нь хөрсийг тогтвортой байлган, хөрс салхинд хийсэх эсвэл усанд урсах нь багасаж элэгдэлд ордоггүй, мөн ой мод нь ус болон хөрсний чанарыг сайжруулдаг.
- Нүүрстөрөгч шингээх. ОХБЦГ-ын ой мод нь нүүрстөрөгчийг шингээж, дэлхийн дулаарлыг бууруулдаг.
- Ойн дагалт баялаг. ОХБЦГ-ын ой мод нь ойн


дагалт баялгийг бий болгодог. Хамгийн өргөн хэрэглээний ойн дагалт баялагт хушны самар, гүзээлзгэнэ гэх мэт жимс, жимсгэнэ, мөөг,эмийн ургамлууд ордог.

- Ус нөөцлөх. Ой модтой газрын доор мөнх цэвдэг байх бөгөөд энэ нь гол, горхи, худаг, усны судлууд, усны ай савуудыг тэтгэж байдаг. Энэ бүгдээс ундны усны нөөц бүрддэг.

Хамгаалалтын захиргаа (2014b) ОХБЦГ-ын нийт мод бэлтгэлийн мэдээг гаргадаг (урьд өмнө олон нийтэд зориулан хэвлэгдээгүй тоо мэдээ). Үүнийг График 28-д үзүүлэв.

Мод бэлтгэлээс олсон орлогын 40% нь зардал,

Зураг 28. ОХБЦГ-ын бэлтгэсэн нийт модны хэмжээ (2010-2013)




Эх сурвалж: ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014b)

Жич: Байгаль орчин, аялал жуулчлалын яам 2011 онд ОХБЦГ-аас мод бэлтгэх зөвшөөрөл буюу квот олгоогүй.

ТХГН-ийн тухай хуулиар тусгай хамгаалалттай газраас мод бэлтгэхийг хориглосон байдаг (Монгол Улсын Их Хурал, 1994). Гэхдээ хуулийн дагуу модны хугарсан мөчир, унасан модыг түүх зэргээр ойн цэвэрлэгээ хийж болно. Ойн цэвэрлэгээний хүрээнд байгаль орчин хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас ОХБЦГ-аас 2010 онд 900 шоо метр (Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, 2010), 2012 онд 1500 шоо метр (Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, 2012),

2013 онд 1000 шоо метр (Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, 2012) мод бэлтгэхийг зөвшөөрчээ¹⁶. ОХБЦГ-аас бэлтгэсэн мод жил ирэх бүр нэмэгдэж байгаа бөгөөд бэлтгэх зөвшөөрөгдсөн хэмжээнээс доогуур байна. Бэлтгэж буй модны дийлэнхийг түлээ болон банзанд ашигладаг. ОХБЦГ-аас бэлтгэсэн модны зах зээлийн үнийг нийт бэлтгэсэн модны хэмжээгээр үржүүлэн тооцов (График 29).

График 29. Бат-Өлзий сумын нэг м³ модны зах зээлийн үнэ (мян.төг)




Эх сурвалж: ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014b)

¹⁶ Манай орны хувьд ойн цэвэрлэгээг үнэхээр ойг унасан мөчир, модыг түүн ойг цэвэрлэх зорилгоор хийдэг гэдэг нь эргэлзээтэй. Ойн цэвэрлэгээ хийх зөвшөөрлийг мэргэжлийн компани эсвэл орон нутгийн ойн нөхөрлөлд олгодог, гэтэл авсан зөвшөөрлөө ашиглан унасан мөчир, мод түүх биш харин хууль бус мод бэлтгэл хийх явдлууд бишгүй гардаг, үүнийгээ далдлахдаа бэлтгэсэн мод нь нэг бол бүртгэлгүй, бүртгэлтэй байсан ч тоо хэмжээг нь дарагдуулах, мөн цэвэрлэгээний мод хэмээн бүртгүүлж, хэрэглээний мод, банзаа зах зээлд нийлүүлэх зэрэг асуудлууд гарсаар байна. Үүнийг Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын байгаль орчны байцаагч Буянтогтохын Янжиндуламын ярилцлагаас харж болно. Тэр 2013 онд 243 шоо метр модыг Бат-Өлзий сумаас хууль бусаар бэлтгэснийг илрүүлсэн ба энэ нь мөнгөн дүнгээр 31.7 сая төгрөг буюу 20.8 мянган доллартай тэнцүү байхаар байна (2014 оны 2-р сарын 9-ний өдөр Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд хийсэн ярилцлага). Мөн ойгоос мод бэлтгэх ганцхан боломж бол зөвхөн ойн цэвэрлэгээний зөвшөөрөл гэж тэрээр нэмж хэлсэн.



График 30. ОХБЦГ-таа бэлтгэсэн модны эдийн засгийн үнэ цэнэ (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014b)


60% нь ашиг гэж үзээд тус ашгийн хувиар ой модны экосистемийн үйлчилгээний мод бэлтгэл салбарт оруулж буй хувь нэмэр буюу цэвэр үнэ цэнийг тооцов. График 30-д 2010-2013 оны хоорондох бэлтгэсэн модны үнэ цэнийг харуулав. 2013 онд ОХБЦГ-аас бэлтгэхийг зөвшөөрсөн модны нийт үнэ 134.5 сая төгрөг (88.3 мянган доллар) байхад бэлтгэсэн модны нийт үнэ 99.5 сая төгрөг (65.3 мянган доллар) болсон байна¹⁷. 2010-2013 оны хооронд ОХБЦГ-аас бэлтгэсэн нийт модны үнэ цэнийн нийлбэр 219.2 сая төгрөг (161.3 мянган доллар) болж байна.

Ойгоос бэлтгэсэн модыг түлээ түлш бэлтгэх, байшин, барилга барих, гэрийн мод хийх зэрэг зорилгоор ашигладаг. Олгосон зөвшөөрлөөс доогуур хэмжээнд мод бэлтгэл явагдсан байгаа нь боломжийг ашиглаж чадахгүй байна гэсэн үг, өөрөөр хэлбэл мод бэлтгэлийн зохион байгуулалт, төлөвлөлт, хэрэгжилт нь БББ хувилбарын дагуу явагдаж байна гэсэн үг. Энэ нь БББ хувилбар нь

зөвшөөрөгдсөн хэмжээнээс доогуур мод бэлтгэл хийгдэж байгаа талаас нь авч үзвэл тийм ч муу хувилбар биш мэт боловч зохих хэмжээндээ хүртэл нөөцөө ашиглахгүй байгаа нь эдийн засгийн хувьд үр ашиггүй явдал. Зөвшөөрөгдсөн хэмжээг БКХО хувилбар хэрэгжсэн үед хүрэх боломжит түвшин гэж үзэв. 2012 онд БКХО хувилбараар мод бэлтгэлийн салбар 134.5 сая төгрөг (88.3 мянган доллар)-ийн үр өгөөжийн хүртэх боломжтой байсан бол БББ хувилбар хэрэгжиж байгаагийн улмаас 99.5 сая төгрөг (65.3 мянган доллар)-ийн үр өгөөжийг хүртжээ. Энэ хоёрын зөрүү нь 35 сая төгрөг бөгөөд энэ нь БББ хувилбар хэрэгжсэний алдагдлыг харуулж байна. Магадгүй бэлтгэсэн модны хэмжээг дутуу бүртгэсэн, эсвэл мод бэлтгэлд тавих хяналт шалгалт дутмаг байдлаас ч шалтгаалсан байх талтай. БББ хувилбар хэрэгжсэнээс үүдэх энэхүү алдагдлыг бууруулах боломжтой.

¹⁷ 2010, 2012, 2013 онуудад бэлтгэсэн нийт модонд төрөл тус бүрийн эзлэх хувийг тооцоход түлээ 48%, банз 33%, зах банз 5%, палк 14%-ийг тус бүр эзэлж байлаа (Тооцооллыг Хавсралт хүснэгтээс үз). Бэлтгэх модны зөвшөөрлийн хэмжээг эдгээр төрлөөр зааж өгөөгүй, тул зөвшөөрлийн хэмжээг төрлөөр гаргахдаа дээрх хувиудыг ашигласан болно. Модны хэмжээг төрөл тус бүрээр зах зээлийн үнээр нь үржүүлэн нийт үнэ цэнийг гаргасан бөгөөд түүнээс 40%-ийг зардал гэж үзэн хасч тооцоход зөвшөөрөгдсөн модны цэвэр үнэ цэнэ 2010 онд 92.5 сая төгрөг, 2012 онд 183.2 сая төгрөг, 2013 онд 134.5 сая төгрөгтэй тэнцүү байв.

График 31. ОХБЦГ-ын ой модны экосистемийн үйлчилгээний үнэ цэнийн хэтийн төлөв (Сая.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо

График 31-т харуулснаар БББ хувилбар цаашид хэрэгжсээр байвал ой модны үнэ цэнэ 2013 онд 99.5 сая төгрөг (65.3 мянган доллар) байсан бол 2033 онд 73.5 сая төгрөг (48.2 мянган доллар) болж буурах хандлагатай байна¹⁸. БКХО хувилбар хэрэгжсэнээр 2013-2033 онд бэлтгэгдэх модны хэмжээ зөвшөөрөгдсөн хэмжээнд жил бүр тогтмол 1000 шоо метр (БОНХЯ, 2012) байвал жилийн үнэ цэнэ 134.5 сая төгрөг хэвээр хадгалагдана. БББ хувилбарын алдагдал 2013-2033 онд 1.02 тэрбум төгрөгт (670.2 мянган доллар) хүрнэ.

НҮҮРСТӨРӨГЧ ШИНГЭЭЛТ

ОХБЦГ-т шинэсэн ойн талбай ихтэй учир нүүрстөрөгч шингээлтийн экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг тооцохдоо шинэсэн ойг сонгов. ОХБЦГ-ын ойн нийт талбай 151.9 мянган га ба үүний 135.9 мянган га талбайд шинэс ургадаг байна. Одоогоор Монгол орон нүүрстөрөгч шингээлтийн зах зээл буюу Carbon Trade-д оролцоогүй, манай оронд энэ зах зээл хөгжөөгүй байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. ОХБЦГ-ын шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлтийн үнэ цэнэ

	2009	2010	2011	2012	2013
Шинэсэн ойн нэг тонн нүүрстөрөгч шингээсний жилийн үнэ цэнэ (доллар/шингээсэн нүүрстөрөгч тонноор)	6.6	6.6	6.6	6.6	6.6
ОХБЦГ-ын шинэсэн ойн талбай (мян.га)	155.68	135.68	135.68	135.68	135.68
ОХБЦГ-ын шинэсэн ойн шингээсэн нүүрстөрөгчийн хэмжээ (мян.Тонн)	1027.5	895.5	895.5	895.5	895.5
Нүүрстөрөгч шингээлтийн өнөөгийн зах зээлийн үнэ (доллар/тонн)	1.5	1.5	1.5	1.5	1.5
ОХБЦГ-ын шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлтийн үнэ цэнэ (Сая доллар)	1.54	1.34	1.34	1.34	1.34
НИЙТ ҮНЭ (2009-2013 ОНЫ НИЙЛБЭР, САЯ ДОЛЛАР)	6.91				

Эх сурвалж: Зохиогчдын тооцоо, ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014б)

Жич: Нүүрстөрөгч шингээлтийн багтаамж, үнийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг ТХГНС-ний үнэ цэнийн тайлангаас үзнэ үү.

¹⁸ Монгол банкны 2013 оны долларын ханшаар тооцов 1 доллар=1523.93 төг.




ОХБЦГ-ын шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлтийн үнэ цэнэ 2013 онд 1.93 тэрбум төгрөг (1.34 сая доллар), 2009-өөс 2013 оны үнэ цэнийн нийлбэр 9.94 тэрбум төгрөг (6.91 сая доллар) байна.

2009 онд 2.22 тэрбум төгрөг (1.54 сая доллар)-тэй тэнцүү байсан ОХБЦГ-ын шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлтийн үнэ цэнэ 2013 онд 1.93 тэрбум төгрөг (1.34 сая доллар) болж буурчээ. Энэ нь шинэсэн

ойн талбай багасаж буйтай холбоотой юм. БББ хувилбарын үр дүн. БКХО хувилбарараар бол ОХБЦГ-ын шинэсэн ойн экосистемийн үйлчилгээ 2032 он хүртэл тогтвортой байх боломжтой. Гэвч БББ хувилбарыг хэрэгжүүлснээр тус дүн жил бүр 1.5%-иар буурна гэж үзэв. ОХБЦГ-ын БББ болон БКХО хувилбарын хэтийн төлөвийг График 32-т үзүүлэв.

График 32. ОХБЦГ-ын шинэсэн ойн нүүрстөрөгч шингээлтийн үнэ цэнийн хандлага (Тэрбум.төг)



Эх сурвалж: Зохиогчдын тооцоо

БББ хувилбар (ой модны менежмент сул, ой модны хэмжээ багасах, хууль бус мод бэлтгэл нэмэгдэх гэх мэт) хэрэгжсэнээр ирэх хорин

жилийн хугацаанд 11.5 тэрбум төгрөгийн (7.6 сая доллар) хохирол учирч болзошгүй байна.

4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1 ДҮГНЭЛТ

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ нь бүс нутгийн эдийн засагт томоохон хувь нэмэр оруулж байгааг харуулах нотолгоо хангалттай байна. Гэвч, БББ хувилбар цаашид энэ хэвээр хадгалагдвал мал аж ахуй гэх мэт салбар богино хугацаанд өсөх боловч, экосистемийн үйлчилгээ доройтох үед эдийн засгийн үйл ажиллагаа доголдож, эдийн засгийн салбарууд уналтанд орно.

Энэхүү судалгаанаас БББ хувилбар хэрэгжсэнээр учирч болох үнэ цэнийн алдагдлыг тооцсон, гэхдээ БКХО хувилбарыг хэрэгжүүлснээр энэ алдагдлыг бууруулах, арилгах, мөн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх бүрэн боломжтой юм.

Байгалийн аялал жуулчлалын салбар нь ОХБЦГ-тай давхцан орших сумдын эдийн засгийн хөгжилд маш чухал ач холбогдолтой. 2013 онд ОХБЦГ-т нийтдээ 43,591 жуулчин очсоноос, 17,625 нь гадаадын, 25,966 нь дотоодын жуулчид байв. ОХБЦГ-ын Хамгаалалтын захиргаа (2014b)-наас ирүүлсэн мэдээллийн дагуу 2013 онд гадаадын нэг жуулчин ОХБЦГ-т дунджаар 3 хонож, 713 мянган төгрөг (467.9 доллар) зарцуулдаг байна. Үүнд зочид буудал, хоол хүнс, нэвтрэх хураамж, үйлчилгээний хөлс, тээврийн зардал багтаж байна. Дотоодын жуулчдын хувьд тус оны байдлаар ОХБЦГ-т дунджаар 5 хонож, 475,3 мянган төгрөг (311.9 доллар)-ийн зардал гаргажээ. Дотоодын жуулчид гадаадын жуулчдаас бага зардал гаргаж байгаа ч тэдний аяллын хугацаа урт байна. Нийт орлогын 60 хувь цэвэр ашиг болж, 40 хувь нь үйл ажиллагааны зардалтай тэнцүү гэж хийсвэрлэв. БББ хувилбарын хувьд 2013 оны байдлаар ОХБЦГ-ын байгалийн аялал жуулчлалын салбарт оруулж буй хувь нэмэр буюу эдийн засгийн үнэ цэнэ 14.9 тэрбум (9.8 сая доллар) төгрөг гэж тооцов. БКХО хувилбар хэрэгжвэл, өнөөгийн БАЖ-ын салбарын экосистемийн үйлчилгээний эдийн засгийн 2033 он гэхэд 35.1 тэрбум төгрөг (23 сая доллар) болж өсөх хандлагатай байна.

ОХБЦГ дотор болон ойр орчмын мал аж ахуйн үйлдвэрлэлийн хамгийн чухал орц, нөөц бол бэлчээр, цэвэр усны экосистемийн үйлчилгээ юм. ОХБЦГ-аас бэлтгэсэн байгалийн хадлан, отрын бэлчээр нь өвөлжилт хүндэрсэн үед мал аж ахуйн салбарт маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

ОХБЦГ-ын экосистемийн үйлчилгээнээс газар тариалангийн салбарын хүртэж буй үр өгөөж буюу эдийн засгийн үнэ цэнийг бүтээгдэхүүн (хадлан, тэжээл, үр тариа, хүнсний ногоо, жимс) үйлдвэрлэл, ажлын байр бий болгосны үр өгөөжөөр тооцож үзэхэд, 2002 онд 1.4 тэрбум төгрөг (1.25 сая доллар), харин 2012 онд 6.0 тэрбум төгрөг (4.42 сая доллар) –тэй тэнцүү байна.

БББ хувилбар энэ хэвээр үргэлжилбэл экосистемийн салбарын хөгжилд оруулж буй хувь нэмэр буюу үнэ цэнэ нь урт хугацаанд тогтвортой байж чадахгүй. Хэрэв БББ хувилбар үргэлжилбэл 2023-2033 онд БКХО хувилбартай харьцуулснаар 35.9 тэрбум төгрөг (26.4 сая доллар)-ийн цэвэр алдагдал гарна. Газар тариалангийн салбар нь газар тариалан эрхлэгч өрх болон аж ахуй нэгжүүдэд ажлын байр бий болгодог. 2012 оны байдлаар, ОХБЦГ-тай давхцан оршдог 6 сумын газар тариалангийн салбарт ойролцоогоор 2,000 хүн ажиллаж байв.

Мал аж ахуй нь орон нутгийн ард иргэдийн амьжиргааны хамгийн том эх сурвалж болдог. Ямааны ноолуур үйлдвэрлэл зэрэг МАА-н үйлдвэрлэл нь тухайлбал бэлчээрийн даац хэтрэх гэх мэт байгаль орчны сөрөг нөлөөллийг дагуулж байдаг. МАА-н салбарын байгальд үзүүлж буй нөлөөллийн бодит түвшин, түүний эдийн засгийн зардлыг тооцоход нарийвчилсан судалгаа шаардлагатай. 2012 онд ОХБЦГ-ын 6 сумдад 1 сая орчим мал байв.

2012 оны байдлаар тус салбарын нийт үйлдвэрлэл 57.8 тэрбум төгрөг (42.6 сая доллар) байсан. Үүнээс зардлыг хасаж, үлдсэн цэвэр орлогыг



тооцоход 34.1 тэрбум төгрөг (25.1 сая доллар) болж байна. Гэхдээ, бэлчээрийн экосистемийн ядмаг удирдлага, зохион байгуулалт энэ хэвээр байвал мал аж ахуйн салбарын экосистемийн үнэ цэнэ урт хугацаанд тогтвортой байж чадахгүй. Тиймээс, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон эдийн засгийн үнэ цэнийг тогтвортой байлгахын тулд ТХГН-ийн экосистемийн үйлчилгээг дэмжихэд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Мал аж ахуйн салбарт ажил эрхлэлт мөн чухал байдаг. 2012 онд ОХБЦГ-ын 6 сумын мал аж ахуйн салбарт нийт 10,900 хүн ажлын байраар хангагдсан байна.

2012 оны байдлаар, ОХБЦГ-ын 6 сумын нутаг дэвсгэр дээр оршин суудаг 43 орчим мянган хүн амын ундны усны экосистемийн үйлчилгээг хүртсэн бөгөөд тэдний ихэнх нь Өвөрхангай аймгийн Хархорин болон Уянга суманд амьдардаг байна.

ОХБЦГ-аар дайран өнгөрдөг болон эх авдаг ундны усны эдийн засгийн үнэ цэнэ нь 2002 онд 189.1 сая төгрөг (170,300 доллар) байсан бол 2013 онд 421.5 сая төгрөг (276,600 доллар) болж өссөн байна. 2002-2008 оны эдийн засгийн үнийн нийлбэрийг тооцоход 2.8 тэрбум төгрөг (2.03 сая доллар) болж байна. Хужирт ЖЕМ ХХК Өвөрхангай аймгийн Хужирт суманд 2009 оноос хойш үйл ажиллагаа явуулж Улаанбаатарын зах зээлд цэвэр ус нийлүүлэх болсон. 2013 онд үйлдвэрлэсэн нийт цэвэр усны эдийн засгийн үнэ цэнэ 235.2 сая төгрөг (211.8 мянган доллар) байгаа нь тус оны ОХБЦГ-ын ундны усны нийт үнийн 55.8%-тай тэнцэж байна. Хэрэв энэ газар нутгийг тусгай хамгаалалтад аваагүй байсан бол ундны усны хүн амд өгч буй экосистемийн үйлчилгээний үр өгөөж ийм өндөр байхгүй байсан.

БББ хувилбар нь богино хугацаанд бага хэмжээний хожоо бий болгох ч 2026 оноос алдагдалд оруулж эхэлнэ, 2026-2033 оны алдагдлын нийлбэр 1.65 тэрбум төгрөг (1.22 сая доллар)-т хүрч болзошгүй.

ОХБЦГ-ын ойн экосистемийн үйлчилгээ нь мод бэлтгэлийн салбарт үр өгөөжөө өгч байдаг. 2010-2013 оны ОХБЦГ-аас бэлтгэсэн ойн модны эдийн засгийн цэвэр үнэ цэнэ нь нийт 219.2 сая төгрөг (161.3 мянган доллар) байна. Ойн модыг түлээ, түлш, барилгын материал хийх, мөн гэрийн мод үйлдвэрлэлд ашиглах замаар орон нутгийн хүмүүс үр өгөөжийг нь хүртдэг. БББ хувилбар энэ хэвээр үргэлжилбэл ойн модны аж ахуйн эдийн засгийн үнэ цэнэ 2013 онд 99.5 сая төгрөг (65.3 мянган доллар) байсан бол 2033 онд 73.5 сая төгрөг

(48.2 мянган доллар) болж буурахаар байна.

Зорилтот салбарын шинжилгээний арга зүйгээр цэвэр ус, бэлчээр, гэх мэт экосистемийн үйлчилгээг зайлшгүй ашиглан үйл ажиллагаагаа явуулдаг тухайн салбарын үйлдвэрлэлд үндэслэн үнэ цэнийг тооцогдов. Эдгээр салбарын үйлдвэрлэл нь ОХБЦГ-т БКХО хувилбарыг хэрэгжүүлснээр цаашид тогтвортой экосистемийн үйлчилгээг хүртэн үйл ажиллагаагаа амжилттай явуулах боломжтой.

Салбарын тоо мэдээний олдоц, харьцуулалт хийхэд шаардлагатай шалгуур үзүүлэлтүүд бэлэн болсон тохиолдолд, мөн энэ талын судалгааг илүү нарийвчлалтай сайн хийх аваас бидний тооцоолсон үнэ цэнэ илүү өндөр ч гарах магадлалтай. Судалгааны арга зүй нь Нийт Эдийн Засгийн Үнэлгээний арга зүй буюу Total Economic Value analysis (TEV) биш харин 3-р бүлэгт авч үзсэн Зорилтот Салбарын Шинжилгээний арга зүй буюу Targeted Scenario Analysis (TSA) дээр үндэслэгдсэн болно. Энэ арга зүйг ашиглан судалгаа хийхийн зорилго нь тухайн салбарын төрийн болон хувийн байгууллагууд эдийн засаг, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхдээ ойр орчмын ТХГН-ийн экосистемийн менежментэд оруулах хөрөнгө оруулалтыг асуудлыг хамтатган тусгахад дэмжлэг үзүүлэхэд оршино. Мөн, БОНХАЖЯ-наас ТХГН-ийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, санхүүжилтийн стратегийг дэмжих улс төрийн хүсэл сонирхлыг дээшлүүлэх нийгэм, эдийн засгийн үндэслэлийг бий болгоход оршино.

4.2 ЗӨВЛӨМЖ

Дээрх дүгнэлтэнд үндэслэн дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

- ОХБЦГ-ын экосистемийн менежментийг сайжруулахад учирч буй бодлогын алдаа, дутагдал, саад бэрхшээлийг үнэлсний үндсэн дээр ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа, сумын ЗДТГ болон орон нутгийн малчидтай хамтран бэлчээр, усны байгалийн нөөцийн тогтвортой менежментийг төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх, тухайлбал, ОХБЦГ-ын ховор амьтан, ургамлын нөхцөл байдал болон бэлчээрийн даацын үнэлгээнд тулгуурлан бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Сумын засаг даргын тамгын газрууд тогтвортой аялал жуулчлалын стратегийг хувийн хэвшил болон Монгол улсын ТХГН-ийн төрийн байгууллагуудтай хамтран

боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Тус стратегид ТХГН-т нэвтрэх хураамжийн бодлогыг сайжруулах, жуулчдын статистик тоо баримт дээр үндэслэн байгалийн үзмэр, дурсгалт газруудад очих явган хүний зам, хоноглох газрын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг асуудлыг тусгах;

- ОХБЦГ болон суурин газруудад жуулчны мэдээллийн төвүүдийг бий болгох, түүнийг санхүүжүүлэх;
- ОХБЦГ-ын цахим хуудсанд эдийн засгийн нөлөө, санхүүгийн тоо мэдээ зэрэг мэдээллийг Англи болон Монгол хэл дээр оруулах;
- Орон нутгийн санхүүжилтийн механизмуудыг бий болгох замаар аялал жуулчлалын салбарын хөгжлийг дэмжих, нөгөөтэйгүүр аялал жуулчлалын бизнес эрхлэгчдийн татвар төлөлтийг нэмэгдүүлэх;
- Хүн амын ундны усны хэрэгцээнд ашиглаж буй гол, мөрөн, булаг шандны усны чанарыг үнэлэн, усны эх үүсвэрийг хамгаалах бодлогыг тодорхойлох;
- ОХБЦГ-ын ойн нөөцийн хэмжээ болон чанарт хяналт тавих зорилгоор ойн мэдээллийн системийг бусад бүс нутаг болон ТХГН-ийн удирдлагуудтай хамтран бий болгох;
- Дээрх санал, зөвлөмжүүд нь тус тайланд авч үзсэн салбаруудад БББ хувилбарыг БКХО хувилбар болгон өөрчлөхөд шаардагдах жишиг арга хэмжээнүүдийн санал юм.

ХАВСРАЛТ 1. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд. Монгол улсын ой модтой газар нутгийн ойжилтыг нэмэгдүүлэх тухай тогтоол., Хэвлэл. No. А-145 (2012).
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд. Монгол улсын ТХГН-ийн ойжилтыг нэмэгдүүлэх тухай тогтоол., Pub. L. No. Тогтоол No: А-13 (2010).
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд. Монгол улсын дархан цаазат болон байгалийн цогцолбор газрын ой модтой газар нутгийн ойжилтыг нэмэгдүүлэх тухай тогтоол., Pub. L. No. Order No: А-293 (2012).
- Үндэсний статистикийн хороо. (2012). Улсын хөдөө аж ахуйн 2011 оны анхны тооллого. Улаанбаатар хот.
- Үндэсний статистикийн хороо. (2014а). 18-р хэсэг. Хөдөө аж ахуй. Статистикийн эмхэтгэл, 2013. Улаанбаатар хот: ҮСХ.
- Үндэсний статистикийн хороо. (2014б). ҮСХ-ны SPAN төслийн эмхэтгэн гаргаагүй мэдээлэл. Улаанбаатар хот.
- Д.Одонцэцэг, К.Ихэнбай, Л.Жанчивдорж, С.Чулуунхуяг, Б.Баяржаргал, К.Бадарч (2010). Усны экологийн ба эдийн засгийн үнэ цэнэ. Улаанбаатар хот.
- ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа. (2012). Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө 2012-2015. Монгол улс, Өвөрхангай аймаг, Хархорин сум.
- ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа. (2014а). Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын менежментийн төлөвлөгөө: 2014-2018. Монгол улс, Өвөрхангай аймаг, Хархорин сум.
- ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа. (2014б). Монгол улсын Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын ой мод, аялал жуулчлалын эмхэтгэн гаргаагүй мэдээлэл. Монгол улс, Өвөрхангай аймаг, Хархорин сум.
- Монгол Улсын Их Хурал. Монгол улсын ТХГН-ийн тухай хууль (1994).
- Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа (2014). Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын зарим статистик мэдээлэл. Монгол улс, Өвөрхангай аймаг, Хархорин сум.
- Өвөрхангай аймгийн ЗДТГ. (2013). Хархорин сумын танилцуулга. Вебсайт: <http://uvur->
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хэрэг эрхлэх газар (DEFRA, 2007) экосистемийн үйлчилгээг үнэлэх зааврын удиртгал Вебсайт: www.defra.gov.uk
- Л.Эмертон, Н.Эрдэнэсайхан, Д.В.Бастиан, Д.Цогоо, Л.Жанчивдорж, П.Сувд, А.Энхбаатар (2009). Монгол- Туулын экосистемийн эдинй засгийн үнэ цэнэ. Тогтвортой хөгжил (хуу. 1–108). Вашингтон, Д.С.
- FAO. (2014). Тогтвортой хөдөө аж ахуйн үндэс тоос хүртээлт. Ром. Вебсайт: http://www.fao.org/fileadmin/templates/agphome/documents/Biodiversity-pollination/Pollination-FolderFlyer_web.pdf
- Монгол Улсын Засгийн Газар. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол №302: Усны экологийн болон эдийн засгийн үнэ цэнийн шинэчилсэн тогтоол., Хэвлэл. No. 302/2011 (2011). Монгол улс.



khangai.mn/snews/show/id/43#.VB4dfqCaCl

- Өвөрхангай аймгийн үйлдвэр ХАА-н газар. (2014). Газар тариалангийн түүхэн товчоон: Өвөрхангай аймаг. Вебсайт: http://mofa.gov.mn/ovorhangai/index.php?option=com_content&view=article&id=89&Itemid=176
- Монгол Улсын Засгийн Газар (2013), Улсын концессийн төслийг хэрэгжүүлэх тогтоол, Pub.L.No. D. # 31
- Д.Скротер, (2005) Дэлхийн өөрчлөлтөнд нөлөөлж буй экосистемийн үйлчилгээний хүртээмж, эмзэг байдал Европт, 310 (5752): 133.
- ТЕЕВ (2012), Орон нутгийн болон бүс нутгийн бодлого, менежмент дэх экосистем хийгээд био төрөл зүйлийн эдийн засаг. Хэйди Виттмер, Хариприя Гүндимеда. Earthscan, Лондон, Вашингтон.

Төв болон зүүн европын ТХГН-ийн экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг тооцоход зориулан НҮБХХ-өөс санаачилсан судалгааны арга зүй юм. 2014 оны эхээр ЗСШ-ний арга зүйн гарын авлага хэвлэгдэн гарсан билээ. ЗСШ нь салбарын хөгжил, хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан бодлого тодорхойлогчдод тухайн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээг экосистемийн үйлчилгээтэй уялдуулахад чиглэсэн арга зүй юм.

ЗСШ-ний арга зүйгээр үйлдвэрлэлийн хэмжээ, түүний хэв шинж, экосистем, үйлдвэрлэлд ашиглагдах орц, нөөц, бүтээгдэхүүний гарц (үнэ) зэргийн эдийн засгийн харилцан хамаарлыг судалдаг. Тус арга зүйг ашиглан судалгаа хийхдээ хэд хэдэн асуултад хариулт авах боломжтой болдог. Тухайлбал: а) экосистемийн доройтол нь бүтээмж, түүнээс олох ашиг, үр өгөөжийг хэрхэн бууруулдаг вэ?; б) Экологийн доройтлоос үүдэх хохирлоос зайлсхийх байгаль орчинд ээлтэй менежментийг хэрэгжүүлснээр гарах үр өгөөж хэр хэмжээтэй байх вэ? гэх мэт. “Бизнес байгаагаараа байх (БББ)”, “Байгалийн капиталд хөрөнгө оруулах (БКХО)” гэсэн хоёр хувилбараар дээрхи хоёр асуултад хариулах бөгөөд экосистемийн үйлчилгээний салбарын хөгжилд оруулах хувь нэмэр буюу үнэ цэнийг хувилбар тус бүрээр судалдаг. Усан цахилгаан станцын салбар дахь БББ болон БКХО хувилбарын энгийн жишээг дараах хүснэгтэд үзүүлэв.

ХАВСРАЛТ 2. ЗОРИЛТОТ САЛБАРЫН ШИНЖИЛГЭЭ - ЗСШ (СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ)

Энэ судалгаанд Зорилтот Салбарын Шинжилгээний (ЗСШ) арга зүйг ашиглав. Энэ нь экосистемд-тулгуурлан үнэ цэнийг тооцдог уламжлалт үнэлгээний арга зүйтэй төсгүй. ЗСШ-ний арга зүй нь салбарт-тулгуурласан шинжилгээ бөгөөд Латин Америк, Карибын бүс нутгийн экосистемийн үйлчилгээ, саяхны жишээ дурдвал

Экосистемийн үйлчилгээний БББ хувилбарын хэв шинж: Усан цахилгаан станц буюу далангийн жишээгээр

<ul style="list-style-type: none"> ▪ Усны экосистемийн менежмент сул; ▪ Усны сав газрын төлөвлөгөө зэргийг багтаасан газар тариалангийн тогтвортой бодлого, стратеги байхгүй(бий болох шатандаа явж байгаа); ▪ Ойн нөөцийн хомсдол, ой мод багассан газар болон голын эрэг хавийн хөрсний элэгдэл нэмэгдсэн; ▪ Пестицид болон химийн бордооны замбараагүй хэрэглээ; ▪ Бэлчээрийн даац хэтрэх; ▪ Газрын гадаргын ус бохирдох; ▪ Хөрсний элэгдэл (их хэмжээний хаягдал); ▪ Газар тариаланд ашиглах тоног төхөөрөмж, арга барил нь хуучирсан; ▪ Бүс нутаг, газар ашиглалтын хил зааг тогтоох бодлого, түүний хэрэгжилтийг хангах систем ядмаг; 	<ul style="list-style-type: none"> ▪ Хуучирч, ашиглалтнаас гарсан дэд бүтэц (Ус хуримтлуулах усан сан, усны судал, ус дамжуулах шуудууны сүлжээ, усны хаалт, далан, насос, хаягдал зайлуулах систем); ▪ Тариалангийн усалгаанд ашиглаж буй усыг хэмжих, зохих төлбөр тогтоох боломж сул; ▪ Арчилгаа, тордолгоо, урсгал засвар хийх хөрөнгө хангалтгүй; ▪ ХАА-н газарт хууль бусаар барилга байгууламж барих; ▪ Газар тариалангийн үйлдвэрлэл бага хэмжээгээр явагдаж, боловсруулах үйлдвэр сул хөгжсөн; ▪ Институцийн зохион байгуулалт, хүчин чадал сул;
--	---

ҮЕ ШАТ БА МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ

Мэдээллийн олдогоос хамааран дараах үе шаттайгаар ЗСШ-ний арга зүйг ашиглан судалгаа хийж болно. Үүнд:

1. Судалгааны хамрах хүрээг тодорхойлох: ОХБЦГ гэх мэт,
2. Цуглуулсан тоо мэдээ, бусад судалгааны материалууд дээр үндэслэн БББ болон БКХО хувилбарын хэрэгжсэнээр гарах үр нөлөөллийг тодорхойлох,
3. Тооцоолол хийх үзүүлэлтүүдийг сонгох (тоо мэдээний олдоч, судалгааны оролцогч талуудын санал дээр үндэслэнэ),

4. БББ болон БКХО хувилбарыг эцэслэн тодорхойлж түүний дагуу үнэ цэнээ тооцно,
5. Авч хэрэгжүүлэх бодлого, менежментийн зөвлөмжийг боловсруулах.

ТООЦООЛОЛ ХИЙХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мэдээллийн олдогоос хамааран БББ болон БКХО хувилбарыг үнэлэхэд сонгон авсан үзүүлэлтийг ашиглана. Жишиг үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд жагсаав. Сонгон авсан бүх үзүүлэлтэд судалгаа хийх гэж буй салбар бүрт тохирохгүй байж болох бөгөөд салбарын онцлогоос хамааран ялгаатай үзүүлэлтээр тооцоолол хийдэг.

БББ болон БКХО хувилбараар үнэ цэнийг тооцох салбарын жишиг үзүүлэлтүүд

Ажлын байрны өсөлт (шууд болон шууд бусаар)
Орлогын хэмжээ ба түүний жилийн дундаж өсөлт
Улсын төсөвт оруулах хувь нэмэр(улсын төсөвт оруулж буй татварын жилийн орлого)
Ногоон татвараас төсөвт орох жилийн орлого
Гадаад валютын орлого (жил бүрийн, экспортоос олох)
Салбарын хөрөнгө оруулалт (Төрийн)
Салбарын хөрөнгө оруулалт (хувийн хэвшлийн)
Хохирол буюу алдагдлын тоо хэмжээ, мөнгөн дүн (БББ хувилбар хэрэгжсэнээс үүдэн гарах)
Болзошгүй алдагдлыг бууруулсан тоо хэмжээ, мөнгөн дүн (БКХО хувилбар хэрэгжсэнээр гарах)
Бүтээгдэхүүний цаашдын хандлага (тоо хэмжээ, үнэ)
Салбарын үйлдвэрлэлийн цаашдын хандлага (ДНБ-д эзлэх хувиар илэрхийлнэ)
Байгалийн капиталд гарах өөрчлөлт (ж.нь. Хамгаалалтанд авсан газрын хэмжээ (Га), эсвэл БКХО хувилбар хэрэгжсэнээр гарах өөрчлөлтүүд)

БББ БОЛОН БКХО ХУВИЛБАРЫГ ТОДОРХОЙЛОХ

Салбар тус бүрийн цуглуулсан тоо мэдээллийг БББ болон БКХО хувилбаруудад ангилан ялгана. Биологийн олон янз байдал болон экосистемийн үнэ цэнэ нь тогтсон нэг хугацаагаар хэмжигдэхгүй харин байгаль орчны бохирдол, доройтлыг мөн тогтвортой менежментийг хэрэгжүүлсний үр нөлөө харагдахуйц урт хугацаагаар хэмжигдэх ёстой.

БББ хувилбарт зөвхөн одоогийн явагдаж байгаа үйл ажиллагааг оруулаад зогсохгүй экосистемийн үйлчилгээг доройтуулж буй үйл ажиллагаануудыг мөн авч үздэг.

БББ хувилбараар богино хугацааны (Ж.нь: 10-аас доош жилийн) хожоо, хомсдол, доройтолд

орж буй экосистемийн үйлчилгээнд үзүүлэх сөрөг нөлөөлөл, зардал, болон эдийн засгийн үнэ цэнийг үл ойшоосноос үүдэх сөрөг үр дагаврыг авч үздэг. Харин БКХО хувилбарын хувьд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгаснаас хүртэх урт хугацааны (10-аас дээш жил) хожоо, түүний үнэ цэнийг авч үздэг. Мөн экосистемийн үйлчилгээг нэмэгдүүлэх, арчлах, нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлснээр шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц урт хугацааны үр өгөөж бий болдог. БКХО хувилбарын үед хэрэгжих үйл ажиллагаа нь зүгээр сэтгэлийн хөөрлөөр, эсвэл үндэслэлгүйгээр экосистемийн тогтвортой байдлыг



хангах үйл ажиллагаа байж болохгүй, харин аль болох амьдралд ойр, хэрэгжихүйц, зардал бага шаардсан, урт хугацаанд тухайн салбарын үр өгөөж, ашгийн хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ, бодлогууд байна. БКХО хувилбарын жишиг ажлууд гэвэл усны эх ундрагыг хамгаалах, усны хагалбарын менежмент, ойн аж ахуй, газар тариалан-бэлчээрийн менежментийг хослуулах, байгаль орчинд сөрөг нөлөөтэй уул уурхай болон мод бэлтгэлийг хөгжүүлэх, байгалийн нөөц, байгаль орчинд суурилсан орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ХАА-н органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэх мэт (Боварник нар (2010)-ын бүтээлээс авав). Авч хэрэгжүүлэх бодлого, менежментийн зөвлөмжийг боловсруулах

БББ болон БКХО гэсэн бодлогын хувилбар хоорондын ялгаа, харилцан уялдаа, үйлдвэрлэлийн хэмжээнд гарах өөрчлөлт зэргийг тооцсоны дараа, энэ хоёр бодлогын хувилбараас сонголт хийхэд нь туслах зорилгоор бодлого боловсруулагчдад үр дүнгээ танилцуулах хэрэгтэй.

Зарим шийдвэр гаргагчид судлаачдаас ЗСШ-ний судалгааны тайланд үндэслэн өгөх бэлэн санал, бодлогын хувилбаруудыг сонсохыг хүсдэг. Аль нэг бодлогын хувилбарыг сонгохоосоо өмнө шийдвэр гаргагчид хэлэлцүүлэг өрнүүлж асуудлыг тал талаас нь нухацтай ярилцах тохиолдол бас бий. Зарим тохиолдолд, бодлогын сонголт хийхдээ нэмэлт баримт нотолгоо шаардах, эсвэл нэмэлт

тоо мэдээ цуглуулж дахин судалгаа хийх ч нөхцөл үүсдэг.

Судлаач нь эдгээрийн аль ч тохиолдолд бүх оролцогч талуудад бодлогын хувилбар бүрт гарч болох эрсдэл, боломж, давуу болон сул талуудыг харьцуулахад дөхөм болохуйц судалгааныхаа үр дүнгээ, түүнд ашигласан тоо мэдээ, баримтуудыг дэлгэрэнгүй танилцуулах шаардлагатай. Аль нэг талыг баримтлах, түүнийгээ зөв гэдгийг харуулах үзүүлэлт, тоо мэдээг гол болгохоос зайлсхийж, гол хүчин зүйлс, түүнийг тоо баримтыг танилцуулах нь зүйтэй (НҮБХХ, ЗСШ)¹⁹.

Хүндрэл, бэрхшээл

Салбарын түвшинд болон БББ, БКХО хувилбараар судалгаа хийхэд дараах хүндрэл учирдаг. Үүнд:

- Тус судалгаанд эдийн засгийн болон экологийн мэргэжлийн тоо мэдээ, материал ашигладаг. ОХБЦГ-ын талаар иймэрхүү тоо мэдээний олдоц муу.
- Экосистемийн олон талт үр өгөөжийг цогцоор нь бус салбар тус бүрээр тооцдог.
- БББ, БКХО хувилбар тус бүрээр тооцоолол хийхэд шаардлагатай үндэсний болон салбарын хэмжээний тоо мэдээ нь дутмаг байдаг.
- Олдсон тоо мэдээ нь хэт хуучин байх ба зарим нь нэг сүүлийн үеийн тоо мэдээ нь тооцоолол хийхэд хангалтгүй байдаг.

¹⁹ НҮБХХ (2013) Зорилтот Салбарын Шинжилгээ

ХАВСРАЛТ 3. САЛБАРЫН ТОО МЭДЭЭ

Хавсралт 3.1 ОХБЦГ-ын 6 сумын нийт хүн ам

Аймаг	Сум	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Архангай	Хашаат	4,187	3,932	3,652	3,594	3,509	3,395	3,305	3,344	3,325	3,304	3,301	3,294
	Хотонт	5,228	4,865	4,692	4,763	4,874	4,725	4,809	4,440	4,324	4,559	4,443	4,371
Өвөрхангай	Бат-Өлзий	5,755	5,851	5,932	5,955	5,878	6,077	6,189	6,318	6,381	6,794	6,615	7,176
	Уянга	8,010	9,764	10,003	10,273	10,510	10,083	9,581	9,498	9,659	9,593	9,050	9,006
	Хархорин	13,482	13,496	12,546	13,015	13,270	12,533	12,901	12,882	12,933	12,613	12,601	12,617
	Хужирт	7,047	6,939	6,871	6,985	6,749	6,496	6,649	6,716	6,811	6,734	6,750	6,613
Нийт		43,709	44,847	43,696	44,585	44,790	43,309	43,434	43,198	43,433	43,597	42,681	43,077

Хавсралт 3.2 ОХБЦГ-ын нийт нийт хүн ам ба өрхийн тоо, 2013

Аймаг	Сум	Хүн ам	Өрхийн тоо	ОХБЦГ-ын хүн ам		ОХБЦГ-ын өрхийн тоо	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
Архангай	Хашаат	3,294	967	781	23.7%	215	22.2%
	Хотонт	4,371	1,330	988	22.6%	294	22.1%
Өвөрхангай	Бат-Өлзий	7,176	2,312	1,323	18.4%	415	17.9%
	Уянга	9,006	2,668	250	2.8%	56	2.1%
	Хархорин	12,617	3,628	1615	12.8%	474	13.1%
	Хужирт	6,613	1,920	2189	33.1%	649	33.8%
Нийт		43,077	12,825	7,146	16.7%	2,103	16.4%

Эх сурвалж: ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа (2014);

Хавсралт 3.3 ОХБЦГ-ын газар нутаг ба 6 сумын нийт газар нутагт эзлэх хэмжээ

Аймаг	Сум	Сумын нийт газар нутгийн хэмжээ (КМ ²)	ОХБЦГ-ын сумдын нийт газар нутагт эзлэх хэмжээ	
			Газар нутаг (КМ ²)	Эзлэх хувь (%)
Архангай	Хашаат	2,587.0	310.0	12.0%
	Хотонт	2,346.9	318.4	13.6%
Өвөрхангай	Бат-Өлзий	2,592.4	1,952.1	75.3%
	Уянга	3,046.5	120.1*	3.9%
	Хархорин	2,305.3	837.8	36.3%
	Хужирт	1,664.1	107.0	6.4%
Нийт		14,542.2	3,645.38	25.1%

Эх сурвалж: ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа

Уянга сумын 115 км.кв газар нутгийг Хүйсийн Найман Нуурын байгалийн дурсгалт газар, үлдсэн 5.1 км.кв газар нутгийг ОХБЦГ эзэлнэ. Өөрөөр хэлбэл ОХБЦГ-т Хүйсийн Найман Нуур


байгалийн дурсгалт газар багтдаг. Найман нуурыг оруулахгүйгээр ОХБЦГ-ын нийт хэмжээ 3,530.38 км.кв юм.

ОХБЦГ-ын 6 сумаас хураасан хадлан (тонн)

Аймаг	Сум	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Архангай	Хашаат	4,955.8	4,452.3	4,497.5	4,675.5	5,753.7	5,582.7	6,365.6	6,432.5	9,191.9	7,741.1	8,114.1
	Хотонт	4,542.9	4,379.5	4,205.3	4,848.3	5,823.8	5,577.4	6,382.6	6,174.6	4,387.1	5,235.2	5,891.1
Өвөрхангай	Бат-Өлзий	542.0	3,600.0	3,774.0	2,300.0	4,948.2	2,520.0	5,600.0	655.0	5,000.0	3,200.0	3,195.0
	Уянга	524.3	673.0	418.7	382.0	411.4	200.0	4,798.1	41.2	3,800.0	2,500.0	2,162.3
	Хархорин	2,510.0	3,930.0	2,267.0	1,500.0	5,300.0	3,450.0	4,800.0	3,850.0	3,000.0	4,100.0	3,895.4
	Хужирт	1,600.0	1,992.0	2,112.0	2,210.0	2,550.0	1,243.0	2,110.0	1,850.0	3,200.0	2,150.0	2,617.1
Нийт		14,675.0	19,026.8	17,274.4	15,915.7	24,787.1	18,573.2	30,056.3	19,003.3	28,579.0	24,926.4	25,874.9
Нийт (2002–2012)		238,692.1										



ОХБЦГ-ын 6 сумаас авсан хадлан (мянган тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014


ОХБЦГ-аас хураасан хадлан (Тонн)

	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Хадлан (Тонн)	2900	2800	3000	3100	4000	4220	4560

ОХБЦГ-ын 6 сумаас авсан хадлангийн зах зээлийн нийт үнэ цэнэ (Сая.төг)

Аймаг	Сум	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Архангай	Хашаат	461.4	415.3	438.9	474.0	577.3	561.8	850.0	869.8	1,401.8	1,455.5	1,586.4
	Хотонт	423.0	408.5	410.4	491.5	584.3	561.2	852.2	834.9	669.0	984.3	1,151.8
Өвөрхангай	Бат-Өлзий	50.5	335.8	368.3	233.2	496.5	253.6	747.7	88.6	762.5	601.7	624.7
	Уянга	48.8	62.8	40.9	38.7	41.3	20.1	640.7	5.6	579.5	470.0	422.8
	Хархорин	233.7	366.6	221.2	152.1	531.8	347.2	640.9	520.6	457.5	770.9	761.6
	Хужирт	149.0	185.8	206.1	224.0	255.9	125.1	281.7	250.1	488.0	404.2	511.7
НИЙТ		1,366.3	1,774.7	1,685.7	1,613.5	2,487.0	1,868.9	4,013.3	2,569.5	4,358.3	4,686.6	5,059.0
НИЙТ (2002-2012)		31,482.8										

Нэг тонн өвсний үнэ (мян.төг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2014);
Жич: 6 сумын дундаж үнэ, Зохиогчдын тооцоо

ОХБЦГ-ын 6 сумын малын тэжээл үйлдвэрлэл(Тонн)

Аймаг	Сум	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Архангай	Хашаат	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Хотонт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Өвөрхангай	Бат-Өлзий	59.5	51.5	56.0	30.0	81.8	155.7	601.9	21.5	60.0	180.0	78.8
	Уянга	133.4	213.8	220.5	90.0	219.1	80.0	959.6	79.7	110.0	200.0	76.4
	Хархорин	252.0	310.0	238.9	140.0	250.0	260.0	275.0	291.7	240.0	300.0	361.3
	Хужирт	137.0	169.2	198.0	201.0	260.0	228.0	322.0	250.0	315.0	250.0	267
Нийт		581.9	744.5	713.4	461.0	810.9	723.7	2,158.5	642.9	725.0	930.0	783.5
НИЙТ (2002-2012)		9,275.3										

ОХБЦГ-ын 6 сумын малын тэжээлийн бүтээгдэхүүн (Тонн)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014

ОХБЦГ-ын 6 сумын малын тэжээлийн бүтээгдэхүүний зах зээлийн нийт үнэ (Сая.төг)

Аймаг	Сум	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Архангай	Хашаат	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
	Хотонт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өвөрхангай	Бат-Өлзий	5.92	5.61	6.44	3.67	9.63	19.55	78.85	2.86	7.80	24.05	10.60
	Уянга	13.27	23.28	25.36	11.00	25.81	10.04	125.71	10.61	14.30	26.73	10.28
	Хархорин	25.06	33.76	27.47	17.11	29.44	32.64	36.03	38.85	31.20	40.09	48.61
	Хужирт	13.62	18.42	22.77	24.57	30.62	28.63	42.18	33.30	40.95	33.41	35.92
Нийт		57.87	81.07	82.04	56.34	95.51	90.86	282.76	85.62	94.25	124.28	105.41
НИЙТ (2002-2012)		1,156.0										




Нэг тонн малын тэжээлийн үнэ (мян.Төг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014;
Жич: 6 сумын дундаж үнэ, Зохиогчдын тооцоо

Нэг тонн улаан буудайн үнэ (мян.Төг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014;
Жич: 6 сумын дундаж үнэ, Зохиогчдын тооцоо

ОХБЦГ-ын 6 сумын улаан буудайн бүтээгдэхүүн (Тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014

ОХБЦГ-ын 6 сумын улаан буудайн бүтээгдэхүүн (Тонн)

Аймаг	Сум	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Архангай	Хашаат	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Хотонт	20.0	20.0	0.0	0.0	0.0	0.0	60.0	50.0	90.0	0.0	0.0
Өвөрхангай	Бат-Өлзий	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Уянга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Хархорин	1,919.9	1,661.9	2,937.4	1,227.2	1,776.1	1,075.4	797.3	1,528.1	2,367.6	3,141.8	5,328.7
	Хужирт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт		1,939.9	1,681.9	2,937.4	1,227.2	1,776.1	1,075.4	857.3	1,578.1	2,457.6	3,141.8	5,328.7
НИЙТ (2002-2012)		24,001.5										

ОХБЦГ-ын 6 сумын улаан буудайн бүтээгдэхүүний зах зээлийн нийт үнэ (Сая.төг)

Аймаг	Сум	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Архангай	Хашаат	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Хотонт	2.1	2.1	0.0	0.0	0.0	0.0	16.9	13.9	32.9	0.0	0.0
Өвөрхангай	Бат-Өлзий	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Уянга	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	Хархорин	198.9	174.5	308.4	196.4	305.5	214.6	224.0	425.3	864.7	1,079.4	1,657.6
	Хужирт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт		201.0	176.6	308.4	196.4	305.5	214.6	240.9	439.2	897.6	1,079.4	1,657.6
НИЙТ (2002-2012)		5,717.0										

ОХБЦГ-ын 6 сумын хүнсний ногоо тариалалт (Тонн)


Хүнсний ногоо	Сум*	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Төмс	Хашаат (АР)	20.1	93.5	1.5	5.9	50.9	35.0	5.6	7.0	2.5	35.7	40.0
	Хотонт (АР)	33.0	102.0	75.0	54.5	55.5	81.0	70.0	55.0	8.0	14.5	70.0
	Бат-Өлзий (ӨВ)	5.3	10.0	31.5	20.4	8.5	42.4	18.0	50.4	90.0	130.0	131.0
	Уянга (ӨВ)	90.4	66.0	92.0	22.0	5.6	8.4	46.0	66.4	66.6	60.0	90.0
	Хархорин (ӨВ)	466.0	520.0	338.0	407.0	51.0	540.0	715.0	700.0	697.5	727.0	926.6
	Хужирт (ӨВ)	19.1	73.8	142.8	110.0	6.5	46.0	21.3	47.4	45.0	90.0	76.0
	Нийт	633.9	865.3	680.8	619.8	178.0	752.8	875.9	926.2	909.6	1,057.3	1,333.6
НИЙТ (2002-2012)		8,833.1										



Лууван	Хашаат (АР)	2.3	5.5	0.7	2.3	-	10.0	0.6	0.5	0.5	-	5.0
	Хотонт (АР)	8.0	4.0	1.4	7.0	9.0	5.0	6.0	1.5	1.0	8.0	15.0
	Бат-Өлзий (ӨВ)	1.4	1.3	1.0	1.5	1.2	1.1	2.0	1.6	3.4	3.4	4.9
	Уянга (ӨВ)	-	4.0	1.7	-	3.8	2.9	2.9	9.0	3.9	-	7.0
	Хархорин (ӨВ)	45.0	32.0	33.0	2.2	40.9	45.0	55.0	101.0	125.0	59.5	190.5
	Хужирт (ӨВ)	18.0	0.2	4.0	-	2.6	0.9	1.8	9.0	4.8	3.7	14.0
	Нийт	74.7	47.0	41.8	13.0	57.5	64.9	68.3	122.6	138.6	74.6	236.4
	НИЙТ (2002-2012)	939.4										
Сонгино	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	2.0	3.0	-	-	3.0	4.0	-	-	-	5.0	6.0
	Бат-Өлзий (ӨВ)	0.2	-	-	1.0	-	0.9	1.5	5.0	5.5	3.9	4.9
	Уянга (ӨВ)	-	-	0.7	-	1.8	1.9	7.5	2.0	2.6	-	3.5
	Хархорин (ӨВ)	14.9	17.0	11.0	0.9	18.0	22.0	23.0	42.0	5.4	28.0	0.6
	Хужирт (ӨВ)	0.2	2.7	13.0	-	0.6	0.7	5.0	2.5	1.7	2.5	0.8
	Нийт	17.3	22.7	24.7	1.9	23.4	29.5	37.0	51.5	15.2	39.4	15.8
	НИЙТ (2002-2012)	278.4										
Байцаа	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	4.0	2.0	1.0	3.0	4.0	4.0	2.0	1.0	-	6.0	7.0
	Бат-Өлзий (ӨВ)	-	-	-	0.8	0.8	4.1	2.5	4.2	4.3	4.2	5.1
	Уянга (ӨВ)	3.2	-	1.9	4.9	-	2.9	4.0	12.0	14.0	-	1.1
	Хархорин (ӨВ)	74.0	61.0	45.0	0.6	54.0	87.0	79.0	41.0	55.0	41.0	93.6
	Хужирт (ӨВ)	0.2	2.9	18.0	-	3.8	-	4.8	4.9	2.9	2.5	4.0
	Нийт	81.4	65.9	65.9	9.3	62.6	98.0	92.3	63.1	76.2	53.7	110.8
	НИЙТ (2002-2012)	779.2										
Хүрэн манжин	Хашаат (АР)	2.3	5.0	0.7	3.0	-	11.0	0.9	0.8	0.5	-	4.0
	Хотонт (АР)	6.0	5.0	1.0	11.0	12.0	1.0	3.0	4.0	2.5	5.0	27.0
	Бат-Өлзий (ӨВ)	2.0	1.1	2.5	3.2	0.6	6.7	2.7	3.7	1.2	1.3	5.2
	Уянга (ӨВ)	0.7	7.0	3.1	3.9	2.1	4.5	4.5	1.2	1.4	-	7.5
	Хархорин (ӨВ)	92.0	85.0	61.0	3.1	100.0	101.0	129.0	162.0	151.0	102.0	160.4
	Хужирт (ӨВ)	19.5	8.9	29.8	-	2.5	2.0	6.4	3.1	2.8	5.4	10.2
	Нийт	122.5	112.0	98.1	24.2	117.2	126.2	146.5	174.8	159.4	113.7	214.3
	НИЙТ (2002-2012)	1,408.9										
Өргөст хэмх	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бат-Өлзий (ӨВ)	-	-	-	0.1	-	1.2	-	3.1	3.5	6.1	6.5
	Уянга (ӨВ)	-	-	-	-	-	-	0.7	-	-	1.5	0.3
	Хархорин (ӨВ)	21.0	7.9	4.5	-	18.5	18.0	18.0	9.0	13.0	67.0	56.6
	Хужирт (ӨВ)	0.5	1.3	12.0	-	-	0.5	-	2.0	2.9	-	1.4
	Нийт	21.5	9.2	16.5	0.1	18.5	19.7	18.7	14.1	19.4	74.6	64.8
	НИЙТ (2002-2012)	277.1										
Нийт хүнсний ногоо		951.33	1,122.06	927.81	668.25	457.13	1,091.10	1,238.70	1,352.30	1,318.40	1,413.26	1,975.74
НИЙТ хүнсний ногоо (2002-2012)		12,516.08										


*АР: Архангай аймаг, ӨВ: Өвөрхангай аймаг

ОХБЦГ-ын 6 сумын хүнсний ногоо тариалалт (Тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014

Нэг кг хүнсний ногооны үнэ (Төг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014;

Жич: 6 сумын дундаж үнэ, Зохиогчдын тооцоо



ОХБЦГ-ын 6 сумын хүнсний ногооны зах зээлийн нийт үнэ (Сая.төг)

Хүнсний ногоо	Сум*	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Төмс	Хашаат (АР)	6.8	27.1	0.4	1.9	20.9	16.5	3.9	5.2	1.7	29.3	29.6
	Хотонт(АР)	10.6	27.5	20.3	16.4	21.6	36.5	46.9	39.6	5.2	11.6	50.4
	Бат-Өлзий (ӨВ)	1.9	3.2	10.1	7.1	3.7	21.2	12.6	37.8	67.5	110.5	104.8
	Уянга (ӨВ)	31.6	19.8	29.4	7.7	2.5	4.2	32.2	49.8	50.0	51.0	76.5
	Хархорин (ӨВ)	163.1	145.6	101.4	142.5	19.4	270.0	464.8	490.0	523.1	581.6	741.3
	Хужирт (ӨВ)	6.7	22.1	42.8	38.5	2.6	23.0	14.9	35.6	33.8	76.5	64.6
	Нийт	220.7	245.4	204.4	214.0	70.7	371.3	575.2	657.9	681.2	860.5	1,067.2
	НИЙТ (2002-2012)	5,168.6										
Лууван	Хашаат(АР)	1.2	2.4	0.3	1.1	-	5.3	0.5	0.4	0.4	-	4.9
	Хотонт (АР)	4.0	1.7	0.6	3.2	4.3	2.6	4.7	1.3	0.7	8.4	14.3
	Бат-Өлзий (ӨВ)	0.5	0.6	0.5	0.8	0.7	0.7	1.6	1.4	2.7	3.7	4.9
	Уянга (ӨВ)	-	2.0	0.9	-	2.1	1.7	2.3	8.1	3.3	-	7.0
	Хархорин (ӨВ)	15.8	16.0	16.5	1.1	22.5	27.0	44.0	90.9	100.0	65.5	190.5
	Хужирт (ӨВ)	6.3	0.1	2.0	-	1.4	0.5	1.4	8.1	4.1	4.1	14.0
	Нийт	27.7	22.8	20.8	6.1	31.0	37.8	54.5	110.3	111.2	81.7	235.5
	НИЙТ (2002-2012)	739.4										
Сонгино	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	0.8	1.3	-	-	1.4	2.3	-	-	-	4.7	5.7
	Бат-Өлзий (ӨВ)	0.1	-	-	0.5	-	0.6	1.2	4.3	6.1	3.9	4.9
	Уянга (ӨВ)	-	-	0.4	-	1.0	1.2	6.0	1.7	2.9	-	3.5
	Хархорин (ӨВ)	6.0	7.7	5.5	0.5	9.9	14.3	18.4	35.7	5.9	28.0	0.6
	Хужирт (ӨВ)	0.1	1.4	7.2	-	0.3	0.5	4.0	2.1	1.9	2.5	0.8
	Нийт	6.9	10.3	13.0	1.0	12.6	18.9	29.6	43.8	16.7	39.1	15.5
	НИЙТ (2002-2012)	207.5										
Байцаа	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	1.7	0.9	0.5	1.4	2.0	2.1	1.5	0.8	-	5.7	6.4
	Бат-Өлзий (ӨВ)	-	-	-	0.4	0.5	2.5	2.0	3.4	4.3	4.2	5.1
	Уянга (ӨВ)	1.3	-	1.0	2.5	-	1.7	3.2	9.6	14.0	-	1.1
	Хархорин (ӨВ)	29.6	30.5	24.8	0.3	31.3	52.2	63.2	32.8	55.0	41.0	93.6
	Хужирт (ӨВ)	0.1	1.5	9.9	-	2.2	-	3.8	3.9	2.9	2.5	4.0
	Нийт	32.7	32.8	36.2	4.5	36.0	58.5	73.8	50.4	76.2	53.4	110.3
	НИЙТ (2002-2012)	564.7										
Хүрэн манжин	Хашаат (АР)	0.9	2.0	0.3	1.9	-	5.9	0.8	0.7	0.4	-	3.9
	Хотонт (АР)	2.2	1.9	0.4	6.6	6.0	0.5	2.5	3.4	2.1	4.7	25.7
	Бат-Өлзий (ӨВ)	0.7	0.5	1.3	2.1	0.3	4.0	2.4	3.3	1.1	1.3	5.2
	Уянга (ӨВ)	0.2	2.8	1.6	2.5	1.2	2.7	4.1	1.1	1.3	-	7.5
	Хархорин (ӨВ)	32.2	34.0	27.5	1.9	50.0	60.6	116.1	145.8	135.9	102.0	160.4
	Хужирт (ӨВ)	6.8	3.6	14.9	-	1.4	1.2	5.8	2.8	2.5	5.4	10.2
	Нийт	43.1	44.6	45.9	14.9	58.9	75.0	131.6	157.1	143.3	113.4	212.8
	НИЙТ (2002-2012)	1,040.5										


Хүнсний ногоо	Сум*	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Өргөст хэмх	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бат-Өлзий (ӨВ)	-	-	-	0.1	-	1.4	-	5.4	8.0	16.4	18.1
	Уянга (ӨВ)	-	-	-	-	-	-	1.0	-	-	4.0	0.8
	Хархорин (ӨВ)	19.4	7.4	4.3	-	19.4	21.1	25.9	15.8	29.7	180.2	157.7
	Хужирт (ӨВ)	0.5	1.2	11.3	-	-	0.6	-	3.5	6.6	-	3.9
	Нийт	19.9	8.6	15.6	0.1	19.4	23.1	27.0	24.7	44.4	200.6	180.5
	НИЙТ (2002-2012)	563.8										
Нийт хүнсний ногоо	350.92	364.51	335.92	240.68	228.67	584.48	891.62	1,044.18	1,073.03	1,348.70	1,821.82	
НИЙТ хүнсний ногоо (2002-2012)	8,284.54											

ОХБЦГ-ын 6 сумын жимсний зах зээлийн нийт үнэ (Сая.төг)

Жимс	Сум*	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Улаан лооль	Хашаат(АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бат-Өлзий (ӨВ)	-	-	-	0.1	-	-	-	-	-	-	-
	Уянга (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	-	1.2	0.3
	Хархорин (ӨВ)	-	1.2	3.4	-	12.1	12.9	13.0	-	8.3	34.9	47.6
	Хужирт (ӨВ)	-	-	18.9	-	-	0.6	-	2.0	-	-	1.3
	Нийт	-	1.2	22.3	0.1	12.1	13.5	13.0	2.0	8.3	36.1	49.2
	НИЙТ (2002-2012)	157.8										
Лууван	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бат-Өлзий (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Уянга (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хархорин (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	8.5	1.0	3.0
	Хужирт (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Нийт	-	-	-	-	-	-	-	-	8.5	1.0	3.0
	НИЙТ (2002-2012)	12.5										
Нийт жимс	-	1.20	22.30	0.10	12.10	13.50	13.00	2.00	16.80	37.10	52.19	
НИЙТ жимс (2002-2012)	170.29											



ОХБЦГ-ын 6 сумын жимс, жимсгэнэ (Тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014;

Нэг кг жимсний үнэ (Төг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2014;
Жич: ОХБЦГ-ын 6 сумын дундаж үнэ, Зохиогчдын тооцоо

ОХБЦГ-ын 6 сумын жимс, жимсгэний зах зээлийн нийт үнэ (Сая.төг)

Жимс	Сум*	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Улаан лооль	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бат-Өлзий (ӨВ)	-	-	-	0.1	-	-	-	-	-	-	-
	Уянга (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	-	3.0	0.8
	Хархорин (ӨВ)	-	0.9	2.5	-	12.1	13.6	16.7	-	17.4	86.9	139.0
	Хужирт (ӨВ)	-	-	13.9	-	-	0.6	-	3.1	-	-	3.8
	Нийт	-	0.9	16.4	0.1	12.1	14.2	16.7	3.1	17.4	89.9	143.6
	НИЙТ (2002-2012)	314.4										
Чацаргана	Хашаат (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хотонт (АР)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Бат-Өлзий (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Уянга (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хархорин (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	26.2	4.4	14.6
	Хужирт (ӨВ)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Нийт	-	-	-	-	-	-	-	-	26.2	4.4	14.6
	НИЙТ (2002-2012)	45.2										
Нийт жимс		-	0.86	16.40	0.10	12.12	14.18	16.73	3.06	43.59	94.23	158.29
НИЙТ жимс (2002-2012)		359.55										

Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын орлого


Мөнгөний нэгж	Цалингийн төрөл	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
мян.Төг	Жилийн дундаж орлого	466.8	501.6	631.2	585.6	688.8	840	1550.4	1917.6	2163.6	2305.2	2732.4
	7 сарын дундаж орлого	272.3	292.6	368.2	341.6	401.8	490	904.4	1118.6	1262.1	1344.7	1593.9
	Сарын дундаж орлого	38.9	41.8	52.6	48.8	57.4	70	129.2	159.8	180.3	192.1	227.7
доллар	Жилийн дундаж орлого	420.4	437.5	532.5	485.9	583.9	717.4	1329.9	1334.2	1606	1821.5	2010.2
	7 сарын дундаж орлого	245.2	255.2	310.6	283.4	340.6	418.5	775.8	778.3	936.9	1062.6	1172.6
	Сарын дундаж орлого	35	36.5	44.4	40.5	48.7	59.8	110.8	111.2	133.8	151.8	167.5
Валютын ханш	1 доллар=1356 Төг	1110.3	1146.5	1185.3	1205.3	1179.7	1171	1165.8	1437.2	1347.2	1265.5	1359.2




ОХБЦГ-ын 6 сумын хүн амын усны хэрэглээ (мянган шоо метр)

Сум	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013
Хашаат (АР)	10.1	9.5	8.8	8.7	8.5	8.2	8.0	8.1	8.0	8.0	8.0	8.0
Хотонт (АР)	12.6	11.8	11.3	11.5	11.8	11.4	11.6	10.7	10.5	11.0	10.7	10.6
Бат-Өлзий (ӨВ)	13.9	14.1	14.3	14.4	14.2	14.7	15.0	15.3	15.4	16.4	16.0	17.4
Уянга (ӨВ)	19.4	23.6	24.2	24.8	25.4	24.4	23.2	23.0	23.4	23.2	21.9	21.8
Хархорин (ӨВ)	32.6	32.6	30.3	31.5	32.1	30.3	31.2	31.2	31.3	30.5	30.5	30.5
Хужирт (ӨВ)	17.0	16.8	16.6	16.9	16.3	15.7	16.1	16.2	16.5	16.3	16.3	16.0
Савлагаат ус	0	0	0	0	0	0	0	0.8	0.8	0.8	0.8	1.6
Нийт	105.7	108.4	105.7	107.8	108.3	104.7	105.0	105.3	105.8	106.2	104.2	105.8
Нийт (2002-2012)	1,273.0											

ОХБЦГ-ын 6 сумын мал аж ахуйн салбарт нийт ажиллагсдын тоо




6 сумын нийт малын тоо (мян.толгой)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо(2014), Зохиогчдын тооцоо


ОХБЦГ-ын 6 сумын мах, махан бүтээгдэхүүний нийт хэмжээ (Мян.Тонн)



ОХБЦГ-ын 6 сумын сүү, сүүн бүтээгдэхүүний нийт хэмжээ (Мян.Тонн)




ОХБЦГ-ын 6 сумын ноолууран бүтээгдэхүүний нийт хэмжээ







ОХБЦГ-ын 6 сумын ноосон бүтээгдэхүүний нийт хэмжээ




ОХБЦГ-ын 6 сумын боловсруулсан арьс, ширний нийт хэмжээ (мянган ширхэг)



ОХБЦГ-ын 6 сумын мал аж ахуйн салбарт ажиллагсдын тоо



ОХБЦГ-ын 6 сумын мал аж ахуйн салбарт ажиллагсдын нийт орлого (Тэрбум.төг)




Ой модны тоо мэдээ

ОХБЦГ-аас бэлтгэсэн модны нийт үнэ (Сая.төг)

	2010	2011	2012	2013
Түлээ	10.8	0	39.7	42.6
Банз	9.8	0	26.3	34.5
Зах банз	0.2	0	0.6	0.5
Палк	8.6	0	23.8	21.8
Нийт	29.4	0	90.3	99.5
НИЙТ (2010-2013)	219.2			

2010-2013 оны хооронд ОХБЦГ-аас бэлтгэсэн модны хэмжээ, /төрлөөр/



Эх сурвалж: ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа, 2014б Зохиогчдын тооцоо
Мод бэлтгэх зөвшөөрөгдсөн хэмжээ /төрлөөр/, (шоо метр)



	2010	2011	2012	2013
Түлээ	429.6	-	716.0	477.3
Банз	298.1	-	496.9	331.3
Зах банз	45.4	-	75.6	50.4
Палк	126.9	-	211.5	141.0
Нийт	900	-	1,500	1000

Эх сурвалж: ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа, 2014б Зохиогчдын тооцоо

ОХБЦГ-ын мод бэлтгэх зөвшөөрөгдсөн дээд хэмжээний нийт үнэ (Сая.төг)

	2010	2011	2012	2013
Түлээ	38.7	-	77.3	57.3
Банз	30.4	-	59.0	42.6
Зах банз	0.5	-	1.1	0.8
Палк	22.8	-	45.7	33.8
Нийт	92.5	-	183.2	134.5

Мод бэлтгэх зөвшөөрөгдсөн хэмжээ /төрлөөр/, (шоо метр)

	2010	2011	2012	2013
Түлээ	429.6	-	716.0	477.3
Банз	298.1	-	496.9	331.3
Зах банз	45.4	-	75.6	50.4
Палк	126.9	-	211.5	141.0
Нийт	900	-	1,500	1000

ОХБЦГ-аас мод бэлтгэх зөвшөөрөгдсөн дээд хэмжээний нийт үнэ цэнэ (сая төгрөг)

	2010	2011	2012	2013
Түлээ	38.7	-	77.3	57.3
Банз	30.4	-	59.0	42.6
Зах банз	0.5	-	1.1	0.8
Палк	22.8	-	45.7	33.8
Нийт	92.5	-	183.2	134.5

Эх сурвалж: ОХБЦГ-ын хамгаалалтын захиргаа, 2014б, Зохиогчдын тооцоо